


ТӨЛБӨР ТООЦООНЫ
СИСТЕМИЙН ХОРОО



**ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН
СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ
ЕРӨНХИЙ УДИРДАМЖ**

2006 ОНЫ 1 ДҮГЭЭР САР
(Орчуулсан: 2010 оны 9 дүгээр сар)



ОЛОН УЛСЫН ТӨЛБӨР ТООЦООНЫ БАНК

Энэхүү нийтлэлийн хувийг дараах хаягаар авч болно:

Bank for International Settlements
Press & Communications
CH-4002 Basel, Switzerland

E-mail: publications@bis.org

Fax: +41 61 280 9100 and +41 61 280 8100

Энэхүү нийтлэл нь ОУТТБ-ны цахим хуудсанд (www.bis.org) бий.

© Олон улсын төлбөр тооцооны банк 2006. Бүх эрх хамгаалагдсан. Эх сурвалжийг дурьдсан нөхцөлд товч ишлэлийг хуулбарлаж, эсвэл орчуулж болно.

ISBN 92-9131-702-0 (print)
ISBN 92-9197-702-0 (online)

Өмнөх үг

Үндэсний төлбөрийн системийг үр дүнтэй хөгжүүлэх цор ганц жор байдаггүй боловч төлбөрийн системийн шинэтгэл хийж буй орнуудын өмнө тулгардаг асуудлууд ихэвчлэн адилхан байдаг. Жишээлбэл, энэхүү үйл ажиллагаанд хэн оролцох вэ, хэн санаачлах вэ? Ямар чиглэлд нэн тэргүүнд хөрөнгө оруулах вэ, төлбөрийн системийг бүхэлд нь ойлгосны үндсэн дээр сонголт хийгдсэн үү? Өөр ямар дэд бүтэц шаардлагатай байна вэ, тэдгээрийг дэмжих эрх зүйн орчин ямар байх ёстой вэ?

Энэхүү тайлан нь Томасо Падао-Шиоппагаар удирдуулж байсан Төлбөр тооцооны системийн хороо (ТТСХ) –ны санаачлагаар эхэлсэн бөгөөд үндэсний төлбөр тооцооны системд хийх шинэтгэлийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд тус болох, зөвлөгөө өгөх зорилготой. Төлбөрийн системийг хөгжүүлэх нь цогц процесс бөгөөд технологид тулгуурласан биш хэрэгцээнд тулгуурласан байх ёстой гэж энэхүү тайланд онцлон тэмдэглэсэн. Төлбөрийн системийн шинэтгэл нь банкны систем, төлбөрийн үйлчилгээний эрх зүйн орчин болон төлбөрийн дэд бүтцийн паралел хөгжлөөс шалтгаалах бөгөөд банкны салбар, тохируулагч агентлагууд болон бусад холбогдох этгээдүүдийн хамтын хүчин чармайлт шаардлагатай. Энэхүү тайлан 14 удирдамж болон төлбөрийн системийн хөгжлийн талаарх дагалдах тайлбар материалаас бүрдэнэ. Мөн энэхүү тайлан нь практик жишээ, асуудал, хэрэгжүүлэх боломжтой аргуудыг багтаасан удирдамж бүхий хэрэгжүүлэлтийн хэсгийг агуулна. Энэхүү тайланг бэлтгэхдээ ТТСХ нь дэлхийн хөгжсөн болон хөгжиж буй орнуудын төв банкуудын мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсгийн ажлын үр дүнг ашигласан болно.

Энэхүү тайлангийн анхны хувилбар нь 2005 оны 5 дугаар сард нийтлэгдсэн ба дэлхийн олон орны төв банк, санхүүгийн байгууллагуудын төлбөрийн мэргэжилтнүүдтэй хийсэн бүсийн хэлэлцүүлгээр хэлэлцэгдсэн болно. Ерөнхийдөө, өргөн хүрээтэй хэлэлцүүлгээр энэхүү тайлангийн цар хүрээ, мөн чанар нь үндэсний төлбөрийн системдээ шинэтгэл хийн, хөгжүүлж буй улс орнуудад тустай гэдэг нь нотлогдсон юм.

ТТСХ нь энэхүү тайланг дэмжсэн Томасо Падао-Шиоппа, энэхүү тайланг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан Дэлхийн банкны гишүүд, дарга, Канад төв банкны Шон О'Коннор, ОУТТБ-ны ТТСХ-ны нарийн бичгийн газарт гүнээ талархсанаа илэрхийлье.

Тимоти Ф Гайднер,

Төлбөр тооцооны системийн хорооны дарга

ГАРЧИГ

Өмнөх үг	iii
1 Нийтлэг үндэслэл.....	1
1.1 Оршил ба ерөнхий танилцуулга.....	1
1.2 Төлбөрийн системийг хөгжүүлэх ерөнхий удирдамж.....	5
1.3 Энэхүү тайлангийн зохион байгуулалт.....	11
2 Үндэсний төлбөрийн системийн хөгжил	11
2.1 Мөнгө ба үндэсний төлбөрийн систем.....	11
2.2 Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх үйл явц.....	13
2.2.1 Үндэсний төлбөрийн системийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлс.....	13
2.2.2 Үндэсний төлбөрийн системийн шинэтгэлийг хийх үүсгэл санаачлага	16
2.2.3 Үндэсний төлбөрийн системийн хөгжлийн хандлага	17
2.2.4 Үндэсний төлбөрийн системийн хөгжлийн асуудлууд.....	18
3 Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх ерөнхий удирдамж.....	20
3.1 Банкны систем ба үндэсний төлбөрийн системийн хөгжил	20
Удирдамж 1. Төв банк гол үүрэгтэй байх:	20
Удирдамж 2. Банкны системийн тогтвортой байдлыг хангах:	28
3.2 Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх төлөвлөлт	34
Удирдамж 3. Үндэсний төлбөрийн системийг цогцоор нь авч үзэх:	34
Удирдамж 4. Эрэлт хэрэгцээг голчлон анхаарах:.....	37
Удирдамж 5. Эн тэргүүний зорилтуудыг тодорхойлох:.....	40
Удирдамж 6. Гол нь хэрэгжүүлэх:	47
3.3 Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх	54
Удирдамж 7. Зах зээлийн хөгжлийг дэмжих:	54
Удирдамж 8. Холбогдох бүх талуудыг хамруулах:	62
Удирдамж 9. Хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хамтран ажиллах:	65
Удирдамж 10. Хууль эрх зүйн тодорхой байдлыг хангах:	68
3.4 Үндэсний төлбөрийн системийн дэд бүтцийг хөгжүүлэх нь:.....	76
Удирдамж 11. Бага дүнтэй төлбөрийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх:	78

Удирдамж 12. Их дүнтэй төлбөрийн системийг хөгжүүлэх:	83
Удирдамж 13. Төлбөрийн болон үнэт цаасны системийг хослуулан хөгжүүлэх:.....	88
Удирдамж 14. Бага дүнтэй, их дүнтэй болон үнэт цаасны системийн төлбөр тооцоог зохицуулах:	93
Хавсралтууд.....	100
Хавсралт 1: Удирдамжийн жагсаалт.....	101
Хавсралт 2: Тодорхой жишээ – Шри Ланка.....	103
Хавсралт 3: Хэтийн төлвийг үнэлэх бүрэлдэхүүн хэсгүүд.....	108
Хавсралт 4: Хууль зүйн тогтолцоо ба төлбөрийн хуулиудын загвар.....	112
Хавсралт 5: Нэр томъёоны тайлбар.....	118
Хавсралт 6: Ажлын хэсгийн гишүүд.....	129

1 Нийтлэг үндэслэл

1.1 Оршил ба ерөнхий танилцуулга

Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх нь тасралтгүй үргэлжлэх процесс юм. Улс орон бүхэнд байнга л төлбөрийн системийнх нь ямар нэгэн хэсэгт нь өөрчлөлт шинэтгэл хийгдэж байдаг. Сүүлийн жилүүдэд дэлхий даяар үндэсний төлбөрийн системийн суурь шинэтгэл хурдацтай хийгдэж байна. Гэсэн хэдий ч ижил төрлийн шинэтгэл нь улс орнуудад өөр өөрөөр хэрэгжиж байна. Төлбөрийн системийн шинэтгэл бүрийн хүлээгдэж байсан ашиг тус, үр дүн тэр бүр гардаггүй ба нэлээд олон төлөвлөгдсөн шинэтгэлүүдийн дуусах хугацаа урьдаас таамаглаж байгаагүйгээр сунжирч байсан.

Төлбөрийн системийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилт нь тухайн шинэтгэлийн цогц байдал, түүнийг хэрэгжүүлэх янз бүрийн арга замаас шалтгаалсан хүнд ажил юм. Үндэсний төлбөрийн системдээ шинэтгэл хийх санаачлагыг дэмжигч эрх мэдэл бүхий байгууллагууд ихэвчлэн бусад орнууд, ТТСХ, ОУВС, Дэлхийн банк болон бусад олон улсын санхүүгийн байгууллагуудаас системд хийх шинэтгэлийг хэрхэн зөв төлөвлөх, хэрэгжүүлэх талаар мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа хүсдэг. Энэхүү тайлангийн зорилго нь үндэсний төлбөрийн системээ цаашид хөгжүүлэхэд удирдамж өгч туслах явдал юм.

Энэхүү тайлан нь гол төлөв төв банкууд, тэдгээрээс бусад холбогдох этгээдүүд, ялангуяа банкны систем болон банкны системийг хөгжүүлэх эрх бүхий байгууллагуудтай харилцах харилцаанд чиглэгдсэн. Гэсэн хэдий ч үндэсний төлбөрийн системийн хөгжил нь хамтын процесс учир энэ нь бүхий л улсын болон хувийн секторын холбогдох этгээдүүдэд хамааралтай. Энэхүү тайланг бэлтгэхдээ дэлхийн хөгжсөн болон хөгжиж буй орнуудын төв банкууд болон Дэлхийн банк, ОУВС-ийн мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсгийн өмнөх ажил, туршлагад үндэслэсэн болно. Өмнөх ажлуудын ихэнх нь тодорхой хэрэгсэл, горим, банк хоорондын шилжүүлгийн механизм зэрэгт анхаарч байсан бол энэхүү тайлан нь үндэсний төлбөрийн системийг бүхэлд нь авч үзсэн юм. Энэхүү тайлан дахь үндэсний төлбөрийн систем нь мөнгөн төлбөрийг төв банкны болон арилжааны банкны мөнгө хэлбэрээр үүсгэх, шилжүүлэх зорилготой санхүүгийн систем дэх бүхий л эрх зүйн орчин, дэд бүтцийн зохицуулалтуудаас бүрдэнэ.

Тус тайланд дурьдсан удирдамж нь үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхэд хийх зүйлсийн жагсаалт ч биш, нарийвчилсан заавар ч биш юм. Бүх улс орны бүхий л онцгой хэрэгцээг хангаж чадах цорын ганц концепци байдаггүй. Харин эдгээр удирдамж нь үндэсний төлбөрийн системийн шинэтгэл, ялангуяа гол бүтцийн шинэтгэлийг эхлэх үед авч үзэх үндэсний төлбөрийн системийн ерөнхий бүрэлдэхүүн хэсгүүдэд чиглэгдсэн болно. Түүнчлэн эдгээр удирдамж нь нэг улс орны доторхи болон нэгдсэн валют бүхий бүс нутгийн төлбөрийн системийн хөгжилд хамаарна. Үр ашигтай, найдвартай кросс-валютын хил дамнасан төлбөрийг гүйцэтгэхэд шаардлагатай үндэсний төлбөрийн системийн тодорхой төлвийг хөгжүүлэх талаар энд авч үзээгүй.

Төв банкууд ба төлбөрийн системийн хөгжил

Үр ашигтай, найдвартай үндэсний төлбөрийн системийн хөгжил нь төв банкны мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдал болон ерөнхий эдийн засгийг хөгжүүлэх сонирхолд хамааралтай. Тиймээс төв банкууд төлбөрийн системийн мөнгөний эрэлтэд үзүүлж буй нөлөөлөл, мөнгөний бодлогын ажил гүйлгээний нөлөө болон онц хамааралтай санхүүгийн зах зээлүүдийн үр ашигтай байдал болон тогтвортой байдлыг үнэлэхийн тулд төлбөрийн системийн хөгжилд мониторинг хийдэг.

Үндэсний төлбөрийн систем нь нийт санхүүгийн болон эдийн засгийн үйл ажиллагаанд нөлөөлөхийн тулд мөнгөний зах зээлийн ажил гүйлгээг ашиглан мөнгөний бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй. Мөн төлбөрийн системд гарч буй өөрчлөлт шинэчлэлт нь эдийн засаг дахь нийт мөнгөний эрэлтэд нөлөөлж болох мөнгөний эргэлтийн хурд болон түүнийг урьдаас тооцоолох боломжид нөлөөлдөг. Гэсэн хэдий ч мөнгөн хөрөнгийг шилжүүлэх, төлбөр тооцоог үр ашигтай гүйцэтгэх зорилгоор санхүүгийн байгууллагуудыг нэг дор холбосноос үндэсний төлбөрийн систем нь санхүүгийн байгууллагууд болон зах зээлүүдийн хооронд санхүүгийн эрсдлийг дамжуулах суваг болдог. Үндэсний төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай байдлыг хангахын тулд төв банкууд энэхүү сувгаар санхүүгийн халдвар тараах боломжийг хязгаарлахыг эрмэлзэж байдаг.

Төв банк үндэсний төлбөрийн системийн хөгжилд голлох байр суурийг эзэлдэг. Тэрээр гол төлөв төлбөрийн системд янз бүрийн чухал үүргүүдийг гүйцэтгэдэг. Төв банк бол суурь төлбөрийн системийн оператор, хянагч, төлбөрийн үйлчилгээний хэрэглэгч, төлбөрийн системийн шинэтгэлийг өдөөгч юм. Иймээс төв банк нь тухайн эдийн засаг болон санхүүгийн систем дэх төлбөрийн системд өргөн хүрээтэй үүрэг гүйцэтгэж, тодорхой төлбөрийн системийн хувьд арвин туршлага хуримтлуулсан байдаг. Тиймээс төв банкууд төлбөрийн болон бусад санхүүгийн системийн бодлогын талаар санал зөвлөмж гаргах, хувийн секторын байгууллагуудын хамтаар төлбөрийн системийн шинэтгэлийг санаачлах, түүнийг дэмжих, түүнд хувь нэмэр оруулахад үр нөлөөтэй өдөөгчийн үүргийг гүйцэтгэж чадна.

Үндэсний төлбөрийн системийн бүрэлдэхүүн хэсгүүд

Энэхүү тайланд дурьдагдаж буй үндэсний төлбөрийн систем гэдэг нь утгын хувьд тодорхой нэг төлбөрийн системийн дэд бүтцээс илүү өргөн хүрээг хамарна. Энэ нь тухайн улс орны төв банкны болон арилжааны банкны өр төлбөр хэлбэрээр мөнгөн төлбөрийг үүсгэх, шилжүүлэх процесс, эрх зүйн орчин болон дэд бүтцийн зохион байгуулалтыг бүхэлд нь хамаарна. Бүхий л системд бэлэн мөнгө төлбөрийн чухал хэлбэр хэвээр байгаа хэдий ч энэхүү тайлан нь арилжааны банк болон төв банкны данснаас хийгдэх бэлэн бус төлбөрт чиглэгдсэн. Үндэсний төлбөрийн системийн гол бүрэлдэхүүн хэсэгт дараахь зүйлс орно. Үүнд:

- Төлбөр төлөгчийн данснаас хүлээн авагчийн дансанд мөнгөн хөрөнгийг шилжүүлэхэд хэрэглэгддэг төлбөрийн хэрэгслүүд;
- Төлбөрийн хэрэгслийг дамжуулж, үр дүнг тооцох, төлбөрийн мэдээллийг боловсруулж, дамжуулах, төлбөр төлөгчийн болон хүлээн авагчийн банк, санхүүгийн байгууллагын хооронд шилжүүлэх дэд бүтэц;
- Төлбөрийн данс нээж, төлбөрийн хэрэгсэл гаргадаг, харилцагч иргэд, байгууллагуудад төлбөрийн үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн байгууллагууд, тэдгээр санхүүгийн байгууллагуудад төлбөр тооцоо, клирингийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд;
- Янз бүрийн төлбөрийн хэрэгслийн гаргах, хүлээн авах, төлбөрийн үйлчилгээний шимтгэл хураамжтай холбоотой гэрээ хэлэлцээр, дүрэм зэрэг зах зээлийн зохицуулалтууд;
- Хууль тогтоох, шүүх, тохируулагч байгууллагаас төлбөр шилжүүлэх үйл ажиллагаа, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын талаар гаргасан хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам.

Төлбөрийн дэд бүтцэд тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй (төв нь гадаадад байршдаг байж болно) төлбөрийн гүйлгээ, клиринг, төлбөр тооцооны бүхий л системийг хамааруулна. Зарим дэд бүтэц нь төлбөрийн хэрэгслийн тусгай төрөлд зориулагдсан байдаг. Эрх зүйн орчин нь төлбөрийн үйлчилгээний янз бүрийн төрлүүдийн зах зээлийн зохицуулалтууд, хэрэглэгчдэд төлбөрийн үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн болон бусад байгууллагуудаас бүрдэнэ. Мөн түүнд бизнесийн байгууллагуудад зориулсан хууль эрх зүйн болон зохицуулалтын орчин, холбогдох байгууллагуудын хоорондын харилцааг зохицуулах механизм багтана. Эрх зүйн орчны бүтэц нь дэд бүтцийн зохицуулалт болон холбогдох байгууллагуудыг үйл ажиллагааны хувьд үндэсний төлбөр тооцооны системд холбож өгдөг.

Үндэсний төлбөрийн системийн шинэтгэлийн хүчин зүйлс, өдөөгчид, хандлага

Үндэсний төлбөрийн системийн шинэтгэлийн санаачлага нь системийн хэмжээний найдвартай, үр ашигтай байдлыг сайжруулахад чиглэгдэнэ. Эдгээр санаачлагын амжилт, түүнээс улбаалсан тухайн улс орны үндэсний төлбөрийн системийн хөгжлийн мөн чанарт орчны, эдийн засгийн, санхүүгийн болон төрийн бодлогын хүчин зүйлс нөлөөлдөг. Үндэсний төлбөрийн системийн шинэтгэлийг амжилттай хийхийн тулд түүнийг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ эдгээр хүчин зүйлсийн холбогдох нөлөөллийг авч үзэх шаардлагатай. Эдгээр нь төлбөрийн системийн шинэтгэлийг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллага тус бүрийн зохистой оролцоог хангахад чухал ач холбогдолтой.

Үндэсний төлбөрийн системийн шинэтгэлийг гол төлөв дараахь хүчин зүйлс өдөөдөг. Үүнд: (i) зардал багатай төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг нэвтрүүлэх шинэ боломж, шаардлагыг бий болгосон санхүүгийн ба санхүүгийн бус салбарт гарч буй шинэ дэвшил; (ii) санхүүгийн тогтвортой байдал болон төлбөрийн системийн эрсдэлд ихээхэн анхаарал хандуулах байдал; (iii) олон улсын холбогдох стандартад нийцэх бодлогын шийдвэр, шинэтгэл хийх гадны болон дотоодын шахалт; (iv) зарим тохиолдолд тухайн улс орны бүс нутгийн болон дэлхий дахины худалдаа, санхүүгийн зах зээлд оролцохтой холбоотой улс төр, эдийн засгийн бодлого шийдвэр.

Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх сүүлийн үеийн хандлага нь гол төлөв дараахь зорилгыг агуулж байна. Үүнд:

- Төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөх;
- Зардал хэмнэлтийг сайжруулах, ялангуяа үйл ажиллагааны зардал, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай хөрөнгийн ашиглалт, түүнийг олж авахтай холбоотой зардлыг хэмнэх;
- Банкны үйл ажиллагаа, төлбөр тооцоо, үнэт цаасны төлбөр тооцооны дэд бүтцийн найдвартай байдал, тэдгээрийн харилцан ажиллах боломжийг сайжруулах;
- Төлбөрийн дэд бүтэц дэх хууль зүйн, санхүүгийн болон системийн эрсдэлийг авч үзэх;
- Үндэсний төлбөрийн системийн зохистой хяналт, зохицуулалтыг бий болгох;
- Төлбөрийн үйлчилгээний зах зээлийн үр ашигтай, тогтвортой байдлыг хангах.

Харин үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх явц нь тэр бүр тасралтгүй, үр ашигтай явагдаж чаддаггүйг туршлага харуулж байна. Үр дүнтэй хөгжүүлэхэд тулгарч буй нийтлэг асуудлууд нь:

- Үндэсний төлбөрийн системийн далайцыг хангалттай мэдэхгүй байх, зорилт, манлайлал хязгаарлагдмал байх;
- Шинэ тутам үүсч буй төлбөрийн хэрэгцээ, системийн боломж чадварын талаар мэдээлэл хомс байх;
- Хангалттай хэмжээнд зөвлөлдөөгүйгээс холбогдох байгууллагууд идэвхтэй оролцохгүй байх;
- Эх үүсвэр хангалтгүй байх;

- Үндэсний төлбөрийн системийг тасралтгүй хөгжүүлэх явцад хууль зүйн, зохицуулалтын, төрийн бодлого болон зах зээлийн саад бэрхшээл учрах зэрэг юм.

1.2 Төлбөрийн системийг хөгжүүлэх ерөнхий удирдамж

Энэхүү тайланг бэлтгэхэд дэлхийн янз бүрийн улс орны сүүлийн үеийн шинэтгэлийн хөтөлбөртэй холбоотой туршлага, болсон явдал дээр хийсэн дүгнэлтүүд нь үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхэд анхаарах сургамжийг тодорхойлоход тусаллаа. Эдгээр сургамжуудыг үндэсний төлбөрийн системийг үр дүнтэй хөгжүүлэх ерөнхий удирдамж хэлбэрээр илэрхийллээ. Төлбөрийн системийг хөгжүүлэхэд дараах дөрвөн чиглэлийг тусгасан 14 удирдамжийг бүлэглэн гаргалаа. Үүнд: (i) банкны салбарын үүрэг (төв банкныг оролцуулан); (ii) үр дүнтэй төлөвлөлт, төслийн хэрэгжилт; (iii) төлбөрийн системийн шинэтгэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг хөгжүүлэх; (iv) тухайн улс орны эдийн засагт шинээр үүсч буй хэрэгцээ шаардлагыг хангах найдвартай, үр ашигтай төлбөрийн дэд бүтцийг бий болгох. Зарим бүрэлдэхүүн хэсэг нь цаг үргэлж шинэтгэл, өөрчлөлтөд орж байдаг учир эдгээр удирдамж нь тухайн улс орны үндэсний төлбөрийн системийн хөгжлийн өнөөгийн түвшин ямар байгаагаас үл хамааран бүхий л улс оронд тустай зүйл байх болно.

Хэдийгээр эдгээр удирдамжууд бүгдээрээ бүх улс оронд бүх тохиолдолд адилхан ач холбогдолтой байж чадахгүй ч, эдгээрийг бүхэлд нь цогцоор нь авч үзэх хэрэгтэй. Тухайн нэг цаг мөчид үндэсний төлбөрийн системийн аль нэг тодорхой чиглэлийг хөгжүүлэхэд анхаарч болно. Гэсэн хэдий ч тийм ирээдүйд цогцоор нь хөгжүүлэх шаардлага гарч болох төлбөрийн системийн бусад чиглэлийг мөн анхаарч үзэх хэрэгтэй.

Энэхүү тайлан дахь ерөнхий удирдамж нь өндөр түвшинд хамаарна. Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх нь тухайн улс орны онцлог, орчин, эдийн засаг, санхүү, төрийн бодлогын хүчин зүйлсээс ихээхэн хамааралтай тул тухайн нэг удирдамжийг улс орон бүр өөрийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх шаардлагатай. Өндөр түвшний удирдамжууд нь ерөнхийдөө үр дүнтэй боловч, улс орон бүрд тохирсон “шилдэг стандарт” байх шаардлагагүй байж болно. Гэсэн хэдий ч, өндөр түвшний удирдамжийг хэрхэн тухайн тодорхой нэг шинэтгэлд хэрэгжүүлж болохыг харуулахын тулд энэхүү тайланд удирдамж тус бүрд зориулж шинжилгээний хэрэгслүүд, хэрэгжүүлэх аргачлалыг багтаалаа.

Эдгээр удирдамжийн хураангуйг дор сийрүүлсэн бөгөөд удирдамжуудын гарчгийг Хавсралт 1-д үзүүлээ.

А. Банкны систем

Удирдамж 1. Төв банк гол үүрэгтэй байх: *үндэсний валютын тогтвортой байдлыг хангах ерөнхий үүргийнхээ дагуу төв банк нь үр ашигтай төлбөрийн хэрэгсэл болох мөнгөний хэрэглээг хөгжүүлэхэд гол үүргийг гүйцэтгэнэ.*

Хураангуй: Төлбөрийн системд төв банкны шууд гүйцэтгэх үүрэг нь улс орон бүрд харилцан адилгүй байдаг. Харин үндэсний төлбөрийн системийн үйл ажиллагаа нь үндэсний валютын чанарын чухал элемент болдог тул төв банк түүнд онцгой анхаарах шаардлагатай болдог. Энэ шалтгаан нь төлбөрийн системийг хөгжүүлэхэд төв банк гол байр суурийг эзэлж, янз бүрийн үүргийг гүйцэтгэхэд хүргэдэг. Үүнд: оператор, өдөөгч, хянагч ба хэрэглэгчийн үүрэг багтана. Төлбөрийн системийн үйл ажиллагааг төв банкны шийдвэр гаргах түвшинд өндөр зэрэглэлтэйгээр авч үзэх ёстой бөгөөд дэд ерөнхийлөгч гэх мэт гүйцэтгэх түвшний удирдлага хариуцаж, үүрэг хариуцлага нь тодорхой заагдсан ажилтнуудыг ажиллуулах ёстой.

Удирдамж 2. Банкны системийн тогтвортой байдлыг хангах: *банкууд болон бусад ижил төстэй санхүүгийн байгууллагуудаас эцсийн хэрэглэгчид үзүүлж буй төлбөрийн данс, хэрэгсэл, үйлчилгээ нь хоорондоо өрсөлдөх хэдий ч системийнхээ хувьд үргэлж хамтран ажиллах шаардлагатай.*

Хураангуй: Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхэд нийт мөнгөний дүнд эзлэх банкин дахь мөнгөний хэмжээ нэмэгддэг учир банкууд болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч бусад санхүүгийн байгууллагуудын гүйцэтгэх үүргийг өргөжүүлдэг. Үндэсний төлбөрийн системийн шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд эдгээр байгууллагууд төлбөрийн үйлчилгээ үзүүлдэг өөрийн дотоодын системээ мөн хөгжүүлэх хэрэгтэй. Түүнчлэн, банк, санхүүгийн байгууллагууд харилцагчдад үзүүлж буй төлбөрийн үйлчилгээгээрээ өрсөлдөх ёстой боловч төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг зохистой хөгжүүлэхийн тулд хамтарч ажиллах ёстой. Системийн эрсдэл ба үр ашигтай байдлыг анхааралдаа авахын тулд төв банк эдгээр шинэтгэлийг дэмжих ёстой.

Б. Төлөвлөлт

Удирдамж 3. Үндэсний төлбөрийн системийг цогцоор нь авч үзэх: *төлөвлөлт нь үндэсний төлбөрийн системийн гол бүрэлдэхүүн хэсгүүд болон түүний хөгжилд нөлөөлөх үндсэн хүчин зүйлүүдийн бүх талын ойлголтод суурилсан байх ёстой.*

Хураангуй: Үндэсний төлбөрийн системийн бүх талын ойлголт нь түүний технологитой холбоотой ойлголтоор хязгаарлагдах ёсгүй. Үндэсний төлбөрийн системийг авч үзэхдээ мөнгөний эргэлтийг бий болгож буй байгууллагууд, дүрэм, журам, сүлжээ, хэрэгслүүдийг цогцоор нь авч үзэх хэрэгтэй. Төв банк, банкууд нь найдвартай, үр ашигтай үндэсний

төлбөрийн системийн бүрэлдэхүүн хэсгүүд болон түүний хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийг өргөн утгаар нь авч үзэх ёстой. Гол бүрэлдэхүүн хэсгүүд нь төлбөрийн хэрэгслүүд-шилжүүлэг хийх гол зохицуулалт, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн клиринг, үр дүнгийн тооцоо, хууль эрх зүйн орчин, зах зээлийн зохицуулалт, зохицуулалтын механизм зэрэг гол эрх зүйн орчны зохицуулалтуудаас бүрдэнэ. Янз бүрийн төлбөрийн хэрэгслүүд, үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлөх хүчин зүйлсэд орчны, эдийн засгийн, санхүүгийн болон төрийн бодлогын хүчин зүйлс хамаарах ба мөн үндэсний төлбөрийн системийн бүх талын ойлголтод ч чухал хамааралтай.

Удирдамж 4. Эрэлт хэрэгцээг голчлон анхаарах: *үндэсний төлбөрийн системийн бүх хэрэглэгчдийн төлбөрийн хэрэгцээ, эдийн засгийн боломжийг тодорхойлж, тэдгээрт нийцсэн үйл ажиллагаа явуулна.*

Хураангуй: Үр ашигтай, тогтвортой төлбөрийн системийг хөгжүүлэх үйл явц нь харилцагч, Засгийн газар, санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагууд зэрэг хэрэглэгчдийн төлбөрийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээн дээр тулгуурласан байх ёстой. Эдгээр хэрэгцээг хангахад шаардлагатай байгаа төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг үр ашигтай байдлаар нийлүүлэхэд өнөөгийн эдийн засгийн боломж, мэргэжлийн боловсон хүчин хүрэлцэх эсэхийг авч үзнэ. Үүнд мэдлэгтэй, ур чадвартай хүний нөөцийг бэлтгэх нь харилцаа холбоо, тээврийн систем зэрэг эдийн засгийн бодит дэд бүтцийг хөгжүүлэхтэй эн зэрэгцэхүйц чухал ач холбогдолтой. Системийн гол оролцогч, хэрэглэгчдийн ашиг сонирхол, гүйцэтгэх үүргийг тодорхойлох нь мөн чухал байдаг.

Удирдамж 5. Эн тэргүүний зорилтуудыг тодорхойлох: *үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх эн тэргүүний зорилтуудыг тодорхойлж, стратегийн арга барилаар төлөвлөнө.*

Хураангуй: Стратегийн арга барил гэдэг нь үндэсний төлбөрийн системийн хэтийн зорилтыг тодорхойлж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, эдийн засгийн боломжид үндэслэн тэдгээрт дараалал тогтоох явдал юм. Стратеги төлөвлөлт нь гол оролцогчдын үүргийг тодорхойлж, системийн бүхий л холбогдох бүрэлдэхүүн хэсгүүдийн бүтэц, зохион байгуулалтыг төлөвлөх явдал. Төлөвлөлтийг хийхдээ өнөөгийн системийн ямар бүрэлдэхүүн хэсгүүд нь ирээдүйн хөгжлийн гарц болох вэ гэдгийг авч үзэх хэрэгтэй. Төлбөрийн системийн хөгжил нь тухайн төлбөрийн болон санхүүгийн системийг өөрчлөн байгуулж байдаг хувьсан өөрчлөгдөх процесс юм.

Удирдамж 6. Гол нь хэрэгжүүлэх: *стратеги төлөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэх баталгаатай байх ёстой.*

Хураангуй: Төлбөрийн системийн шинэтгэлийн амжилт нь стратеги төлөвлөлтийн үр дүнтэй хэрэгжилтээс онцгой хамаарна. Төлөвлөгөөний хамгийн чухал хэсэг нь хэрэгжилт гэж үздэг. Үр дүнтэй хэрэгжилт гэдэгт холбогдох талуудын оролцоо, төслийн зохистой удирдлага, тодорхой бичигдсэн үнэлгээ, тайлангууд, чухал үе шатууд, эх үүсвэрийн зохистой удирдлага, санхүүжилтын стратеги, суурилуулалт, ашиглалтын тодорхой

стратеги хамаарна. Төв банк, банкны систем болон бусад холбогдох байгууллагуудын удирдах түвшний хүмүүсийн хүчтэй дэмжлэг, туслалцаагүйгээр хэрэгжилт үр дүнд хүрч чадахгүй.

В. Эрх зүйн орчин

Удирдамж 7. Зах зээлийн хөгжлийг дэмжих: *төлбөрийн үйлчилгээний зах зээлийн зохицуулалтыг бэхжүүлэх, өргөжүүлэх нь үндэсний төлбөрийн системийн хөгжлийн гол хэсэг болдог.*

Хураангуй: Төлбөрийн үйлчилгээнд үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгч, зардал хамаардаг тул үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхэд мөн түүний зах зээлийн зохицуулалтын хөгжил хамаарна. Өрсөлдөөнт зах зээлийн зохицуулалт нь хэрэглэгчдэд хүргэж буй өнөөгийн болон шинэ төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээний үр ашигтай, найдвартай ажиллагаа, хүргэлт, үнэлгээнд чухал ач холбогдолтой. Гэсэн хэдий ч, зах зээлийн зохицуулалтын хөгжил нь стандарт тогтоох, төлбөрийн сүлжээ байгуулах, үйл ажиллагааны журам тогтоох, эрсдлийг удирдах зэрэг чиглэлд зах зээлийн оролцогчдыг хамтран ажиллах шаардлагыг бий болгодог. Түүнчлэн төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээний зах зээлийн зарим зохицуулалт нь тэдгээрийн хамтын ажиллагаа ба өрсөлдөөний хэм хэмжээгээр тодорхойлогддог.

Удирдамж 8. Холбогдох бүх талуудыг хамруулах: *үндэсний төлбөрийн системийн холбогдох бүх талууд бүтээлчээр зөвлөлдөн хэлэлцэхийг дэмжих.*

Хураангуй: Холбогдох талуудын үр дүнтэй хамтын ажиллагаанд зөвлөлдөн хэлэлцэх явдал туйлын чухал. Энэ нь системийн янз бүрийн холбогдох талуудын эрэлт хэрэгцээ, боломж, ашиг сонирхлыг ойлгоход тусална. Мэдээлэл солилцох, зөвлөлдөх, хамтран ажиллахад холбогдох талууд оролцох нь төлбөрийн системд шинэтгэл хийж, бодлого тодорхойлоход төв банк ба бусад гол оролцогчдыг хооронд нь зохицуулж өгдөг талтай. Ийм оролцоо нь мэргэжлийн болон үйл ажиллагааны стандарт тогтоох зэрэг хамтын ажиллагаанд чухлаар шаардагддаг. Зохион байгуулалттай зөвлөгөөн нь төлбөрийн системийг хөгжүүлэх, зах зээлийн үр дүнтэй зохицуулалтыг бий болгох, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чухал шаардлагатай итгэлцэл, оролцоог бий болгодог.

Удирдамж 9. Хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хамтран ажиллах: *төв банкны зүгээс төлбөрийн системийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай болдог.*

Хураангуй: Төв банк үндэсний төлбөрийн системд хяналт тавьдаг. Энэ үйл ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэхийн тулд үндэсний төлбөрийн системийн хөгжилд нөлөөлөхүйц бусад эрх мэдэл бүхий байгууллагатай хамтран ажиллах нь чухал байдаг. Төв банк нь хяналт, бодлогоо хэрэгжүүлэхдээ үндэсний төлбөрийн системд хийгдэж буй гол шинэчлэлүүдийг системийн найдвартай, үр ашигтай байдалд үзүүлэх нөлөөллийн талаас нь үнэлж, хяналт

тавьдаг. Түүнээс гадна банкны хянан шалгагчид, үнэт цаасны зохицуулагчид, шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллага зэрэг бусад төрийн байгууллагууд төлбөрийн системийн хөгжилд нөлөөлөхүйц бодлого, зохицуулалтын ашиг сонирхолтой байж болно. Төв банк болон эдгээр байгууллагуудын хооронд мэдээлэл, санал бодлоо солилцох, шаардлагатай тохиолдолд холбогдох асуудлаар хамтран ажиллах, холбогдох бодлогыг дэвшүүлэх талаарх зохицуулалт нь төлбөрийн системийн хөгжлийн үр ашигтай, найдвартай байдалд тустай.

Удирдамж 10. Хууль эрх зүйн тодорхой байдлыг хангах: *үндэсний төлбөрийн системийн талаар тодорхой, иж бүрэн, ил тод хуулийн тогтолцоог бий болгох.*

Хураангуй: Төлбөрийн системийг үр дүнтэй хөгжүүлэхэд зах зээлийн болон төлбөрийн зохицуулалт, хяналтын болон зохицуулалтын механизм нь хууль эрх зүйн тодорхой байдлыг хангасан, эрсдлийг бууруулсан тогтолцоог шаарддаг. Үндэсний төлбөрийн системийн бүх иж бүрэн хууль, эрх зүйн тогтолцоо нь хууль болон түүнийг хэрэгжүүлэх, тайлбарлах дүрэм журам, зохион байгуулалтаас бүрдэнэ. Тийм тогтолцоонд хувийн өмчийн эзэмшлийн болон шилжүүлгийн тухай хууль, бизнесийн үйл ажиллагааны болон холбоодын тухай хууль, төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ, сүлжээтэй холбоотой гэрээний тухай хуулиуд хамаарна. Үүнд мөн төлбөрийн системийн талаарх төв банкны янз бүрийн үүргийг тусгасан хуулиуд хамаарна.

Г. Дэд бүтэц

Удирдамж 11. Бага дүнтэй төлбөрийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх: *бага дүнтэй төлбөрийн дэд бүтцийг сайжруулж, өргөжүүлэх замаар хэрэглэгч, аж ахуй нэгж, засгийн газрын байгууллагад үзүүлэх үйлчилгээ, үр ашигтай, найдвартай бэлэн бус төлбөрийн хэрэгслийн сонголт, хүртээмжийг нэмэгдүүлэх.*

Хураангуй: Улс орны эдийн засгийн хөгжил нь гол төлөв бага дүнтэй бэлэн бус төлбөрийн олон төрлийн хэрэгсэл, үйлчилгээний эрэлт хэрэгцээг нэмэгдүүлдэг. Тиймээс олон нийтийн дунд төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг хүртэх хувь хэмжээг өсгөх, янз бүрийн төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг бага зардалтайгаар хүргэх боломжийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай.

Удирдамж 12. Их дүнтэй төлбөрийн системийг хөгжүүлэх: *банк хоорондын, хугацааны хувьд яаралтай төлбөрийн өсөлт, санхүүгийн зах зээлийн хэрэгцээнд үндэслэн их дүнтэй төлбөрийн системийг хөгжүүлэх.*

Хураангуй: Их дүнтэй төлбөрийн системийн хамгийн зөв сонголт бол их дүнтэй болон яаралтай төлбөр, санхүүгийн болон мөнгөний бодлогын гүйлгээтэй холбоотой банк хоорондын төлбөрийн эрэлт хэрэгцээг хамгийн сайнаар хангасан систем байдаг. Энэ нь хамгийн нарийн технологитой байх албагүй. Их дүнтэй болон яаралтай төлбөрийн хэмжээ ихсэх тусам их дүнтэй төлбөрийн системийн зүгээс нийлүүлж буй төв банкны мөнгөний

өдрийн дундуурх төлбөр тооцоог эцсийн байхыг шаарддаг. Ийм төрлийн төлбөрүүд нь төлбөрийн системийн оролцогчдод учирч болзошгүй системийн эрсдлээс сэргийлсэн тусгай дэд бүтцийн үйлчилгээг шаарддаг. Их дүнтэй төлбөрийн системийн янз бүрийн сонголтууд байдаг ч тэд бүгдээрээ ТТСХ-оос гаргасан Системийн хувьд нэн чухал төлбөрийн системийн суурь зарчимд бүрэн нийцсэн байх ёстой.

Удирдамж 13. Төлбөрийн болон үнэт цаасны системийг хамтад нь хөгжүүлэх: *санхүүгийн системийн үр ашигтай, аюулгүй байдлыг хангахын тулд үнэт цаасны болон их дүнтэй төлбөрийн системүүдийг нийцүүлэн хөгжүүлэх ёстой.*

Хураангуй: Үнэт цаасны систем, их дүнтэй төлбөрийн систем нь бие биеэсээ хамааралтай байдаг. Төлбөрийн эсрэг нийлүүлэлт хийхэд үнэт цаасны төлбөр тооцооны системийн үнэт цаасны гүйлгээний төлбөр тооцоо нь ихэвчлэн их дүнтэй төлбөрийн систем дэх мөнгөн хөрөнгийн төлбөр тооцооноос хамааралтай байдаг. Мөн их дүнтэй төлбөрийн систем дэх зээл олголтын төлбөр тооцоо нь ихэвчлэн үнэт цаасны төлбөр тооцооны системээр хийгдэх барьцаа хөрөнгийн төлбөр тооцооноос хамааралтай байдаг. Тиймээс эдгээр дэд бүтцийн харилцан ажиллагаа нь зардал хэмнэсэн, аюулгүй, найдвартай байх ёстой. Түүнээс гадна төлбөрийн үл буцаагдах байдлыг хангах хугацаа нь хоёр системд ижил байх ёстой. Иймд үнэт цаасны болон их дүнтэй төлбөрийн дэд бүтэц нь тус тусдаа биеэ дааж хөгжих боломжгүй бөгөөд үнэт цаасны төлбөр тооцооны систем нь ТТСХ-оос үнэт цаасны төлбөр тооцооны системийн талаар гаргасан зөвлөмжид бүрэн нийцсэн байх ёстой, хэрэв шаардлагатай бол мөн арилжааны төв түншийн талаар гаргасан зөвлөмжид бүрэн нийцсэн байх ёстой.

Удирдамж 14. Бага дүнтэй, их дүнтэй болон үнэт цаасны системийн төлбөр тооцоог зохицуулах: *Үндсэн системүүдийн төлбөр гүйцэтгэх чадварын харилцан хамааралтай хэрэгцээ болон тэдгээрийн хоорондын төлбөр тооцооны эрсдлийг үр дүнтэй удирдахын тулд төлбөр тооцоог гүйцэтгэх ажиллагааг зохицуулах ёстой.*

Хураангуй: Бага дүнтэй төлбөрийн, их дүнтэй төлбөрийн, үнэт цаасны төлбөр тооцооны системийн дэд бүтэц хөгжихийн хэрээр тухайн улсын гол гол санхүүгийн байгууллагууд ихэвчлэн тэдгээр бүх системийн оролцогч болдог. Тиймээс нэг системд хийгдэж байгаа төлбөр тооцоо нь нөгөө системд хийгдэж буй төлбөр тооцооны үр ашигтай, найдвартай байдалд нөлөөлж болно. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын болон төлбөр тооцооны эрсдлийг зохистойгоор удирдахын тулд санхүүгийн байгууллагууд гол төлөв үндсэн дэд бүтэц дэх төлбөр тооцооны үйл ажиллагааг холбож, зохицуулдаг бөгөөд энэ нь цаашид эдгээр систем бие биеэсээ хамаарах нөхцлийг бүрдүүлдэг. Хэдийгээр эдгээр системийн төлбөр тооцооны үйл ажиллагааг зохицуулах нь банк хоорондын гүйлгээний зардлыг нийтэд нь хэмнэж, төв банкны мөнгөөр хийгдэх төлбөр тооцооны үл буцаагдах (эцсийн байх) байдлыг хангах байдал сайжрах ч зохицуулалт, харилцан ажиллах боломжтой холбоотой систем дамжсан эрсдэл, хууль зүйн, үйл ажиллагааны, санхүүгийн болон системийн эрсдлийг хянаж, сайтар удирдах хэрэгтэй.

1.3 Энэхүү тайлангийн зохион байгуулалт

Энэхүү тайлангийн дараагийн хэсэгт эдгээр ерөнхий удирдамжийн агуулга, цар хүрээг томъёолсон санаа, хөгжлийн хүчин зүйлсийг авч үзнэ. 3 дугаар хэсэгт төлбөрийн системийг хөгжүүлэх ерөнхий удирдамжийг банкны үйл ажиллагаа, төлөвлөлт, эрх зүйн орчин, дэд бүтэц гэсэн тусгай хэсгүүдэд хуваан толилуулна. Удирдамж бүрт танилцуулга, үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхэд түүний гүйцэтгэх үүргийн талаарх тайлбар, удирдамжийг хэрэгжүүлэх зарим арга замын талаарх хэлэлцүүлгийг багтаасан. Хэсэг бүрийн төгсгөлд энэхүү тайлангийн сэдэв болон удирдамжуудтай холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан лавлах материалыг оруулсан. Энэхүү тайлангийн төгсгөлд зарим чухал хэсгүүдийн талаарх нарийвчилсан мэдээллийг агуулсан хавсралтуудыг орууллаа.

2 Үндэсний төлбөрийн системийн хөгжил


Үндэсний төлбөрийн систем нь тухайн улсын мөнгө, санхүүгийн системийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг учир тухайн улсын эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой. Арилжааны болон санхүүгийн хэлцлийн худалдагч, худалдан авагчийн хооронд мөнгө үндэсний төлбөрийн системээр дамжин шилждэг. Хэрэв үндэсний төлбөрийн системийг сайн хөгжүүлбэл гүйлгээний нийт өртгийг бууруулж, эдийн засагдах арилжааны болон санхүүгийн хэлцлийн боломжийг өргөжүүлэх ач холбогдолтой. Энэхүү хэсэгт үндэсний төлбөрийн системийн үүрэг болон түүнийг хөгжүүлж буй сүүлийн үеийн хандлагыг тайлбарлана. Мөн үндэсний төлбөрийн системийн хөгжилд нөлөөлөх буюу түүнийг өдөөх үндсэн хүчин зүйлийн талаар дурьдаж, хойно толилуулах ерөнхий удирдамжийн агуулгыг багтаасан.

2.1 Мөнгө ба үндэсний төлбөрийн систем

Мөнгөний үндсэн үүрэг бол солилцооны хэрэгслийн үүрэг юм. Төлбөр гэдэг нь хэлцлийг эцэслэх зорилгоор мөнгөний хэрэгсэл, тухайлбал бэлэн мөнгө ба харилцах дансны мөнгө, хоёр этгээдийн хооронд шилжих үйл явц юм. Үндэсний төлбөрийн систем гэдэг нь Зураг 1-т үзүүлсэнчлэн талуудын хооронд мөнгө шилжүүлэхэд оролцож буй янз бүрийн эрх зүйн орчин болон дэд бүтцийн нэгдэл юм. Энэхүү тайланд бэлэн бус төлбөрийг авч үзсэн. Тийм төлбөр нь ихэвчлэн нэг санхүүгийн байгууллага дахь төлөгчийн данснаас нөгөө санхүүгийн байгууллага дахь хүлээн авагчийн дансанд мөнгийг шилжүүлэх цогц ажиллагаа байдаг. Энэ ажиллагаа нь төлбөрийн хэрэгслүүд, эрх зүйн орчин болон боловсруулалтын горим, төлбөрийг гүйцэтгэх мөнгө буюу мөнгөн хөрөнгийг шилжүүлэх механизмыг хөгжүүлэхийг шаарддаг.

Зураг 1

Үндэсний төлбөрийн систем



Ерөнхийдөө төлбөрийн хэрэгслүүд, зохион байгуулалт, стандарт, дүрэм, журам болон зах зээлийн зохицуулалтын цогц байдал нь систем хөгжихийн хэрээр нэмэгддэг. Тиймээс найдвартай, үр ашигтай үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхийн тулд нэгдсэн суурь тогтолцоог бүрдүүлэх нь чухал. Суурь тогтолцоог зөв хөгжүүлбэл төлбөр гүйцэтгэгч

байгууллагууд болон хэрэглэгчдийн харилцаанаас төлбөрийн системд хийгдэх цаашдын шинэтгэлүүд урган гарах боломжтой.

2.2 Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх үйл явц

Бүх улс оронд тохирсон хөгжлийн нэг нийтлэг, эсвэл цорын ганц зам байдаггүйг туршлага харуулж байна. Үндэсний төлбөрийн системийн өнгөрсөн үеийн хөгжил нь харилцаа холбооны технологи, үндэсний банкны бодлогоос ихээхэн хамааралтай байлаа. Хөгжлийн ийм чиг хандлага нь шинэ мэдээлэл, харилцаа холбооны технологи, санхүүгийн салбарын бодлоготой холбоотойгоор одоо ач холбогдлоо алдаж байна. Улс орон бүхэн үндэсний төлбөрийн системийнхээ хөгжлийн өнөөгийн шатыг өөрийн онцлогт тохируулан авч үзэх хэрэгтэй болж байна. Улс орны онцлогийг харгалзан өөрсдөө хийх үнэлгээг үндэслэл тооцоотойгоор тодорхойлсон загвар ч орлож чадахгүй.

Хэдийгээр улс орон бүхэн тодорхой нарийн зүйлээрээ ялгаатай ч үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх үйл явцад хөгжлийн нийтлэг хүчин зүйлс, шалтгаан, хандлага байдаг. Янз бүрийн улс орны хөгжлийн туршлагаас дор сэдэвлэн харуулав.

2.2.1 Үндэсний төлбөрийн системийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлс

Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх үйл явцыг ойлгохын тулд хөгжлийн гол хүчин зүйлсийг тогтоох хэрэгтэй. Гол хүчин зүйлс болон тэдгээрийн төлбөрийн системд үзүүлэх нөлөөллийн талаар доор сийрүүлэв.

(i) Хөгжлийн хүчин зүйлс

Үндэсний төлбөрийн системийн хөгжилд нөлөөлдөг дөрвөн ерөнхий хүчин зүйлсийг орчны хүчин зүйлс, эдийн засгийн хүчин зүйлс, санхүүгийн хүчин зүйлс, төрийн бодлогын хүчин зүйлс гэж хамтад нь бүлэглэж болно.

Орчны гол хүчин зүйлс нь: (i) хүн амын тоо, хотжилт зэрэг хүн ам зүйн хүчин зүйлс; (ii) байгалийн нөөцийн түвшин, хуваарилалт зэрэг газар зүйн хүчин зүйлс; (iii) нийгэм, соёлын үнэт зүйлс, хэм хэмжээ. Эдгээр хүчин зүйлс нь төлбөрийн системийг хөгжүүлэх зарим санаачлагыг хүлээж авах магадлалыг тодорхойлдог.

Эдийн засгийн гол хүчин зүйлс нь (i) нийт эдийн засгийн өсөлтийн түвшин, тогтвортой байдал; (ii) баялгийн хуваарилалт; (iii) ажиллах хүчний боловсрол, ур чадварын түвшин, тэднийг сургах сургалтын бааз; (iv) харилцаа холбоо, тээвэр зэрэг салбарын дэд бүтцийн хөгжил; (v) технологийн өөрчлөлт, шинэчлэлтийн хурдац. Эдийн засгийн суурь хүчин зүйлс, тэдгээрийн худалдаа, үйлдвэрлэл, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөлөл нь төлбөрийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ, улс орны хүчин чадалд онцгой хамааралтай.


Санхүүгийн гол хүчин зүйлс нь төлбөрийн үйлчилгээний хэрэглэгч болон үзүүлэгчдэд төлбөрийн үйлчилгээ, эрх зүйн орчин, дэд бүтцийг хөгжүүлэхтэй холбоотойгоор учрах

санхүүгийн зардал, эрсдэл болон ашиг тус юм. Арилжаа, санхүүгийн хэлцлийн төлбөр гүйцэтгэхэд хэрэглэгчдэд учирч буй зардлыг бууруулж, эдгээр хэлцлийг хийх боломжийг нэмэгдүүлж буй шинэтгэл нь шинэ төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлдэг. Төлбөр гүйцэтгэх процесст үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчийн хооронд янз бүрийн хувь хэмжээгээр хуваагдан ногддог зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шууд болон шууд бус эрсдэл байдаг.

Төрийн бодлогын гол хүчин зүйлсэд санхүүгийн байгууллагуудын талаарх хууль тогтоомж, боловсрол, үйлдвэрлэл, худалдаа, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах болон макро эдийн засгийн талаарх төрийн бодлого хамаарна. Төрийн эрх мэдэл бүхий байгууллага оролцох нь хууль, эрх зүйн орчинд шууд нөлөөлдөг учир төлбөрийн системийг хөгжүүлэхэд суурь хүчин зүйл болдог. Эдгээр төрийн бодлогын хүчин зүйлс нь нийт системийн дүр төрхийг бүрдүүлэхэд орчны, эдийн засгийн, санхүүгийн хүчин зүйлстэй хамтран оролцдог.

Эдгээр ерөнхий хүчин зүйлс үндэсний төлбөрийн системийн хөгжилд хэрхэн нөлөөлөхийг мэдэх нь төлөвлөлтийн үе шатанд чухал ач холбогдолтой. Ерөнхий хүчин зүйлс нь төлбөрийн системийн эрх зүйн хүчин зүйлсийн хамтаар төлбөрийн үйлчилгээний эрэлт, нийлүүлэлт, зах зээлийн зохицуулалтад нөлөөлөх чанараараа үндэсний төлбөрийн системийн хөгжих чиглэлд нөлөөлдөг. Эдгээр нь янз бүрийн холбогдох талуудын сонирхол, мөн хэрэв зохистойгоор тэнцвэржсэн бол олон нийтийн сонирхлыг илэрхийлдэг. Шинэтгэлийг амжилттай хийхийн тулд эдгээр бүх хүчин зүйлсийг авч үзэх хэрэгтэй. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь тооцсон арга хэмжээ нь төлбөрийн хэрэгсэл, дэд бүтэц, үйлчилгээний зах зээлийн үр ашигтай, найдвартай байдлыг сайжруулах санаачлагыг холбогдох талуудын зүгээс гаргах боломжийг бүрдүүлэхэд тустай.

Шинэтгэлийг төлөвлөх процесст хөгжлийн хүчин зүйлс хэрхэн нөлөөлдөг, энэ төлөвлөгөө нь үндэсний төлбөрийн системийн зарим гол бүрэлдэхүүн хэсгийг шинэчлэх зорилгоор хэрхэн зохиогддог талаар Зураг 2-г үзүүлээ.



(ii) Төлбөрийн үйлчилгээнээс шаардагдах шинж чанарууд

Эцсийн хэрэглэгчийн зах зээлд төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээнээс шаардагддаг нийтлэг шинж чанарууд нь: (i) төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ нь хүртээмжтэй, өргөн сонголттой байх; (ii) янз бүрийн хэрэгсэл, үйлчилгээтэй холбоотой ашиг тус, хэрэглэгчид учрах зардал, эрсдлүүдийн талаарх мэдээлэлтэй байх; (iii) хэрэглэгчийн зардал бага байх; (iv) ижил төрлийн төлбөрийн хэрэгслийн гүйлгээний өрсөлдөгч сүлжээ хоорондоо харилцан ажиллах боломжтой байх; (v) мэдээллийн аюулгүй байдлын өндөр зэрэглэлтэй, хууль зүйн эрсдэл багатай байх. Төлбөрийн систем хөгжихийн хэрээр төлбөрийн хэрэгцээ өөрчлөгдөж, төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн байгууллагуудаас төлбөрийг найдвартай, шуурхай гүйцэтгэх шаардлагыг эцсийн хэрэглэгчдийн зүгээс гол төлөв тавьдаг.

Дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгчдээс санхүүгийн байгууллагуудын зүгээс гол төлөв шаарддаг системийн шинэтгэлийн шинж чанарууд нь: (i) үйлчилгээний хүртээмж; (ii) сүлжээнд хамрагдах зардал бага байх; (iii) үйлчилгээг шуурхай, тогтсон ёсоор хүргэх; (iv) сүлжээний үйл ажиллагааны найдвартай байдал; (v) төлбөр тооцооны эрсдэл бага байх; (vi) төлбөр тооцооны үл буцаагдах байдал, ялангуяа их дүнтэй төлбөрийн хувьд. Санхүүгийн байгууллагууд нь дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгчдээсээ эдгээр хүчин зүйлсийн шинж чанар, нөлөөллийн талаарх илүү ил тод байдлыг шаарддаг болсон.

Хэрэглэгчид, болон үйлчилгээ үзүүлэгчдэд илүү ил тод болгох, үр ашгийг дээшлүүлэх, эрсдлийг бууруулах эдгээр шаардлагууд нь өнөөгийн үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхэд нөлөө үзүүлдэг. Цахим кредит шилжүүлэг, картад суурилсан бага дүнтэй

төлбөрийн хэрэгсэл зэрэг бэлэн бус төлбөрийн хэрэгслийн цоо шинэ хөгжил нь эдгээр шаардлагаас үндэстэй.

(iii) Төлбөрийн үйлчилгээний нийлүүлэлтийн шинэ чанарууд

Эцсийн хэрэглэгчийн зах зээлд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нь орлого олох боломжоо нэмэгдүүлэх, зардал, эрсдлээ бууруулах зорилготой байдаг. Тэд энэ зорилгоо: (i) мэдээллийн боловсруулалт, харилцаа холбоо, түүнчлэн төлбөрийн даалгавар, хэрэгслүүдийг хот хооронд шилжүүлэх, дамжуулах ажиллагаанд шинэ технологи нэвтрүүлэх; (ii) АТМ, ЕФТПОС болон интернет төлбөрийн систем зэрэг системүүд нь харилцан ажиллах боломжтой байх; (iii) төлбөрийн шинэ үйлчилгээ, зах зээлд санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэгчдийг оролцуулах замаар хэрэгжүүлдэг.

Дэд бүтцийн үйлчилгээний зах зээл, зохицуулалтад шинэтгэл хийснээр санхүүгийн байгууллагууд үйл ажиллагааны, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын болон эрсдлийн удирдлагатай холбоотой зардлыг хэмнэхийг зорьдог. Эдгээр хэмнэлтийг гол төлөв: (i) клирингийн болон төлбөр тооцооны системийн үндэсний хэмжээн дэх нэгдмэл байдлыг хангах; (ii) төлбөрийн дэд бүтцийн зохион байгуулалт, засаглал, үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүй, зохицуулалтын шинэтгэлийг хийх; (iii) үйл ажиллагааны эрсдлийг бууруулах зорилгоор сүлжээний үйл ажиллагааны уян хатан байдлыг сайжруулахад чиглэгдсэн шинэтгэлийг хийх замаар бий болгохыг зорьдог.

2.2.2 Үндэсний төлбөрийн системийн шинэтгэлийг хийх үүсгэл санаачлага

Шинэтгэлийг хийх санаачлага нь гол төлөв тодорхой үйл явдал, шинэчлэлээс үүсэн гардаг. Эдгээр үйл явдал нь ихэвчлэн дараахь үйл явдалтай холбоотой байдаг. Үүнд:

- Санхүүгийн болон санхүүгийн бус салбар дахь төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээний шинэ хэрэгцээ, боломжийг тусгасан шинэчлэлүүд;
- Төлбөрийн систем, түүний эрсдлүүд, түүний дотор санхүүгийн тогтвортой байдалд чухал ач холбогдол бүхий төлбөрийн мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой эрсдлүүдийн талаарх ойлгоц нэмэгдэх;
- Бусад улс оронд хийгдэж буй үндэсний төлбөрийн системийн шинэтгэл, гадаадын банкууд орж ирэх, төлбөрийн болон үнэт цаасны төлбөр тооцооны системд бүс нутгийн болон олон улсын стандартыг мөрдөх бодлого баримтлах зэрэгтэй холбоотой гадны болон дотоод шахалт ирэх;

- Олон улсын эдийн засаг, валютын холбоо үүсэх, тухайн улс олон улсын худалдаа, санхүүгийн зах зээлд эргэн оролцох зэрэг улс төр-эдийн засгийн процесс.

Эдгээр үйл явдлуудын улмаас тухайн эдийн засаг дахь шинээр үүсч буй төлбөрийн хэрэгцээнд тухайн үеийн төлбөрийн систем хангалтгүй байгаа нь тогтоогдож, шинэтгэл хийх санаачлага урган гардаг.

2.2.3 Үндэсний төлбөрийн системийн хөгжлийн хандлага

Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх санаачлага нь гол төлөв бүхий л системийн үр ашигтай, найдвартай байдлыг сайжруулахад чиглэгдсэн байдаг. Ерөнхийдөө төлбөрийн системийг хөгжүүлэх санаачлага нь эрэлтээс үүдсэн (жишээ нь: шинэ хэрэгсэл, үйлчилгээ), нийлүүлэлтээс үүдсэн (жишээ нь: зардал бууруулсан шинэ стандарт, технологи) байдаг. Төлбөрийн системийг хөгжүүлэх санаачлага нь дараахь зүйлсийн аль нэг рүү, эсвэл хэд хэд рүү чиглэсэн хандлагатай байдаг. Үүнд:

- Өргөн хүрээг хамарсан төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг аажмаар бий болгох;
- Төлбөр тооцооны системд санхүүгийн байгууллагууд төлбөр тооцооны зээлийг хямд өртгөөр авах, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хэмнэх боломжийг олгох;
- Төлбөрийн нэвт боловсруулалтыг гүйцэтгэх төлбөрийн, үнэт цаасны, гадаад тооцооны, харилцаа холбооны болон банкуудын дотоод дэд бүтцийн харилцан ажиллах боломж, уялдаа холбоо, уян хатан байдлыг хангах;
- Системийн оролцогчдод учирч болзошгүй хууль зүйн, үйл ажиллагааны, санхүүгийн эрсдлийг тооцох, тэдэнд үзүүлж буй дэд бүтцийн үйлчилгээний зардал хэмнэлтийг сайжруулах чиглэлээр төлбөрийн дэд бүтцийг зохицуулах;
- Үндэсний төлбөрийн системд зохистой зохицуулалтыг хөгжүүлэх, төв банкинд үр дүнтэй хяналтын үйл ажиллагааг бий болгох;
- Хэрэглэгчдэд үзүүлж буй төлбөрийн янз бүрийн үйлчилгээний хүргэлт, үнэлгээний илүү үр ашигтай, илүү тогтвортой, сайн зохион байгуулалттай зах зээлийг хөгжүүлэх.

2.2.4 Үндэсний төлбөрийн системийн хөгжлийн асуудлууд

Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх процессийг тасралтгүй, үр дүнтэй явуулахад анхаарах шаардлагатай асуудлуудыг олон улс орнуудын өнгөрсөн туршлагаас харж болно. Хамгийн нийтлэг асуудлуудаас дурьдвал:

- Үндэсний төлбөрийн системтэй холбоотой үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн ерөнхий цар хүрээний талаарх хангалттай мэдлэггүйн улмаас төлбөрийн системд төлөвлөгдөөгүй гэнэтийн өөрчлөлт оруулах, гол холбогдох талуудын дунд хязгаарлагдмал ойлголт, манлайлал, итгэлцэлтэй байх;
- Шинээр үүсч буй төлбөрийн хэрэгцээ, хөгжиж буй эдийн засгийн хүчин чадал, тэдгээр шаардлагад өнөөгийн системийн нийцэх чадварын талаар хязгаарлагдмал мэдээлэлтэй байх;
- Хангалттай хэлэлцэж ойлголцоогүйгээс улсын болон хувийн секторын холбогдох талуудын зүгээс оролцоо, дэмжлэг сул байх;
- Төлбөрийн системийг хөгжүүлэх, шинэтгэлийн санаачлагыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр, туршлага хязгаарлагдмал байх;
- Шинэ төлбөрийн арга хэрэгсэл нэвтрүүлэхтэй холбоотой эрсдлээс сэргийлэх байдал, хууль зүй, зохицуулалтын болон бусад төрийн бодлогын зүгээс төлбөрийн системийг хөгжүүлэхэд саад болох хүчин зүйлс байх.

Төлбөрийн системийг хөгжүүлэх удирдамжууд нь хөгжлийн эдгээр асуудлуудад чиглэгдсэн болно.

Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхтэй холбоотойгоор санал болгож буй лавлах материалууд

Fry, M J, I Kilato, S Roger, K Senderowicz, D Sheppard, F Solis and J Trundle (1999): “Payment systems”, *Payment systems in global perspective*, Routledge Press and Bank of England.

Ghossoub, E A and R R Reed (2005): “Money and specialization in a neo-classical growth”, *Journal of Money, Credit and Banking*, vol 37, no 5, October.

Humphrey, D L Pulley and J Vesala (1996): “Cash, paper and electronic payments: a cross-country analysis”, *Journal of Money, Credit and Banking*, vol 28, no 4, November.

Levahri, D and D Patinkin (1972): “The role of money in a simple growth model”, in D Patinkin (ed), *Studies in monetary economics*, Harper & Row, New York.

Millard, S and M Willison (2005): “The welfare benefits of stable and efficient payment systems”, working paper, Bank of England, forthcoming.

Sendrovic, I (1994): “Technology and the payment system”, in B J Summers (ed), *The payment system: design, management and supervision*, IMF.

Snellman, J (2000): “Evolution of retail payments in Finland in the 1990s”, *Discussion Paper 19/2000*, Bank of Finland, December.

Snellman, J J Vesala and D Humphrey (2000): “Substitution of non-cash payment instruments for cash in Europe”, *Discussion Paper 1/2000*, Bank of Finland, March.

Summers, B J (1994): “The payment system in a market economy”, in B J Summers (ed), *The payment system: design, management and supervision*, IMF.

3 Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх ерөнхий удирдамж

Үндэсний төлбөрийн системийн хөгжил нь түүний үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг өргөн хүрээнд авч үзэх шаардлагыг бий болгодог. Эдгээр үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг ерөнхийдөө эрх зүйн орчин болон дэд бүтэц гэж ангилдаг. Хэдийгээр эдгээр хэсгүүд нь төлбөрийн системд өөр өөр нөлөө үзүүлдэг ч төлбөрийн системийн гол эрх зүйн болон дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүд нь бие биедээ ихээр харилцан нөлөөлдөг бөгөөд төлбөрийн системийг хөгжүүлэх процесст чухал үүрэг гүйцэтгэдэг.

Ард байгаа нэгдүгээр Хэсэг дэх удирдамжуудад төлбөрийн талаарх банкны системийн үүргийг тусгасан. Дараагийн Хэсэг үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх процессыг төлөвлөх талаарх удирдамжуудыг агуулсан. Гуравдугаар Хэсэгт төлбөрийн системийн эрх зүйн орчны (зах зээл, зөвлөгөөн, хяналт, хууль зүйн) шинэтгэлийн талаар дурьдсан. Хамгийн эцсийн Хэсэгт төлбөрийн системийн дэд бүтцийн талаар тусгасан болно.

3.1 Банкны систем ба үндэсний төлбөрийн системийн хөгжил

Үндэсний төлбөрийн системийн хөгжил нь банкны системийн хөгжилтэй салшгүй холбоотой байдаг. Харилцагч, аж ахуйн нэгж байгууллага, түүнчлэн төрийн байгууллагуудад данс нээж, төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээгээр хангах нь банк, түүнтэй адил санхүүгийн байгууллагуудын бизнесийн үндсэн үйл ажиллагаа байдаг. Төлбөрийн системтэй холбоотой төрийн бодлогоороо дамжуулан төв банк нь энэхүү процессыг дэмжиж байдаг. Тиймээс үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх нь төв банк, арилжааны банкны систем, банкны болон төлбөрийн системийн хөгжилд хувь нэмэр оруулж буй бусад эрх мэдэл бүхий байгууллагуудын хамтын үүрэг юм. Энэ процесст төв банк голлох байр суурийг эзэлж, банкны салбар нь идэвхтэй оролцох ёстой.

Удирдамж 1. Төв банк гол үүрэгтэй байх: *Үндэсний валютын тогтвортой байдлыг хангах ерөнхий үүргийнхээ дагуу төв банк нь үр ашигтай төлбөрийн хэрэгсэл болох мөнгөний хэрэглээг хөгжүүлэхэд гол үүргийг гүйцэтгэнэ.*

Тайлбар: Төв банк нь үндэсний төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай байдлыг хангах зорилготой. Шигтгээ 1-т үзүүлсэнчлэн төв банк оператор, өдөөгч, хянагч, хэрэглэгч гэсэн хэд хэдэн үүргийг гүйцэтгэх замаар голлох байр суурийг эзэлдэг.

Эдгээр үүргийн хүрээнд төлбөрийн системийн зохион байгуулалттай хөгжилд төв банкны зүгээс хувь нэмрээ оруулах дөрвөн гол арга байна. Төв банк нь: (i) янз бүрийн төлбөрийн үйл ажиллагаа эрхэлж, төлбөрийн системд шинээр үүсч буй хэрэгцээг хангах зорилгоор үйл ажиллагааны бодлогоо өөрчлөх; (ii) төлбөрийн системийг бодитойгоор хөгжүүлэх санаачлагыг томъёолоход туслах зорилгоор төлбөрийн системийн талаарх туршлагадаа үндэслэн өөрчлөлтийг өдөөх; (iii) үндэсний төлбөрийн системийг өмнөхөөсөө илүү үр ашигтай, тогтвортой болгон хөгжүүлэх явдлыг бодлого болон хяналтын үйл ажиллагаагаараа дэмжих; (iv) шаардлагатай тохиолдолд өөрийн төлбөрийн хэрэгцээг

хангах, шинэ үр ашигтай, найдвартай төлбөрийн үйлчилгээг авах боломжтой. Төв банк зарим үед төлбөрийн системийн зарим суурь шинэтгэлийг санаачлах, төлөвлөх, хэрэгжүүлэх, төлбөрийн системд гүйцэтгэдэг бүхий л үүргээ ашиглан хөгжлийн хөтөлбөрийг хөтлөн явуулах шаардлага гардгийг хөгжиж буй олон орнуудын туршлага харуулж байна. Хэрэв хувийн хэвшлийн санаачлан хэрэгжүүлэх шинэтгэл нь төв банкны хөгжлийн зорилгод нийцсэн тохиолдолд төв банкны гүйцэтгэх гол үүрэг нь зөвлөх, дэмжих, өөрийн янз бүрийн үүргээрээ дамжуулан өөрчлөх явдал болно.

Олон оронд төв банкны операторын, өдөөгчийн, хяналтын болон хэрэглэгчийн үүрэг нь янз бүрийн хөгжлийн хүчин зүйлийн улмаас хувьсан өөрчлөгдсөөр ирсэн байна. Үндэсний төлбөрийн системийн хөгжлийн эхний шатанд үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгчдийн хооронд зохицуулалтын бэрхшээл гарч болно. Мөн өрсөлдөгч санхүүгийн байгууллагууд нийтлэг стандарт, дэд бүтцийг хөгжүүлэхэд хамтран ажиллах, түүнчлэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн түрүүнд нэвтрүүлэх дургүй байж болно. Ийм нөхцөлд заримдаа төв банкууд шинэ дэд бүтцийн үйлчилгээг шууд үзүүлэх сонголтыг хийдэг. Өөрийн зарим үйл ажиллагааг нөхөх буюу түүний бас нэг хувилбарыг бий болгохын тулд төв банкууд хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчдийг шинэ тутам бий болж буй төлбөрийн үйлчилгээний шаардлагад нийцэн хөгжихийг дэмжиж, тэднийг үр дүнтэй хянахын тулд хяналтын үйл ажиллагаагаа мөн хөгжүүлдэг.

Шигтгээ 1

Төлбөрийн системийн хөгжилд төв банкны гүйцэтгэх үүрэг

Оператор буюу төлбөрийн үйлчилгээг нийлүүлэгчийн хувьд төв банк дараахь байдлаар төлбөрийн болон зээлийн үйлчилгээг үзүүлж, хөгжүүлж болно. Үүнд:

- Шууд төлбөрийн хэрэгсэл болох бэлэн мөнгийг гүйлгээнд гаргах, банк хоорондын гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх хөрөнгө болох харилцах дансны мөнгийг гаргах;
- Системийн хувьд нэн чухал клирингийн болон төлбөр тооцооны системийг эзэмших, ажиллуулах, түүний засаглалд оролцох;
- Системийн хувьд нэн чухал бус клирингийн болон төлбөр тооцооны системийг эзэмших, ажиллуулах, магадгүй түүний засаглалд оролцох;
- Төлбөр тооцооны системийн оролцогчдын төлбөр тооцооны дансыг удирдах, тэдэнд өдрийн дундуур болон өдрийн эцэст төлбөр тооцооны зээл олгох.

Өдоогчийн хувьд төв банк төлбөрийн системийн шинэтгэл, хөгжилд дараахь байдлаар хувь нэмрээ оруулж болно. Үүнд:

- Төлбөрийн системийн загвар, үйл ажиллагаа, бодлогын талаар санаачлага гаргах, зохицуулах, судалгаа хийх, зөвлөгөө өгөх;
- Үндэсний төлбөрийн системийн хууль эрх зүйн баримт бичгийн төсөлд зөвлөгөө өгөх, зарим тохиолдолд түүний төслийг боловсруулах.

Үндэсний төлбөрийн системийн **хянагчийн** хувьд төв банк дараахь үйл ажиллагааг явуулж болно. Үүнд:

- Өнөөгийн болон төлөвлөгдөж байгаа системд хяналт тавих, тэдгээрийн найдвартай, үр ашигтай байдалд үнэлгээ өгөх;
- Төлбөрийн системийн загвар, үйл ажиллагааны талаар хэлэлцэх, зөвлөх, шаардлагатай тохиолдолд түүнд өөрчлөлт оруулах;
- Хяналтын зарчим, бодлого, удирдамжийг нийтлэх.

Үйл ажиллагааныхаа явцад төлбөрийн системийн **хэрэглэгчийн** хувьд төв банк клиринг, төлбөр тооцооны системд дараахь зорилгоор оролцож болно. Үүнд:

- Бусдын эзэмшиж, ажиллуулдаг системийг ашиглан өөрийн болон харилцагчийнхаа (Засгийн газар, түүний агентлагууд зэрэг) нэрийн өмнөөс төлбөр хийх, хүлээн авах;
- Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн системийг өөрийн үйл ажиллагаанд ашиглах;
- Бусад төв банк, санхүүгийн байгууллагуудад зориулсан корреспондент банкны үйлчилгээг ашиглах.

Хяналт нь төлбөр тооцооны системийн үр ашигтай, найдвартай байдлын зорилтыг дараахь байдлаар хангадаг үйл ажиллагаа юм. Үүнд: (i) одоо байгаа болон төлөвлөгдөж буй системийг хянах; (ii) системүүд нь эдгээр зорилтыг хангаж буй эсэхэд үнэлгээ өгөх; (iii) хэрэв шаардлагатай бол системд өөрчлөлт оруулах. Зах зээлийн нөхцөл сайжирч, хяналтын үйл ажиллагаа хөгжихийн хэрээр зарим төв банкууд өөрийн шууд үйлчилгээ үзүүлдэг байсан дэд бүтцийн зарим үйлчилгээг, ялангуяа бага дүнтэй төлбөрийн дэд бүтцэд аутсорсинг хийж, эсвэл бүр хувьчилж, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавьж

байна.¹ Хавсралт 2-т ийм хувьслыг Шри Ланкийн төв банкнаас үндэсний төлбөрийн системд гүйцэтгэдэг янз бүрийн үйл ажиллагаандаа 2001 онд хийсэн шинэтгэлийн жишээн дээр товчхон харуулсан болно.

Хэрэгжилт: Төлбөрийн системийг хөгжүүлэхэд голлох үүрэгтэй оролцож буй төв банкны хувьд хязгаарлагдмал эх үүсвэрээ хаана хамгийн зохистойгоор ашиглах вэ гэдгийг тогтоох нь түүний гол асуудал болдог. Нэг чухал ажил бол төлбөрийн системийн талаарх сургалт байдаг. Өөрийн дээд удирдлага, ажилтнууд, түүнчлэн бусад холбогдох этгээдүүдийг сургах нь төлбөрийн системийг хөгжүүлэхэд төв банк өдөөгч, хянагч, операторын үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэх угтвар нөхцөл болдог. Улс орны эдийн засаг, санхүүгийн хөгжилд үндэсний төлбөрийн системийн гүйцэтгэх үүрэг, мөнгө, санхүүгийн тогтвортой байдалд ямар ач холбогдолтойг төв банк дотроо сайн ойлгож байх нь маш чухал.

Системийн хувьд чухал ач холбогдолтой санаачлагад төв банк хөрөнгө оруулах хэрэгтэй. Эдгээр санаачлагын талаар төв банкны гүйцэтгэх үүрэг нь – операторын, хянагчийн, өдөөгчийн болон хэрэглэгчийн үүрэг бөгөөд эдгээр нь тухайн санаачлага болон түүнд оролцож буй бусад холбогдох этгээдүүдийн гүйцэтгэх үүргээс шалтгаална. Үндэсний төлбөрийн системийн хөгжилд төв банк чухал үүрэг гүйцэтгэдэг явдал нь тэдний зүгээс дараахь үйл ажиллагааг явуулах хүлээлтийг бий болгодог. Үүнд:

- Төлбөрийн системийн үйл ажиллагаагаа өөрийн үндсэн үйл ажиллагаатай адилаар зохион байгуулах;
- Туршлага, ур чадварыг нэмэгдүүлэх үүднээс сургалт, мэдлэг хөгжүүлэх ажиллагаанд хөрөнгө оруулах;
- Төлбөрийн системд өргөн хүрээтэй шинэтгэл хийх үүднээс өөрийн төлбөрийн системийн үйл ажиллагааг төлөвлөх, эрэмбэлэх, хангалттай хэмжээнд хөгжүүлэх;
- Чухал төлбөрийн системийн хөгжлийг хянах, төлбөрийн системийн судалгаа, шинжилгээ хийхэд зориулж хангалттай эх үүсвэр гаргах;
- Үндэсний төлбөрийн системд хийгдэж буй хөгжлийн талаар бусад холбогдох талуудтай хэлэлцэх, зөвшилцөх боломж бүрдүүлэх үүднээс төлбөрийн системийн үйл ажиллагааны хүрээнд харилцаа холбооны стратегийг хөгжүүлэх.

¹ Удирдамж 10-т дурьдсанчлан эдгээр үйл ажиллагааны зарим нь хуулиараа төв банкны гүйцэтгэх үүрэгт хамаарч болно. Тиймээс зарим үйлчилгээг үзүүлэх, эсвэл болих нь зүгээр нэг бодлогоор шийдэгдэх процесс биш байдаг.

(i) Төлбөрийн системийн үйл ажиллагааг зохион байгуулах

Төв банкны төлбөрийн системийн үйл ажиллагаа нь төлбөрийн үйл ажиллагаа, бодлого, хяналтын үйл ажиллагааг гол төлөв хамардаг. Төлбөрийн системийн үйл ажиллагаа эрхэлдэг нэгж нь мөнгөний бодлого, захиргаа зэрэг төв банкны бусад үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүдээс тусдаа байж болно. Энэ нь тухайн нэгжид зөвхөн төв банкны төлбөрийн системийн зорилго, зорилтод төвлөрөн ажиллах боломжийг олгодог.

Төв банкны үндсэн үйл ажиллагааны хувьд төлбөрийн системийн үйл ажиллагаа нь дэд ерөнхийлөгч гэх мэт дээд түвшний удирдлагаар дамжуулан төв банкны бодлогын зөвлөлд тайлагнадаг байх ёстой. Түүнчлэн төлбөрийн системийн үйл ажиллагааны хүрээнд янз бүрийн нэгжүүдийн хоорондын уялдаа холбоо, зохицуулалт маш чухал. Энэ нь төв банкны төлбөрийн үйл ажиллагааны хүрээнд янз бүрийн нэгжүүдийн зүгээс өөр өөрийн өнцгөөс харж шинэ бодлогын санал, үйл ажиллагааны горимыг хэлэлцэх боломжийг олгодог. Эдгээр уялдаа холбоо, зохицуулалтын механизм нь албан ёсоор буюу албан бусаар зохион байгуулагдаж болно. Шигтгээ 2-г Канадын төв банкны ашигладаг механизмыг жишээ болгон харууллаа.

Шигтгээ 2

Улс орны жишээ: Канад төв банкны CLACSS

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, клиринг, төлбөр тооцооны системийн хороо (CLACSS) нь Ерөнхийлөгчийн Зохицуулалтын ахлах зөвлөхөөр удирдуулсан дотоодын хороо юм.
- CLACSS нь Ерөнхийлөгчөөр ахлуулсан санхүүгийн системийн бодлогын хороо болох Канадын төв банкны Санхүүгийн системийн хороотой төлбөрийн, үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны асуудлаар санал бодол солилцох, бодлогын зөвлөмж гаргах зорилготой.
- CLACSS нь дараахь үйл ажиллагааг хариуцсан газар, хэлтсийн ахлах ажилтнуудаас бүрдсэн гишүүдтэй. Үүнд:
 - Төлбөрийн системийн үйл ажиллагаа, үйл ажиллагааны судалгаа,
 - Мөнгөний бодлогын хэрэгжилт, хөрөнгийн удирдлага,
 - Төлбөрийн клиринг, төлбөр тооцооны хяналт, бодлогын судалгаа,
 - Хууль зүйн үйлчилгээ.

(ii) Мэдлэг, туршлагыг тасралтгүй хөгжүүлэх

Төлбөрийн системийн хөгжилд нөлөөллөө хадгалахын тулд төв банк үндэсний төлбөрийн системийн сүүлийн үеийн хандлага, асуудлуудын талаарх мэдлэг, туршлагаа тасралтгүй гүнзгийрүүлж байх шаардлагатай. Төв банк нь санал болгож буй төлбөрийн системийн шинэтгэлийн, системийн хэмжээгээрх үр ашигтай, найдвартай байдалд хэрхэн нөлөөлөхийг үнэлэх, төв банк өөрөө тэрхүү шинэтгэлд хамгийн сайнаар хэрхэн хувь нэмрээ оруулахыг тодорхойлох чадвартай байх хэрэгтэй. Үүний тулд төв банк нь ажилтнуудаа сургаж, төлбөрийн системийн үйл ажиллагаа, төлбөрийн үйлчилгээний зах зээл, дэд бүтцийн судалгаа хийх чиглэлээр ажиллуулах шаардлагатай.

Түүнчлэн өөрийн үндэсний валютаар төлбөр тооцоо хийдэг төлбөрийн системд байнгын анхаарал тавьж байх ёстой боловч гадаад улс орон дахь хандлага, хөгжлийг мэдэж байх нь зөв зохистой шинэтгэлийн санаачлагыг томъёолоход тустай.

Тиймээс төв банк мөн төлбөрийн системийн хөгжилд нөлөөлдөг янз бүрийн холбогдох талуудтай байнга хэлэлцэж, зөвшилцөж байх нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй. Эдгээр зөвлөгөөнд ТТСХ, Дэлхийн банк, ОУВС зэрэг олон улсын байгууллагууд болон бусад орны төв банкуудын мэргэжилтнүүдийг мөн оролцуулж болно.

(iii) Төлбөрийн системийн үүргийг хөгжүүлэх процессийг төлөвлөх, эрэмбэлэх

Төв банк нь үндэсний төлбөрийн системийн ерөнхий хөгжлийн процессын суурь хөрс болох операторын, өдөөгчийн болон хянагчийн үүргээ хөгжүүлэх шаардлагатай. Төв банк төлбөрийн систем дэх эдгээр үүргээ тогтмол хянаж үзэн, хэрэв шаардлагатай бол тэдгээрийг төлбөрийн системийн ирээдүйн хөгжлийн найдвартай, үр ашигтай байдлыг хангахын тулд хэрхэн өөрчилж болох талаар үнэлгээ өгч байх нь зүйтэй. Гэсэн хэдий ч ерөнхий хөгжлийн төлөвлөгөөний шууд хэрэгцээнээс хамааран төв банк нь онцгой нэг үүрэгтээ тусгайлан анхаарч болно. Жишээлбэл суурь эрх зүйн орчин, дэд бүтцийг хөгжүүлэх үед төв банк нь төлөвлөгдсөн шинэтгэлийг хэрэгжүүлэхийн тулд өөрийн операторын болон өдөөгчийн үүрэгтээ гол анхаарлыг хандуулж болно.

Операторын үүрэг

Операторын үүргийн тухайд төв банкны хэрэгжүүлэх хамгийн чухал төсөл бол өөрийн төлбөр тооцооны дансдын боловсруулалт болон зохицуулалтын горимд шинэтгэл хийх явдал байж болно. Юуны өмнө төв банк өөрийн үндэсний дансдын удирдлага, боловсруулалтын системийг хөгжүүлэх нь банкны систем дэх шинэ төлбөрийн үйлчилгээ, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Жишээлбэл бүс нутгийн банкууд, үндэсний банкны бүс нутгийн салбарууд гол төлөв төв банкны бүс нутгийн салбарт төлбөр тооцооны дансаа байршуулдаг. Хэрэв төв банк дансны зөвхөн төвлөрсөн бус удирдлагын бүтэцтэй бол банкууд төв банкин дахь төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа банкныхаа хэмжээнд үр дүнтэйгээр удирдах боломж багасна.

Харилцаа холбооны технологи үндэсний хэмжээнд хөгжихийн хэрээр төв банк дансны удирдлагын системээ шинэчилж, нэгдсэн онлайн систем болгох чадвартай байх хэрэгтэй. Банкууд төв банкны бүс нутгийн салбарт төлбөр тооцооны дансаа байршуулж болох боловч тэдгээр нь төв банкны нэгдсэн дансны удирдлагын системд хамрагдсан байх ёстой. Энэхүү систем нь төлбөр тооцооны үйлчилгээнд ашиглагддаг бусад дотоодын нягтлан бодох бүртгэлийн болон боловсруулах системд холбогдсон байх ёстой. Үндэсний хэмжээн дэх салбаруудынхаа хүрээнд ийм нэгдсэн дансны удирдлагын системийг ашигладаг банкууд төв банкин дахь хөрөнгийнхөө позицийн мэдээллийг илүү сайн авах боломжтой бөгөөд энэ нь тэдгээр позици илүү ашигтайгаар удирдах боломжийг олгодог. Түүнчлэн төв банкны эх үүсвэрийн нийт эрэлт, нийлүүлэлтийн талаарх мэдээллийг төв банк илүү сайн авах боломжтой бөгөөд энэ нь түүнд мөнгөний бодлогоо илүү үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг олгодог.

Өдөөгчийн үүрэг

Өдөөгчийн үүргийнхээ хүрээнд төв банк төлбөрийн системийг хөгжүүлэх санаачлагыг хэрэгжүүлэхээр холбогдох талуудаар тохиромжтой арга хэмжээг авахуулах хүсэлт гаргаж болно. Энэ үүргийн хувьд төв банкны ерөнхий зорилго бол төлбөрийн системийн хөгжлийн тодорхой асуудлын шийдлийг олох явдал бөгөөд энэ нь төв банк болон зарим холбогдох талуудын хувьд буулт хийх явдал байж болох ч хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой. Энэхүү шийдэл нь төлбөрийн системийг хөгжүүлэх санаачлагыг холбогдох талууд хүлээн зөвшөөрөх нөхцлийг сайжруулахад туслах ба цаашдын шинэчлэл, эрх зүйн шинэтгэлийг хувийн секторт хийх өдөөлтийг бий болгоно. Төв банк түүнчлэн төлбөрийн системийн хөгжилд саад учруулахуйц бодлого, зохицуулалтад анхаарал хандуулахыг бусад холбогдох эрх мэдэл бүхий байгууллагаас хүсч болно. Эдгээр нь дараахь үйл ажиллагаанд нөлөө үзүүлдэг төрийн бодлого, зохицуулалт байна. Үүнд: (i) өөр өөр төрлийн үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчдийн зүгээс төлбөрийн үйлчилгээний зах зээлд нэвтрэх боломж; (ii) төлбөрийн данс, хэрэгсэл, шилжүүлгийн үйлчилгээний ашиглалт, нийлүүлэлт. Хоёр дахь тохиолдолд жишээлбэл, янз бүрийн банкны болон төлбөрийн үйлчилгээний зах зээлийн татвар, татаасын бодлого, үнэлгээний зохицуулалт нь найдвартай, үр ашигтай үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхэд санамсаргүй сөрөг үр дагавар учруулж болно.

Хянагчийн үүрэг

Төв банкны хяналтын үйл ажиллагааны бодлогын хүрээг тодорхой тогтоох нь чухал алхам болдог. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, төлбөрийн үйлчилгээний зах зээлийн ёс зүй зэрэг төлбөрийн системийн чухал хэсгийг хамаардаг улсын секторын бусад агентлаг байхгүй тохиолдолд хяналтын зорилт нь өргөн цар хүрээг хамарч болно. Төв банкны хяналтаар төлбөрийн системд нэвтрэх нөхцөл, төлбөр тооцооны эрсдлийн хяналт, удирдлагын процесс, системийн хэмжээний найдвартай, үр ашигтай байдалд үзүүлэх нөлөөлөл зэргийг онцгой анхаарсны үндсэн дээр суурь дэд бүтцийн зохион байгуулалтад

үнэлгээ өгөх ёстой. Төлбөрийн системийн шинэчлэл хийгдэж буй үед хяналтын зорилт нь үндэсний төлбөрийн системийн гол бүрэлдэхүүн хэсгүүд болон шинэ зохицуулалтуудыг хянах ажиллагаанд чиглэгддэг.

Хэрэв системийн хэмжээний найдвартай, үр ашигтай байдлыг зохих ёсоор тэнцвэржүүлэх чадвар хувийн секторт дутагдаж байгаа нөхцөлд төв банк хяналтын үүргээрээ дамжуулан хөгжлийн санаачлагад хөндлөнгөөс оролцож болно. Төлбөрийн системийн өөрчлөлтийг үр дүнтэй, итгэлтэйгээр хийхийн тулд төв банк нь хяналт тавих тодорхой, тохиромжтой эрх мэдэлтэй байх хэрэгтэй.

Төв банк үүргээ хангалттай биелүүлэх үүднээс хяналтын үйл ажиллагаагаа зардал хэмнэлттэйгээр зохион байгуулах шаардлагатай. Жишээ нь гол төлөв төв банкны хяналтын үйл ажиллагаа нь зөвхөн хяналтын асуудал, бодлогод төвлөрөн ажиллахын тулд төлбөрийн систем болон мөнгөний бодлогоос тусдаа бие даасан нэгж хэлбэрээр зохион байгуулагдсан байдаг. ТТСХ-ны 2005 оны “Төв банкнаас төлбөр тооцооны системд тавих хяналт” тайланд хяналтын үйл ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр зарим нарийвчилсан удирдамжийг багтаасан байдаг.

(iv) Төв банкны үүргийг сурталчлах

Хэрэв төв банкны зорилго, бодлого, шинэтгэл хийх санал нь төлбөрийн системийн бусад гол холбогдох талуудад тодорхой, дэлгэрэнгүй байдлаар танилцуулагдсан бол төлбөрийн системийн хөгжилд үзүүлэх төв банкны нөлөөлөл нь хамгийн үнэ цэнэтэй, үр дүнтэй байна. Төв банк нь мэдээллийг бүхий л холбогдох талуудад хууль тогтоомж, бодлого, зөвлөгөөн, төлбөрийн судалгааны нийтлэл, ерөнхий тайлан нийтлэл болон холбогдох талуудын гэрээ зэрэг янз бүрийн харилцааны хэрэгслээр тууштай дамжуулах шаардлагатай. Түүнчлэн мэдэгдлүүд нь төв банкны өөр өөр хэлтсийн дунд болон янз бүрийн холбогдох талуудтай төв банкны дээд удирдлагын хийх яриа хэлэлцээн дээр ижил утгатай байх ёстой. Шигтгээ 2-т жишээ болгон харуулсан шиг төлбөрийн бодлогыг зохицуулах дотоодын хороонууд нь энэ талаар үнэ цэнэтэй байх болно. Италийн төв банкны хяналтын үүргийг сурталчлах бодлогыг Шигтгээ 3-т харууллаа.

Шигтгээ 3

Улс орны жишээ: Итали төв банкнаас баримтлах төлбөрийн системийн ил тод байдлын бодлого

Италийн банкны тухай хуулиар төлбөрийн системийн хяналтын үйл ажиллагааг Италийн төв банкинд 1993 онд албан ёсоор хариуцуулсан.

1997 оны 5 дугаар сард Италийн банк төлбөрийн системийн хяналтын Цагаан номыг гаргаж, хяналтын үйл ажиллагааны онолын үндэс болон эрх зүйн орчинг тодорхойлсон. 1999 оны 11 дүгээр сард хоёр дахь нийтлэлийг (Төлбөрийн системийн хяналтын цагаан ном. Зорилт, аргачлал, хамрагдах талбар) гаргаж, хяналтад хамрагдах талбар, хяналт хийх аргуудын талаар нарийвчилсан судалгаа дүгнэлтийг багтаасан. Эдгээр хоёр нийтлэлийн зорилго нь төлбөрийн системийн үр ашигтай, найдвартай байдлыг нэмэгдүүлэхэд хяналтын үйл ажиллагааны гүйцэтгэх үүргийн талаар зах зээлийн операторууд, үйлчилгээ үзүүлэгчид, мэргэжлийн шинжээчидтэй хэлэлцэж зөвлөлдөх эхлэлийг тавих явдал байсан.

Зах зээлд ойлгомжтой, ил тод хяналтын эрх зүйн орчинг толилуулах үүднээс 2004 оны 2 дугаар сард Италийн төв банк “Төлбөрийн системийн хяналтын нөхцөл”-ийг гаргасан. Эдгээр нөхцлүүд нь төлбөрийн системийн хөгжилд нөлөөлөх холбогдох талуудын хамтын ажиллагаа, ёс суртахууны хүрээнд авах арга хэмжээ зэрэг хяналтын уламжлалт хэрэгслүүдийг баяжуулж өгсөн.

Удирдамж 2. Банкны системийн тогтвортой байдлыг хангах: *банкууд болон бусад ижил төстэй санхүүгийн байгууллагуудаас эцсийн хэрэглэгчдийг хангаж буй төлбөрийн данс, хэрэгсэл, үйлчилгээ нь хоорондоо өрсөлдөх хэдий ч системийнхээ хувьд үргэлж хамтран ажиллах хэрэгтэй.*

Тайлбар. Энэхүү тайлан нь үндсэн үйл ажиллагаагаараа эцсийн хэрэглэгчдэд төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг, хөрөнгө татан төвлөрүүлдэг, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг бүх санхүүгийн байгууллагуудыг хамарна. Эдгээрт хувийн, хамтын, улсын өмчийн байгууллагууд багтана. Түүнчлэн, банкуудад болон банкны нэрийн өмнөөс эцсийн хэрэглэгчдэд гол үйл ажиллагаа болох төлбөрийн үйлчилгээг үзүүлдэг банк бус байгууллагуудыг хамрагдана. Тэдгээрийн зарим нь шуудангийн, бичил санхүүгийн байгууллага болон төлбөрийн шилжүүлгийн үйлчилгээг хувиараа эрхлэгчид байх бөгөөд бизнесийн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд төлбөрийн тусгай үйлчилгээг үзүүлэхдээ өөрсдөө банкны үйлчилгээг ашиглаж байдаг.

Банкны системд итгэлцэл нь төлбөрийн системийн хөгжлийн зайлшгүй нөхцөл болдог. Үүнийг бий болгохын тулд эцсийн хэрэглэгчдэд үзүүлэх төлбөрийн хэрэгслээр дамжуулан үндсэн үйлчилгээ үзүүлэгч банкны системд оролцогчид нь дараахь нөхцлүүдийг хөгжүүлэх хэрэгтэй. Үүнд: (i) үндэсний хэмжээнд үзүүлж буй үйлчилгээндээ дэвшилтэт технологи арга барилыг хэрэглэх; (ii) дансны болон төлбөрийн боловсруулалтын системийн дотоод удирдлага; (iii) төлбөрийн үйлчилгээний дэд бүтцэд зориулсан сүлжээний механизмыг холбож буй зохицуулалт. Үүний зэрэгцээ банкны системд бүхэлдээ хамтран ажиллах, мөн шинэ хэлбэрийн эрх зүйн зохицуулалт, ялангуяа зах зээлийн зохицуулалтыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах шаардлагатай.

Шигтгээ 4-т эцсийн хэрэглэгчдийн зах зээл дээр банкны болон банкны бус үйлчилгээ эрхлэгчдийн үүргийг ерөнхийлөн харуулав.

Шигтгээ 4

Эцсийн хэрэглэгчдийн зах зээл дээрх банк болон банк бус байгууллагууд

Төлбөрийн системийн хөгжил дэвшил нь эцсийн хэрэглэгчдэд төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг үзүүлж байдаг банкны болон банкны бус салбарын хөгжилтэй салшгүй холбоотой.

- Ихэнх оронд банк болон түүнтэй холбоотой байгууллага нь зах зээлд эцсийн хэрэглэгчдэд төлбөр тооцоо гүйцэтгэх данс, төлбөрийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлэх үндсэн нийлүүлэгч болдог.
- Төлбөрийн үйлчилгээ эрхлэгч банк бус байгууллагууд тухайлбал, шуудангийн төлбөрийн үйлчилгээний алба болон аж ахуйн нэгж, байгууллагууд дахь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч цэгүүд нь эцсийн хэрэглэгчийн зах зээлд дансны болон төлбөрийн үйлчилгээ үзүүлж болдог.

Банкны бус үйлчилгээ эрхлэгч нь дараахь зүйлд гол анхаарлаа хандуулах нь олонтаа байдаг. Үүнд:

- Зах зээлийн сегмент (жишээлбэл, бага орлоготой хувь хүмүүс, жижиг үйлдвэр);
- Үйлчилгээний байршил (жишээлбэл, багахан эсвэл алслагдсан хөдөөгийн суурин болон бүс нутаг);
- АТМ-ын сүлжээ, интернет төлбөрийн систем, боловсруулалт, клиринг, төлбөр тооцооны тусгай үйлчилгээ зэрэг дэд бүтцийн үйлчилгээ;

Хэрэгжилт. Банкны системийн тогтвортой хөгжлийн гол хариуцлага нь банкуудын хоорондын уялдаа холбоон дээр байдаг. Төлбөрийн системийг амжилттай хөгжүүлэхийн тулд банкны систем нь зах зээл судлал, бизнесийн хөгжил, төлбөрийн системийн хүрээний мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, тэдгээрийг хөлслөх, тогтвор суурьшилтай ажиллахад нь хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй. Төв банк нь төлбөрийн системийг хөгжүүлэх санаачлагыг дэмжих зорилгоор банкны системийг хөгжүүлэх үйл явцыг өдөөгчийн үүргийг гүйцэтгэдэг боловч энэ нь зөвхөн банкуудтай хамтран ажилласан нөхцөлд үр дүнд хүрэх юм.

(i) Төлбөрийн үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх

Банкны системийн юуны өмнө шийдэх зорилт нь голлох төлбөрийн үйлчилгээг улс орны бүх бүс нутагт хүргэхэд оршино. Хөдөөгийн суурин газар, жижиг хотуудад өөрийн салбар нэгжээ нээн ажиллуулж байгаа, харилцах данс нээх, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зэрэг ялангуяа жижиг харилцагчдад хямд төлбөртэйгээр энэ үйлчилгээг хүргэж байгаа банк болон шинэ үйлчилгээ эрхлэгчдийг урамшуулж болно. Банкны болон банкны бус үйлчилгээ эрхлэгчид мобайл банкны төлбөрийн үйлчилгээг хүн ам багатай дүүрэгт хүргэхэд, түүнчлэн цахим банкны болон төлбөрийн сүлжээний дэвшилтэт технологи (жишээ нь, утасгүй холболт-wireless technologies)-д хөрөнгө оруулахад оролцох боломжийг мөн судалж үзэх хэрэгтэй. Төв суурин газруудад орон нутгийн буюу

хоршооллын банк байгуулах зөвшөөрлийг банкны байгууллагууд олгох, банкинд дансаа байршуулж шилжүүлэг хийх, төлбөрийн хэрэгслээр эцсийн хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэхэд бэлэн байгаа банк бус байгууллагуудтай гэрээ байгуулах зөвшөөрлийг банкны зүгээс өгч болох юм. Энэ зохицуулалтын дагуу төлбөрийн дансууд үлдэж, харин тэдгээр дансуудад төлбөрийн үйлчилгээ авахаар хандах хандалт орон нутагтаа төвлөрсөн бус байдалтай болно. Бразил улсад хэрэглэгдэж байгаа арга барилын жишээг Шигтгээ 5-д авч үзлээ.

Улс орон даяар бүх хэрэглэгчдэд үзүүлж буй банкны болон төлбөрийн үйлчилгээний хүртээмжийг үр ашигтайгаар өргөжүүлэхийн тулд банкууд дараахь байдлаар дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Үүнд:

- (i) Цахим банкны сүлжээ (жишээлбэл, АТМ, интернет банк), салбар нэгжээрээ дамжуулан үндэсний хэмжээнд төлбөрийн данс болон үйлчилгээ ашиглах хандалтыг өргөжүүлэх;
- (ii) Янз бүрийн харилцагчдын хандах сүлжээгээр дамжуулан мэдээллийн систем болон дансны удирдлагын нэгдсэн системд хөрөнгө оруулах;
- (iii) Бага дүнтэй төлбөрийн хэрэгслийн хүрээг өргөжүүлэх зорилгоор дансны удирдлагын дотоод системийг харилцагчдын үүсгэсэн болон түүний зөвшөөрөлтэй төлбөрүүдэд зориулагдсан бусад системүүдтэй нэгтгэх, холбох;

Цахилгаан холбооны дэд бүтэц, банкны сүлжээний хандалтыг зөвшөөрсөн газраас онлайн горимд ажиллаж буй компьютерын системээр дамжуулан дансны удирдлагын ба дансны мэдээллийн цахим систем рүү холбогдохоор болгож болох юм. Цахилгаан холбооны технологи хөгжихийн хэрээр болон дэд бүтцийн хамрах хүрээ тэлэхийн хэрээр энэхүү онлайн системд хандах илүү олон хээргслүүдийг нэгтгэж болно.

Шигтгээ 5

Улс орны жишээ: Бразилийн банкны үйлчилгээний цар хүрээний өргөжилт

Бразилийн 5578 засаг захиргааны нэгжээс 1740 орчим (30 %) нь банкны салбаргүй боловч тэдгээр нь банкны үйлчилгээг корреспондент банкуудаар (*correspondentes bancários*)² дамжуулан авдаг байна. Ойролцоогоор 16 000 орчим корреспондент банк байдаг ба бараг тийм тооны банкны салбар байдаг байна. Тэд харилцан тохиролцож зөвшилцсөний үндсэн дээр банкны өмнөөс төлөөлөгчийн хувиар дараахь чиглэрээр ажилладаг байна. Үүнд:

- Хөрөнгө татан төвлөрүүлэх ба ерөнхий төлбөрүүд;
- Зохих дансад хамаарах төлбөрийг гүйцэтгэх;
- Зээл олгох тухай өргөдөл болон зээлийн карттай холбоотой санал хүлээн авах;

Хамгийн чухал корреспондент банк нь Бразилийн шуудангийн алба (ЕСТ) юм. ЕСТ нь Бразилийн хувийн томоохон банк – Бардескогийн нэрийн өмнөөс ажилладаг бөгөөд зарим нэгийг эс тооцвол, өөрийн нутаг дэвсгэр дээрээ банкны салбаргүй бараг бүх засаг захиргааны мужид үйлчилдэг байна. Бусад корреспондент банкуудад хонжворт сугалааны байгууллагууд, супермаркетууд, эмийн сангууд болон бусад багавтар жижиглэн худалдааны байгууллагууд хамрагддаг.

Корреспондент банкуудын үйл ажиллагааг Бразилийн Төв банк оролцсон улсын байгууллага болох -Үндэсний валютын зөвлөл зохицуулдаг. Дүрмээр дараахь зүйлийг тогтоодог:

- Корреспондент банкны хувиар үйл ажиллагаа явуулах тухай хэлцэл байгуулах чавартай санхүүгийн байгууллагын төрлүүд;
- Тэдний үзүүлж чадах үйлчилгээний төрлүүд;
- Банк болон түүний нэрийн өмнөөс ажилладаг корреспондент банкуудын хооронд хийгдэж буй төлбөрийн тооцооны журам;
- Корреспондент банкууд нь банкны үйлчилгээг үзүүлэхдээ өөрсдийн хөрөнгө мөнгөө ашиглаж болохгүй тухай шаардлага;

(ii) Банкны системийн стандартыг сайжруулах

Нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын стандартад нийцсэн төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээний стандартыг хөгжүүлэн, бий болгож буй салбарын бүлэг болон форумыг төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн байгууллагууд хөхүүлэн дэмжих хэрэгтэй. Ялангуяа янз бүрийн дундын сүлжээнүүд болон гүйлгээ хийгдэж байгаа сүлжээгээр дамжигдаж байгаа үйлчлүүлэгчдийн мэдээллийн аюулгүй байдлын стандарт нь онцгой чухал юм. Мөн түүнчлэн, клирингийн төлбөрийн аюулгүй болон үр дүнтэй байдлыг хангах хэрэгслүүдийн стандарт чухалд тооцогдоно.

Төлбөрийн үйлчилгээний стандарт, зах зээлийн тогтсон хэв журмыг шинэчлэхдээ төв банк болон бодлогын асуудлаар нийтлэг сонирхол бүхий банкны байгууллагуудтай хамтран

² Бразилийн Төв Банкны Үндэсний Мөнгөний Бодлогын Хорооноос гаргасан 3.110 тоот тогтоол болон 3.156 тоот тогтоолын нэмэлт өөрчлөлтийг харна уу.

ажиллах нь салбарын бүлгүүдийн хувьд үр дүнтэй байна. Банкуудын төлбөрийн нийтлэг дэд бүтцийг хөгжүүлэх хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжиж болох юм. Энэ нь клирингийн янз бүрийн төлбөрийн хэрэгслүүдийн зохицуулалт болон клирингийн төвийн зохион байгуулалтыг хамарч болно. Мөн АТМ болон дебет картыг ашигласан төлбөрийн сүлжээ гэх мэтийн дундын цахим төлбөрийн сүлжээг хөгжүүлэх, клирингийн төвийг автоматжуулахад зарцуулагдах тохируулгын болон суурилуулалтын зардлыг банкууд хуваан гаргаж болно.

(iii) Төв банкны оролцоо

Төв банк нь төлбөрийн системийн хөгжлийг санаачлагч ганц эх үүсвэр биш юм. Банкны систем нь мөн өөрөө үндэсний төлбөрийн системийн үр ашигтай, найдвартай байдлыг сайжруулах өөрчлөлт шинэчлэлтийн эхлэлийг тавигч байж болно. Гэхдээ төв банк хувийн секторын санаачлагад түлхэц өгдөг ч, оператор ба өдөөгчийн үүрэг гүйцэтгэхдээ зайлшгүй үед санаачлагыг гартаа авч болно.

Төв банк операторын үүрэг хүлээдгийн хувьд голлох дэд бүтцийг хөгжүүлэхэд банкны системтэй хамтран ажиллана. Олонх улс оронд төв банк нь төлбөр тооцооны гол дэд бүтцийн оператор болдог ба энэ нь тохиромжтой үед төв банкин дахь мөнгөөрөө төлбөр тооцоо гүйцэтгэдэг бусад дэд бүтэцтэй холбогдох боломжтой. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд, төв банк нь салбарын стандартуудыг гаргахад өөрийн зохицуулалтад хамаарах зарим нэгийг нь баталгаажуулах замаар нөлөөлж болно.

Сүлжээний оролцоогоороо дамжуулан, мөн үйлчилгээ үзүүлэх хэлэлцээрийн дагуу төв банк нь банкууд болон өөр бусад ижил төстэй санхүүгийн байгууллагуудад клирингийн болон төлбөр тооцооны үйлчилгээнд шууд ба шууд бусаар оролцоход тусалцаа үзүүлэх ёстой. Тухайлбал, банкууд нь өөрсдийн гүйлгээний болон санхүүгийн шаардлагад нийцсэн үйлчилгээнд шууд хандах эрхтэй байвал зохино. Гэхдээ, тэд бизнесийн шинжилгээний үр дүнд үндэслэн өөр банкаар дамжуулан шууд бусаар хандах сонголттой байх ёстой. Төв банкин дахь дансны удирдлагын систем нь бүтцийнхээ хувьд системд байгаа болон шинээр бий болж буй банкуудын төлбөр тооцооны хэрэгцээг хангахад хангалттай уян хатан байх ёстой.

Өдөөгчийн үүрэг гүйцэтгэж байдгийн хувьд төв банк нь шинэ зах зээлийн болон харилцагчдын хүрэн дэх эцсийн хэрэглэгчдэд банкны системийн үзүүлж буй хямд, хялбар төлбөрийн үйлчилгээг хүргэхэд тус нэмэр хүргэж чадна. Мөн түүнчлэн, төв банкны зүгээс банкуудад өөрийн салбарын бүлгийг зохион байгуулахад нь болон эдгээр бүлгүүдийг банкуудад шууд нөлөө үзүүлэх төлбөрийн бодлогын асуудлаар зөвлөгөө өгөхөд нь тусалж болно. Үүнээс гадна хууль, эрх зүйн шинэтгэлийн талаар болон улс орны төлбөрийн ба банкны системийн уялдсан хөгжлийг зохицуулах асуудлаар төв банкнаас банкны байгууллагуудад сургалт явуулах боломжтой. Ийм хууль, эрх зүйн шинэтгэлийг жишээлбэл, ижил төстэй банк бус байгууллагуудын үзүүлж буй төлбөрийн хэрэгслийн болон төлбөрийн үйлчилгээний нөхцөлд дэмжлэг үзүүлэх зорилгоор шаардаж

болох юм. Үнэндээ банкны системийн зохистой хяналт болон зохицуулалт нь хэрэглэгчид, байгууллагуудын үндэсний төлбөрийн системд итгэх итгэлийг бататгахад голлох хүчин зүйлсийн нэг болдог.

Банкны систем болон үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхтэй холбоотойгоор санал болгож буй лавлах материалууд

Bloomstein, H J and B J Summers (1994): “Banking and payment systems”, in B J Summers (ed), *The payment system: design, management and supervision*, IMF.

Bossone, B and M Cirasino (2001): “The oversight of payments systems: a framework for the development and governance of payment systems in emerging economies”, *Payments and Securities Clearance and Settlement Systems Research Series*, CEMLA/World Bank, July.

Bradford F, M Davies and S Weiner (2003): *Nonbanks in the payment system*, Federal Reserve Bank of Kansas City, November.

Committee on Payment and Settlement Systems (2003): *The role of central bank money in payment systems*, Bank for International Settlements, August.

——— (2005): *Central bank oversight of payment and settlement systems*, Bank for International Settlements, April.

Rivlin, A (1998): “Risks and opportunities in payment systems”, in *Payment Systems in the Global Economy: Risk and Opportunities*, 34th Annual Conference on Bank Structure and Competition, Federal Reserve Bank of Chicago, May.

Spindler, J A and B J Summers (1994): “The central bank and the payments system”, in B J Summers (ed), *The payment system: design, management and supervision*, IMF.

Sundararajan, V and G Sensenbrenner (1994): “Linkages between payment system reform and monetary policy: the recent experience in Russia and other former Soviet Union countries”, in T J Balino and C Cottarelli (eds), *Framework for monetary stability*, IMF.

3.2 Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх төлөвлөлт

Өмнө тэмдэглэсэнчлэн, үндэсний төлбөрийн системийн хөгжил бол тасралтгүй процесс юм. Хөгжил нь дэд бүтэц болон эрх зүйн орчны бие даасан шинэтгэлээс эхлээд одоо байгаа зохицуулалтын энгийн өөрчлөлт хүртэлх хүрээг хамарч болно. Хөгжлийн процесс нь төв банк, хувийн банкууд эсвэл банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн тус тусдаа эсвэл хамтын зэрэгцсэн буюу дараалсан төслүүдээр боловсруулагдаж байдаг.

Төлбөрийн системийг хөгжүүлэх төлөвлөлтийн удирдамжууд нь системийг бэхжүүлэх тодорхой санаачлагуудыг томъёолоход тусалж, системийн цаашдын хөгжилд түлхэц өгч, чиглүүлж байдаг. Удирдамжуудын гол санаа нь: (i) үндэсний төлбөрийн системийг өргөн хүрээтэйгээр авч үзэх; (ii) хөгжлийн санаачлагууд нь эдийн засгийн боломж ба үүсэн бий болж буй төлбөрийн хэрэгцээнд анхаарах; (iii) хөгжлийн санаачлагууд нь тэдгээрийн эн тэргүүний зорилтуудыг тодорхойлсон стратеги арга барилаар төлөвлөгдсөн байх; (iv) хөгжлийн төлөвлөлтийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд маш тодорхой бөгөөд сайн зохион байгуулсан байх. Гол холбогдох талууд бүгд хөгжлийн санаачлагуудын төлөвлөлтийн процесст дангаараа болон хамтдаа хамрагдсан байх шаардлагатай ба харин төв банк болон банкны холбоо нь энэхүү процессыг удирдахад хариуцлага болон ашиг сонирхлоо хуваалцана.

Удирдамж 3. Үндэсний төлбөрийн системийг цогцоор нь авч үзэх: *төлөвлөлт нь үндэсний төлбөрийн системийн гол бүрэлдэхүүн хэсгүүд болон түүний хөгжилд нөлөөлөх үндсэн хүчин зүйлүүдийн бүх талын ойлголтод суурилсан байх ёстой.*

Тайлбар. Хоёрдугаар Хэсэгт заасанчлан, үндэсний төлбөрийн системийг шинэтгэх төлөвлөлтийн үед хүчин зүйлс, бүрэлдэхүүн хэсгүүдийг өргөн хүрээтэйгээр сайтар судлах шаардлагатай. Харамсалтай нь, төлбөрийн системийн хөгжил нь дэд бүтцийн загвар, технологи, хэрэгслүүдэд дэндүү хязгаарлагдмал байдлаар анхаарал хандуулах нь олонтаа байдаг. Төлбөрийн системийн тогтвортой хөгжил нь шинэтгэлийн санаачлагуудыг хэрэгжүүлэх үеийн зах зээлийн зохицуулалт, хууль, эрх зүйн орчин, банкны системийн өөрчлөлт зэрэг системийн бүх үндсэн хэсгүүд, түүнчлэн хөгжлийн үндсэн хүчин зүйлийг авч үзэх шаардлагатай.

Төлбөрийн системийн өргөн цар хүрээтэй хэтийн төлөв нь хөгжлийн иж бүрэн төлөвлөгөөг боловсруулахад тус дэм болдог. Ийм төлөвлөгөө нь төлбөрийн дэд бүтэц болон эрх зүйн зохицуулалтын хоорондын харилцааг илэрхийлж болно. Мөн түүнчлэн, хөгжлийн төлөвлөлтийн үе шатуудын өргөн цар хүрээтэй хэтийн төлөв нь үүнийг байхгүй тохиолдолд ихэвчлэн үүсэх дэд бүтцийн болон төлбөрийн технологийн шинэтгэлийн урьдчилан таамаглаагүй, санамсаргүй үр дагавруудаас зайлсхийхэд тусална.

Хэрэгжилт. Энэхүү удирдамжийг хэрэгжүүлэх гол хэрэгсэл нь үндэсний төлбөрийн системийн гол бүрэлдэхүүн хэсгүүдийн өнөөгийн байдлын иж бүрэн үнэлгээ юм. Энэ нь бүх холбогдох талуудын хэрэгцээнд зориулсан ерөнхий бүтцийг гаргахад тусалдаг.

Хавсралт 3-т хэтийн төлвийг үнэлэх бэлтгэл ажлын товч төлөвлөгөөг гаргаж үзүүлсэн болно. Ийм үнэлгээ нь бусад олон улсын ба бүс нутгийн байгууллагуудад болон ТТСХ-д нийтлэгдсэн улс орны төлбөр тооцооны системийн бүтэц, эрх зүй, статистикт хэрэглэгдэж буй үнэлгээтэй ижил байна.

(i) Үнэлгээнд бэлтгэх талаарх зөвлөгөө

Үнэлгээний бэлтгэл нь аливаа хөгжлийн хөтөлбөрийн шийдвэрлэх эхний алхам болдог. Энэ нь төлбөрийн хэрэгслүүд болон үндсэн төлбөр, банк болон бусад санхүүгийн дэд бүтэц, үндэсний төлбөрийн систем дэх гол байгууллагууд, түүнчлэн, хөгжлийн гол хүчин зүйлсийн чиг хандлагыг зайлшгүй хамардаг. Үнэлгээнд бэлтгэхэд юуны түрүүнд улсын болон хувийн секторын холбогдох талуудыг хамарсан хамтын арга хэмжээг удирдлага болгох хэрэгтэй. Мэдээлэл цуглуулахын тулд анкетжуулах, ярилцлага, санал асуулга явуулах, мөн холбогдох талуудтай газар дээр нь уулзалт хийж болно. Эдгээр арга хэмжээ нь, төлбөрийн системд тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх болон одоо үйлчилж буй системд шинээр үүсч байгаа төлбөрийн хэрэгцээг хангах боломжийг үнэлж дүгнэхэд тусална.

Зөвлөлдөх процесс нь холбогдох талуудад үндэсний төлбөрийн системийн өргөн хүрээтэй асуудлаар өөрийн мэдлэгийн түвшингээ дээшлүүлэх боломж олгох механизмыг бий болгодог. Түүнчлэн, тэрээр холбогдох талуудын хэрэгцээ, төлөвлөгөө болон нийт системийн хөгжлийн бодлогод хандах хандлагын “мэдрэмж”-ийг сайжруулах хэрэгсэл болдог. Үүнийг дугуй ширээний уулзалт явуулах, эсвэл улсын болон хувийн секторын янз бүрийн холбогдох талуудтай ажлын хэсэг зохион байгуулах замаар хэрэгжүүлнэ. Тухайн ажиллагаа нь төлбөрийн системийн хөгжлийн хөтөлбөрт оролцоо, сонирхлоороо нэмэр болж чадах хөгжлийн тэргүүлэх чиглэл болон зорилгыг хэлэлцэх боломжийг холбогдох талуудад олгодог.

(ii) Төв банкны оролцоо

Үндэсний төлбөрийн системийн иж бүрэн үнэлгээ нь түүний хөгжлийн шинэ үйл явцыг үнэлж дүгнэхэд маш сайн суурь болж өгдөг. Энэ нь шинжилгээ хийхэд зориулагдсан орчин үеийн иж бүрэн бүтцээр хангаж чадна. Шаардлагатай тохиолдолд үнэлгээг явуулах болон зөвлөлдөх явцад улс орны төв банк гол дэмжигч болж, түүний боломжит өдөөгч нь байх боломжтой. Хамгийн багадаа л төв банк энэ процессийн идэвхтэй оролцогч байх ёстой. Ялангуяа хууль, эрх зүйн хүрээнд түүний алсын хараа, мэргэжлийн ур чадвар онцгой үнэ цэнэтэй. Төв банк нь үр ашигтай, найдвартай үндэсний төлбөрийн системд чухал ач холбогдол бүхий шинэ өөрчлөлтийн үзүүлэх нөлөөллийг үнэлэх зорилгоор үнэлгээг тогтмол хугацаанд шинэчлэх талаар холбогдох талуудад зааварчлага, зөвлөгөө өгч, өөрчлөлтийн үйл явцыг хянаж байдаг.

Үндэсний төлбөрийн системийн хөгжлийн талаарх мэргэжлийн ур чадвар тэр бүр хангалттай байдаггүй. Дэлхийн банк, ОУВС, ОУТГБ-ыг оруулаад олон улсын санхүүгийн байгууллагууд, бусад төв банкуудын шинжээчид энэ процесст дэмжлэг үзүүлж чаддаг.

Шигтгээ 6-д төлбөрийн системийн хөгжилд Дэлхийн банк, ОУВС-ын зүгээс үзүүлэх дэмжлэгүүдийг товчхон харууллаа.

Шигтгээ 6

Дэлхийн банк ба ОУВС: төлбөрийн системийн хөгжилд үзүүлэх дэмжлэг

Дэлхийн банк төлбөрийн системийн хөгжилд дараахь байдлаар дэмжлэг үзүүлнэ:

Техникийн тусламж

- Иж бүрэн үнэлгээг агуулсан тайлан боловсруулах
- Төлбөрийн системийн хөгжлийн хүчин чадал, хэрэгцээнд шинжээчдийн зөвлөгөө өгөх
- Төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги төлөвлөлт хийх
- Шинэтгэлийн санаачлагыг хэрэгжүүлэх талаар зөвлөх

Санхүүгийн дэмжлэг

- Төлбөрийн системийн шинэтгэлийн санхүүжилтэд зориулан банкны зээл олгох

Бусад дэмжлэг

- Төлбөрийн хүрээнд бүс нутгийн санаачлагыг дэмжих
- ТТСХ, ҮЦКОУБ (Үнэт цаасны комиссын олон улсын байгууллага-IOSCO)-д болон бусад хороод, тусгай ажлын хэсгүүдэд оролцох
- Төлбөрийн болон үнэт цаасны төлбөр тооцооны системд зориулагдсан санхүүгийн салбарыг үнэлэх хөтөлбөрийг дэмжих
- Санхүүгийн салбар дахь төлбөрийн, үнэт цаасны, зээлийн болон бусад үйлчилгээний шинэтгэлийг зохицуулах
- Гишүүн орнуудад зориулсан төлбөрийн системийн сургалт, судалгаа

ОУВС санхүүгийн тогтвортой байдал, мөнгө зээлийн бодлогыг үр дүнтэй явуулах, санхүүгийн зах зээл, эдийн засгийн хөгжлийн үр ашгийг дэмжих зорилгоор дэлхийн хэмжээнд төлбөрийн системийг боловсронгуй болгох, хөгжүүлэхэд дараахь байдлаар оролцоно:

Ажиглалт-хяналт

- Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын санхүүгийн салбарыг үнэлэх хөтөлбөрийн бүтцийн хүрээнд тэргүүний туршлага, хууль, олон улсын стандартад нийцсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх
- Санхүүгийн системийн тогтвортой байдал болон эдийн засгийн хөгжлийн асуудлаар зөвлөгөө өгөх

Техникийн тусламж

- Шинэтгэлийн болон төлөвлөлтийн асуудлаар зөвлөгөө өгөх
- Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх болон санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх
- Төв банкны төлбөрийн үйл ажиллагааны үүрэг, зохион байгуулалт
- Төв банкны хяналтын хууль эрх зүйн үндсийг боловсруулах ба түүнийг хэрэгжүүлэх
- Мөргөлдөөний дараахь бүс нутгуудын үндэсний төлбөрийн систем болон байгууллагуудыг сэргээх

Сургалт, зөвлөгөө

- Сургалт ба бэлтгэл (жишээлбэл: төв-суурьтай курс, семинар болон Joint Vienna Institute, Joint Africa Institute), ТТСХ болон Дэлхийн банктай байнга хамтран ажиллах
- ТТСХ ба ҮЦКОУБ зэргээс байгуулагдсан ажлын хэсэг болон тусгай комиссын удирдамж,

- | |
|--|
| <ul style="list-style-type: none">стандартыг хөгжүүлэхДэлхийн банкнаас зохион байгуулагддаг төлбөрийн талаарх орон нутгийн санаачлагаар дамжуулан өгөх зөвлөгөө |
|--|

Дэлхийн банк буюу өөр бусад байгууллагуудтай хамтран ажиллахдаа хөрш орнуудын төв банкуудын бүлэглэлүүд нь төлбөрийн системийн асуудлаар туршлага солилцсоноор бүс нутгуудын хэд хэдэн санаачлагуудыг гаргаж байдаг.

Удирдамж 4. Эрэлт хэрэгцээг голчлон анхаарах: *үндэсний төлбөрийн системийн бүх хэрэглэгчийн төлбөрийн хэрэгцээ болон эдийн засгийн боломжийг тодорхойлж, тэдгээрт нийцсэн үйл ажиллагаа явуулах ёстой.*

Тайлбар. Төлбөрийн систем нь хэрэглэгчдэд гүйлгээний тодорхой төрөл бүрд янз бүрийн төлбөрийн хэрэгслийг илүү олон сонголттойгоор санал болгосноор хөгжиж байдаг нь зүй ёсны хэрэг юм. Тодорхой төлбөрийн хэрэгслүүд ба төлбөрийн үйлчилгээнүүд нь гүйлгээний тодорхой төрлүүдтэй тохирч болох юм. Жишээлбэл, их дүнтэй төлбөрийн хувьд автомат кредит шилжүүлгүүд, зайнаас хандах интернет төлбөрүүдийн хувьд кредит картын гүйлгээнүүд, харин “нүүр нүүрээрээ тулж” хийх төлбөрийн хувьд бэлэн мөнгөөр хийх тооцоо илүү тохиромжтой. Төлбөрийн хэрэгслийн сонголт нь гүйлгээний тодорхой төрлүүдэд зайлшгүй чухал хэрэглэгчдийн онцлог шинжид үндэслэдэг. Эдгээр төлбөрийн хэрэгслүүдээр клиринг, төлбөр тооцоо, гүйлгээг найдвартай, үр дүнтэй гүйцэтгэхийн тулд үйлчилж буй дэд бүтцийг өөрчлөн байгуулж, шинийг нэвтрүүлж байх хэрэгтэй.

Үүсэн бий болж буй төлбөрийн хэрэгцээ нь эдийн засгийн үйлдвэрлэл, худалдаа, санхүүгийн салбарын хөгжлийн боломжит процесс ба чиглэл хандлагатай холбоотой байдаг. Эдгээр салбарууд дахь улсын болон хувийн секторын хөгжлийн санаачлагын талаарх мэдээлэл нь төв банк, засгийн газрын байгууллагууд, санхүүгийн байгууллагууд, аж ахуйн нэгж, хэрэглэгчдийн шинээр бий болж буй төлбөрийн хэрэгцээг ойлгох, илрүүлэхэд ашиг тустай. Энэхүү мэдээлэл нь төлбөрийн системийг шинэтгэх төлөвлөлтөд холбогдолтой, ирээдүйд хөгжиж болохоор байгаа холбогдох талуудад хамаарах гүйлгээний ямар шинэ төрөл байгааг харуулж чадах юм.

Үндэсний төлбөрийн систем дэх тодорхой холбогдох талуудын хэрэгцээ шаардлага нь төлбөрийн үйлчилгээний янз бүрийн зах зээлд тэдгээрийн хэр зэрэг үүрэг гүйцэтгэж байгаагаас шалтгаална. Зарим гол холбогдох талууд нь төлбөрийн систем дэх янз бүрийн үйлчилгээний зах зээл болон байгууллагуудын хувьд өөр өөр үүрэгтэй ба тиймээс ч ялгаатай ашиг сонирхолтой байдаг байна. Жишээлбэл, банкууд төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээг бага дүнтэй төлбөр хийдэг харилцагчдад үзүүлдэг боловч дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгчдээс клирингийн болон төлбөр тооцооны үйлчилгээг шаарддаг. Нэг талаас, төв банк нь банк хоорондын төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч, мөн нөгөө талаас, уг системд хяналт тавих байгууллагын хувьд, мөнгө зээлийн бодлогоо явуулахтай холбогдсон өөрийн ажиллагааг гүйцэтгэхийн тулд дэд бүтцийн үйлчилгээний хэрэглэгч

болдог. Тиймээс, төлбөрийн системийн тодорхой хэрэгцээ, хүчин чадлын талаар төв банк эсвэл банкуудад ч ашиг сонирхол байж болох ба тэдгээрт өөрийн гэсэн үзэл бодолтой байна. Эдгээр олон янзын үүргийг мэдсэнээр хөгжлийн тодорхой санаачлагуудад илэрч болох гол холбогдох талуудын янз бүрийн сонирхол, санаархлыг ойлгоход шийдвэрлэх ач холбогдолтой юм. Мөн энэ нь тодорхой шинэтгэлээс, хэн нь илүү эрсдэл, зардлыг үүрч, хэн нь илүү ашиг авахыг тодорхойлоход тусалдаг. Оролцогчдод эдгээр эрсдэл, зардал, ашгийг зохих ёсоор хуваах зорилгоор шинэтгэлийг боловсруулах нь шинэтгэлийн санаачлагыг амжилттай хэрэгжүүлэхэд дөхөм болох юм.

Хэрэгжилт. Энэхүү удирдамжийг хэрэгжүүлэх хоёр үндсэн асуудал нь бизнесийн хэрэгцээ шаардлагын бодит байдлын шинжилгээ болон тэдгээрийг хангах хүчин чадал, хэрэгцээний нөөцийн үнэлгээ юм. Төлбөрийн системийг хөгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлтэй асуудлын бодит байдалд үндэслэсэн шийдвэр гэдэгт зарим нэг холбогдох талуудын тодорхой ашиг сонирхол болон зохицуулалтын шинэ төрөлд оролцогч бусад талуудын чадавхид чиглэсэн онцгой анхаарал татсан эрх зүйн буюу дэд бүтцийн хоорондын зохицуулалтын төвөгтэй асуудлуудаар тохиролцоонд хүргэх явдал хамаарч болно.

(i) Бизнесийн хэрэгцээ, шаардлагын шинжилгээ

“Бизнесийн хэрэгцээ, шаардлагын” шинжилгээ нь холбогдох талуудын төлбөрийн хэрэгцээ болон түүнийг хангах эдийн засгийн боломжийг тодорхойлох үндсэн хэрэгсэл юм. Үүний зорилго нь шинэтгэлийн боломжит санаачлагууд дахь ирээдүйд чиглэсэн бизнесийн нөхцөл байдлыг тодорхойлоход оршино. Үнэлгээ явуулахын зэрэгцээ, энэ нь дараахь зүйлсийг тодорхойлоход туслах ёстой: (i) дэд бүтцийн үйлчилгээний болон төлбөрийн хэрэгслийн эрэлт хэрэгцээний үүсч буй хандлага; (ii) оролцогчдын хууль зүйн болон санхүүгийн эрсдэл; (iii) үйлчилгээ шууд үзүүлэгчид, үйлчилгээг хэрэглэгчид, түүнчлэн хяналт болон төлбөрийн үйлчилгээний зохицуулалтын янз бүрийн байгууллага зэрэг гол холбогдох талуудын онцлог үүрэг. Түүнчлэн, энэ шинжилгээ нь өнөөгийн хөгжлийг дэмжих эрх зүйн болон зохицуулалтын дэг журам, үйлчилгээ үзүүлэх зах зээлийн зохицуулалт гэх мэт төлбөрийн системийн эрх зүйн тогтолцоонд байж болох хөгжлийн процесс болон үүсэн бий болж буй хандлагыг анхаарах ёстой. Бизнесийн хэрэгцээ, шаардлагын шинжилгээ нь шинэтгэлийг явуулснаар зөвхөн “нийгмийн” тусын тулд биш, мөн системийн шинэтгэлд оролцох үйлчилгээ үзүүлэгч ба хэрэглэгчдэд зориулсан урамшууллыг ерөнхий байдлаар илэрхийлж болно. Бизнесийн хэрэгцээ, шаардлагын тулгамдсан асуудал болох зарим өвөрмөц онцлогтой бүрэлдэхүүн хэсгүүдийг Шигтгээ 7-д тодотгон үзүүлэв.

Бизнесийн хэрэгцээ, шаардлагын шинжилгээг бүрэн дуусгах болон мэдээлэхэд хамаарал бүхий холбогдох талуудын зөвлөгөө шаардлагатай. Холбогдох талуудын тодорхой бүлгүүдийн тулгамдсан асуудалд хамаарах хөгжлийн тухай эдгээр зөвлөгөөнд анхаарахдаа систем дэх тэдний үүргийг төлбөрийн үйлчилгээний янз бүрийн зах зээлтэй болон дэд

бүтэцтэй харьцуулж үзэж болно. Ийм харьцуулалтын тусламжтайгаар дараагийн судалгаа шинжилгээний төлөвлөгөөг боловсруулж, мөн холбогдох тал тус бүртэй зөвлөлдөж болно.

Шигтгээ 7

Бизнесийн шаардлагын орчны бүрэлдэхүүн хэсгүүд

- Шаардлага бүхий төлбөрийн хэрэгсэл, дэд бүтцийн үйлчилгээнд тавигдах нөхцлүүд :
 - хэрэглэгдэж байгаа болон бэлэн байгаа мэдээллийн технологи, төлбөрийн сүлжээний технологи, төлбөрийн системийн ирээдүйн хэрэгцээнд тохирсон загвар зэргийн уян хатан, нийлэмжтэй байдал;
 - төлбөрийн дэд бүтэц дэх системийн болон оролцооны эрсдэлийг бууруулах зорилготой эрсдэлийг удирдах механизмууд (жишээлбэл, эрх зүйн, санхүүгийн ба үйл ажиллагааны)
 - банк хоорондын зээл болон төлбөрийн системд хандах бодит байдал ба нөхцөлүүд;
 - үйлчилж буй хуваарь, горим;
 - олон улсын болон үндэсний стандартад нийцэх байдал.
- Илэрсэн хэрэгцээ, хүлээлтийг оролцуулаад төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээний эрэлтийн нөхцлүүд:
 - янз бүрийн төлбөрийн хэрэгслүүд болон тэдгээрийг тодорхой төрлийн гүйлгээнд ашиглах;
 - төлбөрийн болон дансны мэдээллийн аюулгүй байдал ба баталгаажуулах процесс, түүнчлэн төлбөрийн хэрэгсэлтэй холбоотой эрсдлүүд;
 - мөнгөний бодлогод холбогдох гүйлгээ, засгийн газрын төлбөрийн урсгал, валют арилжааны болон үнэт цаасны төлбөр тооцооны банк хоорондын кредит шилжүүлэгтэй холбоотой гүйлгээнүүд зэрэг тусгай гүйлгээнд зориулсан төлбөрийн хэрэгсэл ба үйлчилгээний шаардлага.
- Зах зээлийн болон бусад эрх зүйн зохицуулалт нь дараахь нөхцлүүдийг багтаана:
 - төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээний эцсийн хэрэглэгчдийн зах зээлийн бэлэн байдал болон хялбар дөхөм байдал;
 - төлбөрийн дэд бүтцэд хандах болон сүлжээ дамнан оролцох шаардлагууд;
 - янз бүрийн төлбөрийн дэд бүтцэд шууд бус хандах нөхцөлүүд ба шинж чанарууд;
 - шууд ба шууд бус оролцооны эрсдэлүүд (өөрөөр хэлбэл, эрх зүйн, ажиллагааны, санхүүгийн);
 - төлбөрийн хэрэгсэл, дэд бүтцийн хэрэглэгчдийн болон нийлүүлэгчдийн хууль ёсны эрх, үүргийн ил тод байдал, зохистой байдал, (дүрэм, журмыг оруулаад);
 - төлбөрийн хэрэгсэл ба үйлчилгээнд үнэ тогтоох арга, үнийн түвшин;
- ил тод байдал, хяналт, зохицуулалтын талууд:
 - системийн зохицуулалт ба түүнд тавих хяналт (эрх мэдэл бүхий байгууллагын төрөл ба тэдгээрийн хариуцлага, түүнчлэн хяналт тавих, зохицуулах байгууллагуудын эрх, үүргийг хамааруулан);
 - хяналт, зохицуулалтын талаарх маргааныг зохицуулах механизмууд;
 - байнгын тогтмолжсон тайлагнал;

(ii) Нөөцийн шаардлага, боломжийг тодорхойлох нь

Хэрэглэгчдийн хэрэгцээг тооцсон системийн шинэтгэлийн төлөвлөлт нь тухайн улсын технологийн хүчин чадал болон хүний нөөцийн зохих хөгжлийг шаардаж болно. Голлох санхүүгийн бус дэд бүтцийн болон тэдний хөгжлийн хөтөлбөрүүдийн ялангуяа цахилгаан холбооны, мэдээллийн технологийн салбарын бодит байдал нь тодорхой төрлийн төлбөрийн дэд бүтэц, интернетээр хийх болон карт ашигласан төлбөрүүдийг хөгжүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой. Түүнчлэн, тээврийн системийг хөгжүүлэх хөтөлбөр ч тодорхой төрлийн төлбөр ба төлбөрийн хэрэгслүүдэд чухал нөлөөтэй. Шууд байдлаараа, тээврийн систем нь зайнаас хийж буй төлбөрт хэрэглэгдэж буй бүс нутаг хооронд биетээр хийгддэг цаасан төлбөрийн шилжүүлэгт нөлөөлж чаддаг. Харин шууд бусаар, тээврийн систем нь тэрхүү зайнаас, биетээр хийгддэг цаасан төлбөрүүдийн хэмжээнд нөлөөлж, энэ мэтээр төлбөрийн хэрэгслийн тодорхой төрлүүдийг хөгжүүлэх шаардлага болон бизнесийн нөхцөл байдалд нөлөө үзүүлдэг байна.

Мэдлэг, туршлагатай боловсон хүчнийг бэлтгэх нь эдийн засгийн материаллаг дэд бүтцийг хөгжүүлэх шиг төлбөрийн системийн хөгжилд тийм чухал юм. Төлбөрийн илүү ярвигтай технологийн удирдлага, ашиглалт, өөрчлөлтийн хүрээнд боловсон хүчнийг бэлтгэхэд зориулсан хөтөлбөр болон арга хэрэгсэл нь төлбөрийн системийн боломжит төлөвлөгдсөн хөгжлийн нэг хэсэг нь байх ёстой. Ийм маягаар, үүсч буй төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээний талаар одоогийн сургалтын хөтөлбөрүүд болон тэдгээрт хамаарах эрх зүйн болон дэд бүтцийн зохицуулалт нь хэрэглэгчдэд ч, үйлчилгээ үзүүлэгчдэд ч ашигтай юм.

Холбогдох дасгал, сургалтын хөтөлбөр болон шийдвэрлэх чухал санхүүгийн бус дэд бүтцийн хөгжилд хамааралтай эрх мэдэл бүхий байгууллагуудтай зөвлөлдөх ажиллагаа нь мэдээлэлд тулгуурласан бизнесийн хэрэгцээ, шаардлагын шинжилгээг томъёолоход тустай байж чаддаг.

(iii) Төв банкны оролцоо

Төв банк нь төлбөрийн системийн чадавхи, бизнесийн шаардлагын талаарх үндсэн зөвлөгөөн болон чухал сургалтуудад идэвхтэй оролцогч байх ёстой. Хувийн салбарууд энэ талаар бие даан зохицуулж чадахгүй үед үйл явцыг хурдасгах, зохион байгуулах боломжийг харах ёстой. Үүнээс гадна төв банк, төлбөрийн системд янз бүрийн үүрэг, ашиг сонирхолтой холбогдох талуудыг санал бодлын зарим нэг зөвшилцөөнд хүргэх мэтгэлцээний шинж чанартай болгох зорилгоор тэдний өөрсдийнх нь үзэл бодлын дотоод зохицуулалт руу түлхэж өгдөг.

Удирдамж 5. Эн тэргүүний зорилтуудыг тодорхойлох: үндэсний төлбөрийн системийн хөгжлийн эн тэргүүний зорилтуудыг тодорхойлж, стратеги аргаар төлөвлөх.

Тайлбар. Стратеги төлөвлөгөө нь үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх хөтөлбөрийн тодорхой чиглэл, цар хүрээ болон хүрэх эцсийн цэгийг зааж өгдөг. Ингэснээрээ тэрээр төлбөрийн систем, түүний эрх зүйн гол бүрэлдэхүүн хэсэг ба дэд бүтэц, түүнчлэн тэдгээрийн хөгжилд нөлөөлөх үндсэн хүчин зүйлүүдийг багтаасан өргөн

утгаар авч үздэг. Стратеги төлөвлөгөө нь эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын харилцан үйлчлэлийг тодорхойлж, улс орны өвөрмөц онцлогтой төлбөрийн хэрэгцээ болон нөөцийн боломжийн иж бүрэн шинжилгээнд үндэслэсэн шинэтгэлийн тэргүүлэх чиглэлүүд болон тодорхой зорилгыг тодорхойлдог. Энэ төлөвлөгөө нь өргөн хүрээтэй зөвлөгөө өгөх, ялангуяа өргөн хэмжээний, суурь өөрчлөлтөд хамаарах тодорхой шинэтгэл, санаачлага дээр зөвшилцөлд хүрэх замаар боловсруулагддаг байна.

Стратеги төлөвлөгөөг улс орны өвөрмөц онцлогийг тооцсоны үндсэн дээр боловсруулна. Гэхдээ төлбөрийн системийн аль нэг хэсэгт тодорхой авч үзэх зүйл нь төлөвлөгдөж буй шинэтгэлийн ашигтай загвар байх болно. Жишээлбэл, нэг улс орны төлбөрийн систем дэх дэд бүтцийн загварууд эсвэл эрх зүйн зохицуулалтын тодорхой төрлүүд нь өөр нэг орны шинэтгэлийн хөтөлбөрт тохирч болно. Гэхдээ төлбөрийн тодорхой хэрэгцээгээр, системийн боломжоор, мөн тухайн орон дахь орчин нөхцөлүүдээр зохицохын зэрэгцээгээр, үндэсний төлбөрийн системийн найдвартай, үр дүнтэй байдлыг дээшлүүлэх зорилгод нийцэж байх шаардлагатай. Шигтгээ 8-д төлбөрийн системийн хөгжлийн стратеги төлөвлөлтийн зарим үндсэн шинж чанарыг онцлон харууллаа.

Шигтгээ 8

Хөгжлийн стратеги төлөвлөгөөний бүрдлүүд

- Төлөвлөлтийн хүсч буй эцсийн төсөөлөл нь ирээдүйн төлбөрийн системийн дээд түвшний зорилго, удирдамжийн зарчим, шинж чанар, ашиг, эрсдэл, зардлын талаарх холбогдох талуудын гол бүлгүүдийн нэгдсэн саналыг маш тодорхой илэрхийлдэг.
- Хөгжлийн процесст улсын болон хувийн салбарын гол холбогдох талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлох.
- Амжилтын эгзэгтэй, бодит хүчин зүйлээр хэмжигдэх ажиглалтын чухал үе шат
- Төлөвлөгдөж буй үнэт цаасны болон төлбөр тооцооны дэд бүтцийн схемчилсэн загварын төсөөлөл нь үйлчилж буй системийн санхүүгийн хөгжлийн ирээдүйн хэрэгцээнд зохицсон өөрчлөн байгуулалт, цаашдын өргөтгөлийн ажилбар ба хүчин чадал, үндсэн шинж чанар, бүтцийн нэгдлийг өөртөө агуулна.
- Стратегийг хэрэгжүүлэх албан ёсны мэдээ нь тодорхой тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх процедур, түүнчлэн түр зуурын хэрэгжүүлэх схем, хуваарилагдсан төсвийн хуваарилалт ба гарсан ахиц дэвшлийн талаар нийтэд зориулсан илтгэл бэлтгэхэд шаардагдах гол чухал үзүүлэлтүүд болон тэдгээрт хүрэх хяналтын үе шат, санхүүжилтийг багтаана.
- Зохих холбогдох талуудын тасралтгүй үргэлжилж буй хоорондын зохицуулалт ба хамтын ажиллагааны журмыг тодорхойлох; хөтөлбөрийн хэрэгжүүлэх явц болон түүнээс хойш үүсч болох маргаан, зөрөлдөөнийг шийдвэрлэх ажиллагааг тодорхойлох; хэрэгжүүлэлтийн үе шат дууссаны дараахь гүйцэтгэл болон мэдээлэх ажиллагааны журыг тодорхойлох.

Дээр үзүүлсэн стратеги төлөвлөгөө чухал ач холбогдолтой, өргөн хүрээний шинэтгэлийн хөтөлбөр гэж тооцогдож байгаа бөгөөд ийм маягаар төлөвлөлтөд нэлээд хэмжээний хүч

хөдөлмөр шаардагдаж байна. Мөн логикийн болон практикийн бэрхшээлтэй асуудлууд нь маш онцлог, зайлшгүй үйл ажиллагааг тодорхойлж байгаа үед хямралаас шалтгаалахгүйгээр шинэтгэл хийх өөр хувилбар байгааг уг төлөвлөгөө харуулна. Шигтгээ 9-д стратеги төлөвлөгөөний жишээ болгож өнгөрсөн арван жилийн турш хэрэгжүүлж байгаа Өмнөд Африкийн үндэсний төлбөрийн системийн шинэтгэлийн төлөвлөгөөний жишээг харуулав.

Шигтгээ 9

Улс орны жишээ: Өмнөд Африкийн үндэсний төлбөрийн систем – тогтолцоо ба стратеги

Зарчмууд:

- Төлбөрийн системийн үйлчилгээ үзүүлэх нь банкуудын онцгой эрх биш юм.
- Аажмаар хувьсч буй төлбөрийн дэд бүтэц бол хамтын хариуцлага юм.
- Эрсдэл ба түүнд өртөх дүн нь илэрхий зүйл.
- Оролцогчид нь төлбөрийн системд өөрсдийн оруулж буй эрсдэлийн хариуцлагыг үүрнэ.
- Өртөг болон эрсдлийн бууралтын хоорондын балансыг хадгална.
- Төлбөрийн системд гарч буй бэрхшээлтэй асуудалд төв банкны зүгээс үзүүлж буй хандлага нь системийн тусдаа оролцогчийн хувьд бус харин системийн нийтлэг сонирхлын төлөө байна.
- Төлбөрийн системийн тогтвортой, найдвартай байдлыг хангахад хяналт тавих нь зайлшгүй хэрэгтэй.

Төсөөлөл:

- Үндэсний төлбөрийн систем нь хүртээмжтэй, үр ашигтай байна.
- Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн хооронд шударга өрсөлдөөн явагдана.
- Бага болон их дүнтэй төлбөрүүдэд болон хөрөнгийн зах, мөнгөний зах, барааны зах дээрх гадаад валютын арилжаатай холбогдох төлбөрүүдэд зориулсан зохистой дэд бүтэц үйлчилнэ.
- Хуулийн эрх бүхий оролцогчид тэгш эрхийн үндсэн дээр банк хоорондын клирингийн болон төлбөр тооцооны үйлчилгээнд оролцох боломжтой.
- Банк хоорондын дотоодын үүрэг хариуцлагын дагуу төлбөр тооцоо тухайн өдөртөө хийгдэнэ.
- Төлбөрийн систем нь бэлэн байгаа төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хамгийн оновчтой байдлаар ашиглана.
- Төлбөрийн систем нь үнэт цаасны арилжаагаар төлбөрийн эсрэг нийлүүлэлт болон гадаад валютын арилжаагаар төлбөрийн эсрэг төлбөрийн цахим хэлбэрийг дэмжинэ.
- Арилжааны эцэст хийгдсэн төлбөр тооцооны хугацааны хожимдол нь олон улсын практикт нийцсэн байна.
- Төлбөрийн систем нь олон улсынхтай харьцуулахуйц байх ба олон улсын нийгэмлэг системийн үр ашигтай байдлыг дүгнэнэ.

Амжилтын хамгийн чухал хүчин зүйлүүд

- Хангалттай эрсдэлийн хяналтын хэмжигдэхүүн ба төлбөр эргэлт буцалтгүй, эцсийн байх.
- Төлбөр ба нийлүүлэлт нэг хугацаанд хийгдэх.
- Эрх зүйн үндсийн тогтвортой байдал, үндэсний зарчим, хэм хэмжээ тогтоосон баримт бичгүүд, процедурыг хатуу баримтлах.
- Төлбөрийн мэдээллийн аюулгүй байдал ба нууцлал, луйврыг илрүүлэх, түүнээс хамгаалах үр дүнтэй арга хэмжээг авч байх.
- Улс орны бүх ард иргэдэд хүртээмжтэй төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээний тохиромжтой нэр төрөлтэй байх.
- Төлбөрийн системийн тодорхойлолтын талаар олон нийт мэдлэгтэй байх.

Стратеги

- Төлбөрийн системийн бүх оролцогчдын үүрэг, хариуцлагыг таниулах.
- Төлбөрийн системийн харилцаан дахь төв банкны хуулийн ёсны бүрэн эрхийг дахин хянаж үзэх.
- Төлбөрийн системийн стандартыг тогтоох, хил дамнасан/валютын захын дадал туршлагын талаар тойм гаргах.
- Клирингийн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан зохицуулалтын суурь үндэстэй байх.
- Ил тод, эрх тэгш хандалтын нөхцлийг бүрдүүлэх.
- Дэд бүтцэд хамтын хөрөнгө оруулах ажлыг гүйцэтгэхэд оролцох тухай хэлэлцээрийг боловсруулах.
- Клирингийн үйл ажиллагаанд зээлийн эрсдэлийг хязгаарлах арга хэмжээ авах.
- Бүс нутаг дахь санхүүгийн байгууллагууд, банкуудтай харилцаа холбоотой байх, төлбөрийн системийн талаар холбогдох асуудлуудыг хэлэлцэх, шийдвэрлэх форум байгуулах.

Төлөвлөлтийн процесс дахь цаг хугацааны болон санхүүгийн нөөцийн хөрөнгө оруулалт нь шинэчлэлтийн хөтөлбөрийн хамрах хүрээ, хэр хэмжээнээс шалтгаална. Гэхдээ бүрэлдэхүүн хэсгүүд хоорондоо уялдаа холбоотой байдгаас системд үйлчилж буй тодорхой нэг хэсгийн өөрчлөлт нь нийт системд чухал нөлөө үзүүлж болох юм. Удирдамж 3-аас удирдамж 6-д заасанчлан, стратеги төлөвлөгөөний үндсэн зарчмууд ба төлбөрийн системийн шинэтгэлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох нь зохицуулалтын одоо байгаа зохицуулалтын өөрчлөлтөд ч, системийн суурь өөрчлөлтөд ч адил байна: (i) системийн өргөн хүрээнд авч үзсэнээр тодорхой санаачлагуудыг төлөвлөх; (ii) одоо байгаа болон үүсч буй төлбөрийн хэрэгцээ, боломж дээр үндэслэсэн, төлөвлөгдсөн өөрчлөлт бүхий ирээдүйн системийн төсөөллийг бий болгох; (iii) хөгжлийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд зэрэгцсэн болон дараалсан шаардлагын үндсэн дээр тодорхой төслийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох ба тэдний өртөг болон нийт системийн урт хугацааны ашгийг бодитоор үнэлэх.

Хэрэгжилт. Хөгжлийн стратеги төлөвлөгөө нь шинэтгэлийн тодорхой санаачлага дахь үндэсний төлбөрийн системийн хөгжлийг зохицуулагч болон төвлөрүүлэгч хэрэгсэл юм. Гэхдээ энэ нь нилээн хэдэн жилийн турш дахь төлбөрийн системийн хөгжилд анхаарч, чиглэлийг тодорхойлох явцдаа төлөвлөлтийн хэмжээнд өөрчлөлтийн гол хүчин зүйл болон нөөцүүд дэх урьдаас таамаглаагүй мэдрэгдэхүйц өөрчлөлтийн нөлөөнд автагдахгүйгээр хатуу хөдөлбөргүй байж чаддаггүй. Энэ тохиолдолд, төлөвлөлтөд зарим нэг өөрчлөлт орж, шинэтгэлийн санаачлагын тэргүүлэх чиглэлүүдэд өөрчлөлт хийх шаардлагатай болно. Гэхдээ хөгжлийн шаардлага болон системийн иж бүрдлийн өргөн хүрээтэй төсөөлөл дээр үндэслэсэн төлөвлөгөө нь үндэсний төлбөрийн системийг төлөвлөсөн чиглэлд урагшлах бололцоог түүнд олгож чадахуйц хангалттай уян хатан байж болно.

(i) *Аналитик арга*

“GAP” шинжилгээ ба “өртөг-эрсдэл-ашиг” шинжилгээ гэсэн хоёр үндсэн аналитик арга байдаг. Эдгээр нь шинэтгэлийн ашигтай санаачлага болон тэдгээрийн давамгайлах чанарыг тодорхойлоход тусалдаг.

“GAP” шинжилгээ: Шинэтгэлийн санаачлагыг тодорхойлох

Шинэтгэл хийх шаардлагатай үндэсний төлбөрийн системийн тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох зорилгоор энэ аргыг хэрэглэдэг. Шинжилгээний эхний хэсэг нь төлөвлөлтийн өмнөх удирдамжуудад үзсэнчлэн, одоо үйлчилж буй системийн үнэлгээний шинжилгээ болон бизнесийн хэрэгцээ, шаардлагын шинжилгээний гол үр дүнгүүдээс заримыг харьцуулж үздэг. “GAP”-ийн энэ харьцуулсан шинжилгээгээр илэрсэн үр дүн нь шинэтгэл хийх шаардлагатай системийн дэд бүтцийн болон эрх зүйн бүрэлдэхүүн хэсгүүдийг заадаг. Түүнчлэн, энэ шинжилгээ нь одоо үйлчилж буй системийн ямар бүрэлдэхүүн хэсэг ирээдүйн төлбөрийн хэрэгцээний ямар хэсгийг хангаж чадахыг тодорхойлдог.

Шинжилгээний хоёр дахь хэсэгт, эдийн засгийн чадавхи нь төлбөр тооцооны системд төлбөрийн шинэ бүтээгдэхүүн, технологи, үйлчилгээг дэмжиж чадаж байгаа эсэхийг үнэлдэг байна. Тодорхой боломжуудыг үнэлснээр хянан үзэж болох зүйл гэвэл жишээлбэл, төлбөрийн системийн тодорхой төрлийн шинэтгэлийг хэрэгжүүлэхэд хүний болон хөрөнгийн шаардагдаж байгаа болон одоо байгаа нөөц, мөн тодорхой санаачлагуудын санхүүжүүлэлтэд зардал хуваарилах боломжууд юм. “GAP” нь хөгжлийн хөтөлбөр дэхь санаачлагуудыг хэрэгжүүлэхэд ирээдүйн хэрэгцээ, боломж хоёрын аль нь илүү ашигтайг тодорхойлоход тусална.

Өртөг-эрсдэл-ашигийн шинжилгээ: санаачлагын тэргүүлэх чанарыг тодорхойлох.

“GAP” шинжилгээ нь, хэзээ тэдгээрийг явуулах вэ гэдгийг тодорхойлохгүй, харин ямар шинэтгэл явуулах нь төлбөр системд хэрэгцээтэй байгааг тодорхойлоход тусална. Амьдрал дээр бүх боломжтой санаачлагууд нэгэн зэрэг биелэгддэггүй, ялангуяа, шинэтгэл нь удаан хугацааных бол. Хэрвээ өргөн хүрээний хөгжлийн төлөвлөгөөтэй байхад хөгжлийн нөөц энэ үед хязгаарлагдмал бол шинэтгэлийн санаачлагын тэргүүлэх чанар нь өргөн хэмжээний хэрэгцээтэй, тэдгээрийг хангах төлбөрийн системийн бололцоотой, тухайлан төлөвлөж байгаа зардалтай, тэдгээрийг хангах янз бүрийн холбогдох талуудын бүлэглэл болон системийн ашиг, эрсдэлтэй уялдаатайгаар тусгайлан тогтоогддог. Өртөг-эрсдэл-ашигийн шинжилгээ нь “GAP” шинжилгээний үр дүнд илэрсэн шинэтгэлийн боломжит санаачлагын тэргүүлэх чанарыг тодорхойлоход тусалдаг. Энэ шинжилгээ нь цаг хугацааны хуваарь, санхүүгийн болон бусад нөөцийн үүргийг, түүнчлэн тэргүүлэх чанарын санаачлагыг хэрэгжүүлэхэд янз бүрийн холбогдох талуудын өөр бусад үүрэг хариуцлагыг тодорхойлоход тусална.

“GAP”-ын шинжилгээ нь системийн эрх зүйн болон дэд бүтцийн зохицуулалтын суурь шинэтгэл дэх хэрэгцээг тодорхой заадаг бол “өртөг-эрсдэл-ашигийн” шинжилгээ нь тэргүүлэх чанарын санаачлагын харьцангуй бага зардалтай, тодорхой мэдэгдэхүйц

өөрчлөлтийг тодорхойлдог. Эдгээр нь одоо үйлчилж буй системийн дэд бүтцийн болон эрх зүйн тодорхой өөрчлөн байгуулалтад ихэнхдээ хамаарагддаг. Хөгжлийн арга зам болсон ийм өөрчлөн байгуулалтыг шууд хайхрахгүй байж болохгүй. Төлбөрийн системийн хөгжил нь одоогийн үйлчилж буй төлбөрийн системд үндэслэгдсэн, шинээр үүсч буй төлбөрийн хэрэгцээг үр ашигтай хангах зорилготой аажим хувьсах процесс юм.

Гэхдээ зөвхөн өртөгт анхаарлаа хандуулах ёстой биш. Төлбөрийн системийн дэд бүтэц болон эрх зүйн суурь шинэтгэлийн ашиг, тэдгээрийг үл гүйцэтгэснээс учрах эрсдэл, ялангуяа системийн эрсдэл нь санхүүгийн системийн тогтворгүй байдалд хүргэсэн нь төлбөрийн системийн шинэтгэлд шинжилгээ хийхийн чухал ач холбогдолтойг харуулах ёстой.

(ii) Харилцан буулт хийн тохиролцоо замаар зөвшилцөлд хүрэх

Холбогдох талуудын төсөвлөгдсөн өртөг, эрсдэл болон давуу талууд, хэрэгцээт үйлчилгээ болон нөөцийн хэрэгцээний ялгаанаас шалтгаалж өөрчлөлт шинэчлэлтийн тэргүүлэх байр суурин дээр тохиролцоонд хүрдэг. Тэргүүлэх байр суурийн ялгаа нь холбогдох талуудын тодорхой бүлэглэл дотор байдаг. Жишээлбэл, банкны холбоонд өөр өөр банкууд төлбөр тооцооны системийн өөрчлөлт шинэчлэлтэд өөр өөр тэргүүлэх байр суурьтай байдаг. Тэд маш олон янзын харилцагчдад үйлчилдэг ба хөрөнгийн нөөцийн янз бүрийн түвшинтэй байна. Жишээ нь, зарим банкууд бүхэлдээ харилцагчид болон орон нутгийн жижиг бизнес эрхлэгчдэд анхаарч байхад бусад банкууд их хэмжээний харилцагчдын хүрээ, арилжааны, үйлдвэрлэлийн болон гадаадын байгууллагуудад нэлээд анхаарлаа хандуулдаг. Ерөнхийдөө, зөвшилцөл гэдэг нь холбогдох талуудын хүсэл эрмэлзлийн дагуу ихэвчлэн өргөн хүрээний зөвлөлдөх ажиллагаа шаардсан бүгдэд хүлээн зөвшөөрөгдсөн тохиролцооны шийдлийг олох явдал.

Шинэтгэлийн нэгдсэн хөтөлбөрийн үзэл баримтлалыг хадгалах, хэлбэржүүлэхийн тулд шинэтгэлийн тодорхой санаачлагад зэрэглэл тогтоох, цэгцлэх нь чухал ач холбогдолтой. Одоогийн үйлчилж буй систем дэх ярвигтай асуудлуудыг шийдвэрлэх нь шинэтгэлийн ач тустай давуу тал гэдэг нь эргэлзээгүй юм. Илэрхий түвэгтэй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн шинэтгэлүүд нь илүү эрсдэл үүсгэлгүйгээр гол холбогдох талуудын ашигтай байдлыг нэмэгдүүлэх, зөвшилцөлд хүрэхэд хамгийн амар хялбар байх нь олонтаа бөгөөд энэ нь ирээдүйн шинэтгэлийн эхлэл нь болж болох юм. Төлбөрийн картын системийг өргөжүүлж байгаа болон клирингийн төвийн дотоод уялдаа холбоо, автоматжуулалтыг боловсронгуй болгож буй санаачлагууд, түүнчлэн ашгийг том жижиг банкуудыг оруулаад бүх холбогдох талуудад хангалттай хуваарилж байгаа зэрэг нь боломжийн эхлэл болж чадна. Гэхдээ бусад төслүүд нь холбогдох талуудын бүлгүүдийг илүү нарийн шилж авснаар үлэмж илүү ашигтай байж болох юм. Тиймээс шинэтгэлийн бусад төслүүдийг хэрэгжүүлэхдээ, янз бүрийн банкуудын бүлэглэл, тэдний үйлчлүүлэгчдэд зардал, эрсдэл, ашиг хуваарилалтын нарийн үнэлэмжийг хийх шаардлагатай.

(iii) Төв банкны оролцоо

Төлбөрийн системийн хөгжилд өгсөн шинжээчийн дүгнэлт хязгаарлагдмал үед төв банк нь “GAP” болон “өртөг-эрсдэл-ашиг”-ын шинжилгээг хийж, нарийвчлан боловсруулахын тулд гадаадын шинжээчдийг хөлслөн тэднээс зөвлөгөө авах, чиглүүлэх, заавар зөвлөгөөгөөр хангах, зохион байгуулах үүрэг хүлээдэг. Гэхдээ төв банк болон системд оролцогч бусад холбогдох талууд л хөгжлийн хөтөлбөрийн эцэст хариуцлага хүлээхээс биш, зөвлөхүүд хариуцлага хүлээхгүй. Үндэсний төлбөрийн системд онцгой ач холбогдол бүхий хөгжлийн хүчин зүйлс ба улсын орны хэрэгцээг тэд бүхнээс илүүтэйгээр мэргэжлийн талаас нь мэддэг. Түүнээс гадна төв банк нь удирдлагыг өөртөө авсан байсан ч, хүрэхэд бэрх шинэтгэлийн давуу эрхтэй үндсэн оролцогч талууд хоорондоо зөвшилцсөн тохиолдолд бүрэн эрх мэдлээ ашигласан ч, тэдний зохих дэмжлэг, зөвлөгөө авах, зөвшилцөлд хүрэхгүйгээр шинэтгэлийг дур мэдэн тулган хүлээлгэхээс аль болох зайлсхийх хэрэгтэй.

Зарим тохиолдолд салбарын санаачлагаар зарим шинэтгэлийг хийдэг. Системийн чанартай хөгжлийн санаачлагыг төлөвлөх ба тодорхойлох талаар зөвлөмж өгөхөд зориулсан холбогдох талуудын хоорондын зөвлөгөөнд төв банк ядахдаа л оролцох нь зүйтэй. Хөгжлийн талаарх хамгийн эцсийн санал нь одоогийн болон цаашдын хэрэгцээ, боломжийн талаар аль болох нэгдмэл саналыг илэрхийлсэн байх ёстой.

Удирдамж 6. Гол нь хэрэгжүүлэх: *стратеги төлөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэх баталгаатай байх ёстой.*

Тайлбар: Төлбөрийн системийг шинэчлэх төлөвлөгөөний төслийн амжилт нь, хэрэгжүүлэх процессыг нарийн зохион байгуулалттай, сайн удирдлагатай байхыг шаарддаг. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэх стратегид төслийг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөөг зайлшгүй оруулах ба тэр хэмжээгээр хөгжлийн төслийн өвөрмөц шинж чанар ил тод болдог. Төслийн хэрэгжүүлэлтэд ерөнхийдөө янз бүрийн холбогдох талуудын бүлэглэлийг татан оролцуулдаг ба харин хэрэгжүүлэх төлөвлөгөө нь тэдний төслийн хүрээнд гүйцэтгэх үүрэг хариуцлагыг тодорхойлж өгдөг.

Төлбөрийн системийн шинэтгэлийн төслийг хэрэгжүүлэх үр дүнтэй төлөвлөгөө нь дараахь зүйлийг агуулна: (i) төслийн удирдлагын зохистой зохицуулалт; (ii) ахиц дэвшлийг хэмжих үе шат; (iii) нарийн тодорхойлогдсон үр дүн; (iv) болзошгүй нөхцөл байдал, түүнийг шийдвэрлэх арга зам; (v) үр дүнтэй “нэвтрүүлэх (“rollout”)” стратеги; (vi) бодит нөөц болон хөрөнгө оруулалтыг нөхөн сэргээх, сайжруулах төлөвлөгөө бүхий санхүүгийн удирдлагын стратеги. Шигтгээ 10-г, төлбөрийн системийн шинэтгэлийн үндсэн төслийн зохион байгуулалт ба ерөнхий удирдамжид тавигдах үндсэн шаардлагуудыг харуулав.

Шигтгээ 10

Төслийн хэрэгжүүлэх зохион байгуулалтын шаардлагууд

Төслийн хэмжээнээс хамааран түүнийг хэрэгжүүлэх, үр дүнтэй зохион байгуулахад тавигдах шаардлагууд:

- Төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх нэр нөлөө бүхий дээд тушаалын дор хаяж нэг спонсортой байх;
- Гол холбогдох бүлэглэл бүрээс нэг төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй, төслийн гол шийдвэрийг гаргадаг төслийн зохицуулах хороотой байх;
- Төслийг хянах, зохицуулах хороонд төслийн явцыг тайлагнах, үүссэн асуудлыг шийдвэрлэхэд нь туслах төслийн удирдагчтай байх;
- Төслийн удирдлага нь ерөнхий захиалагчийн хувьд төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний өдөр тутмын удирдлагын хариуцлагыг хүлээдэг байх.
- Төслийн удирдлагын болон удирдагчийн бүрэн эрх, үүрэг, хариуцлагын хэмжээг нарийн тодорхойлсон байх;
- Төслийн багт холбогдох талуудын бүлэглэл, Дэлхийн банк, ОУВС, ОУТГБ зэрэг олон улсын байгууллагууд, мөн төв банкууд, түүнчлэн бусад хувийн зөвлөхийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудаас шаардлагатай шинжээч оруулсан байх;
- Төслийн багийн зохицуулагч нар нь бүлэглэлүүдийн тодорхой санаачлагын талаар төсөөлөлтэй, удирдах чадвартай байх;
- Төслийн багийн зохион байгуулагчдаас эхлээд төслийн удирдлага, улмаар төслийн удирдагч, зохион байгуулах хороогоор дуусгавар болгосон шат дамжлагаар тайлан гаргах болон тайлан, мэдээгээ солилцож байх нарийн хуваарьтай байх.

Дээр дурьдсан төслийн байгууллагууд нь ерөнхийдөө хөгжлийн том хэмжээний төсөлд хамаарагддаг. Гэхдээ хэрэгжүүлэх төлөвлөгөөний үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд болон хэрэгжүүлэх шаардлагууд нь жижиг хэмжээний төслийн санаачлагад ч мөн тулгардаг чухал асуудал байдаг. Гол ялгаа нь шаардлагатай нөөцийн хэмжээнд байдаг. Төлбөрийн системийн маш өвөрмөц бүрэлдэхүүн хэсэгт анхаарсан санаачлага маш хязгаарлагдмал хэмжээтэй цорын ганц төслийн багийг хамардаг. Төслийг санхүүжүүлэгч нь зохион байгуулах хорооны үүргийг өөрөө авдаг ба харин төслийн удирдлагын, удирдагчийн болон зохицуулагчийн үүргийг нэг хүн гүйцэтгэдэг. Гэхдээ төслийн багийн үүрэг, хариуцлагын хэмжээ, гишүүдийн бүрэн эрх нь бүгд нарийн тодорхойлогдсон байх шаардлагатай.

Хэрэгжилт: Төслийн төлөвлөлт, зохион байгуулалтын хажуугаар төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь төслийг дэс дараатай нэвтрүүлэх боломж болон нөөцийн ашиглагдах байдлаас ихээхэн шалтгаална.

(i) *Шаардлагатай нөөцийг олж авах*

Төлбөрийн системийн шинэтгэлийн төслийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн ур чадвар удирдлагын хүрээнд ч, төлбөрийн системийн хүрээнд ч шаардлагатай. Эдгээр шинжээчдээс шаардагдах хамгийн чухал үйлчилгээ нь ирээдүйн хөгжил дэвшилд чухлаар

тавигдах дотоодын шинжээчийн мэдлэгийг дээшлүүлэхэд тус дөхөм болгох зорилгоор төлбөрийн системийн талаарх мэдлэг чадвараасаа хуваалцах, зааж өгөх явдал юм.

Төслийн тодорхой зорилгыг шийдвэрлэхийн тулд байгаа санхүүгийн болон хүний нөөц, бусад нөөц бололцоогоо урьдчилан тодорхойлох хэрэгтэй. Банкны холбооноос хууль эрх зүй, төлбөрийн үйл ажиллагаа, төслийн удирдлагын мэргэжилтэн гэх зэргээр шинэтгэлийн төсөлд эдгээр шинжээчдийн нөөцийн зарим нь холбогдох талуудаас дайчлагдан оролцож болно. Бүх үндсэн төлбөр авагч этгээдүүдээс зарим нөөцийн үүргийг олж авах нь чухал. Эдгээр үүргүүд нь шинэтгэлээс хүлээгдэж буй үр дүн болон нөөцийн харьцангуй хүртээмжийг илэрхийлж болох юм. Гол холбогдох талуудаас авч байгаа санхүүжилтийг аль болохоор ихээр, төслийг хэрэгжүүлэх үйл явц эхлэхийн өмнө наад зах нь тэдний өөрсдийнх нь үйл ажиллагаатай шууд холбоо бүхий төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд маш нарийн тодорхойлсон байх хэрэгтэй. Үлдэж буй хэрэгцээний санхүүжилтийг Дэлхийн банк мэтийн гадаадын албан ёсны байгууллага болон улсын секторын тусламжтайгаар хангаж болох юм.


(ii) Стратегийн хэрэгжилт (rollout strategy)-ийг тодорхойлох

Төслийг хэрэгжүүлэх (rollout) стратеги нь түүний үндсэн шинж чанараас шалтгаална. Төлбөрийн шинэ хэрэгсэл, технологийн өөрчлөлт, дэд бүтцийн горимын зарим нэг төрлийн шинэтгэл зэрэг санаачлагад зориулсан анхны туршилт хэрэгжих боломжтой, ашигтай байж болно. Энэ нь нийт систем даяар шинэтгэлийг хэрэгжүүлэхийн өмнө техникийн ямар нэгэн бэрхшээлтэй асуудлыг илрүүлэх боломжийг өгдөг. Жинхэнэ систем даяар хэрэгжүүлэх шинэтгэл нь тодорхой бүс нутгаар эсвэл холбогдох талуудын бүлгүүдээр үе шаттай эсвэл дэс дараалсан байж болно.

Эрх зүйн болон зохицуулалтын, мөн зах зээлийн шинэтгэлтэй холбоотой төсөлд анхны туршилт болон тууштай нэвтрүүлэх стратеги нь ерөнхийдөө хэрэгжих боломж багатай. Шинэ хуулийн хэрэгжилт, өөр бусад эрх зүйн акт болон зах зээлийн практик нь төлбөрийн үйлчилгээний зохих зах зээл дээр болон нийт бүс нутагт ерөнхийдөө нэгэн зэрэг болдог. Мөн зах зээлийн нийт оролцогчдод зориулан “тоглолтын талбар”-ын түвшинг хадгалах зорилгоор түүнийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэхийг байнга шаарддаг. Гэхдээ шинэ хууль, дүрэм, зохицуулалт тогтоосон баримт бичгүүд хэрэгжиж эхлэх хүртэл шилжилтийн интервал буюу “хөнгөлөлттэй үе” нь тэдгээрт товлосон хугацааг баримтлахад тус дөхөм болно. Энэ эрх зүйн өөрчлөлтөд нөлөө үзүүлдэг хувь хүн болон байгууллагад өөрийн системээ шинэ дэглэмийн шаардлагатай зохицсон журамд оруулах хугацаа байх ба ингэснээрээ системийн санхүүгийн болон том хэмжээний гүйлгээний эрсдэлийг бууруулна.

Төлөвлөгдсөн маркетинг болон бүтээгдэхүүний тухай мэдээлэл нь хэрэгжүүлэх стратегийн бас нэг шийдвэрлэх хэсэг юм. Шинэ төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээний тодорхой чанарын тухай, хэрэглэгчдийн эрсдэл ба зардалтай харьцуулсан түүний ерөнхий үр ашгийн тухай, зохих үйлчилгээг шууд авах ба ашиглах талаар журмын тухай хэрэглэгчдэд мэдээлэх нь хэрэгжүүлэх процесст түлхэц өгдөг.

Зураг 3-т хөгжлийн төслийн хэрэгжүүлэлтэд зориулан Баруун Африкийн улсын Төв банкны (ВСЕАО) оролцоотойгоор RTGS төслийг хэрэгжүүлэх Гантта-ийн графикийг харуулав.



(iii) Төв банкны оролцоо

Төслийн хэрэгжүүлэлтэд удирдагч болон хөдөлгөгч хүчний хувиар төв банк үнэтэй нэмэр үзүүлж чадна. Тэрээр шаардлагын дагуу төслийн багийн ивээн тэтгэгч, зөвлөх, зохион байгуулагч мөн оролцогчийн үүргийг гүйцэтгэдэг. Мөн төв банк нь төслийн зохион байгуулах хороонд оролцож, улсын санхүүгийн салбар, олон улсын байгууллагуудаас шинжээчдийг татан оролцуулах ажлыг зохион байгуулдаг. Төв банк нь төлөвлөлт хийх замаар шинэтгэлийн санаачлагыг хэрэгжүүлэхэд, мөн төслийн төлөвлөгөөний бусад хэсгүүдийн талаарх бодлоготой өөрийн үйл ажиллагааны дэг журмыг нийцүүлэхэд шаардлагатай байгаа өөрчлөлтийг хийх ажлыг зохицуулж тус нэмэр болж чадна.

Гэхдээ төв банк нь төлбөрийн системийн шинэтгэлтэй холбогдох бүх зардлыг хариуцах албагүй. Тэр тусмаа ашиг нь нийт системийн шинж чанартай байхад. Энэ ашгийг ихэвчлэн системийн оролцогч холбогдох талууд хүртдэг. Хэрвээ тэд ашиг хүртэхийн зэрэгцээ үлэмж хэмжээний зардал, эрсдэл хүлээж байвал нөөцийн төсөв зохиох, давуу талыг тооцохдоо нэлээн нарийн нягт ханддаг. Төв банк нь хаана тэд шинэ систем, үйлчилгээ ашиглахад шууд оролцож байна тэнд зохих зардлаа шингээхийг тэдэнд зөвшөөрч санхүүжилтийн болон үнийн стратегийг боловсруулах боломжийг анхаарч үзэх хэрэгтэй.

Шигтгээ 11-д Индонезийн төлбөрийн системийн шинэтгэлийн хэрэгжүүлэлт, төлөвлөлт дэх төв банкны үүргийг үлгэрлэн үзүүлэв.

**Улс орны жишээ: Индонезийн үндэсний төлбөрийн системийн
шинэтгэлийн хөтөлбөрийн “Blue Print” төсөл**

Индонезийн шинэтгэлийн хөтөлбөрийн төсөл нь 1998 онд төв банкны санаачлагаар газар хоорондын төсөл болсон. Индонезийн үндэсний төлбөрийн систем (ИУТС)-ийн Blue Print нь үндсэн баримт бичиг бөгөөд дараахь байдлаар тодорхойлогдоно:

- Төлбөрийн системийн бүрэлдэхүүн;
- Бүрэлдэхүүнд оролцогч бүрийн гадаад, дотоод хөгжлийн асуудлууд;
- Цаг хугацааны тодорхой үед эдгээр асуудлуудыг шийдвэрлэх арга, төслүүд;

Стратеги төлөвлөгөөний баримт бичиг нь төлбөрийн системийн хөгжлийн асуудлуудыг авч үзсэн ба хөтөлбөр батлагдсанаас хойш 10 жилийн хугацаанд нэвтрүүлэх 22 төсөлтэй бөгөөд эдгээр төслүүд нь дараахь асуудлуудад чиглэгдсэн байна:

- Цахим төлбөрийн хэрэгслүүдийг хөгжүүлэх төслийг багтаасан төлбөрийн хэрэгслүүд.
- Зохицуулалтын баримт бичгүүд, удирдамжуудыг боловсруулах төслүүдийг агуулсан эрх зүйн орчин нь дараахь зүйлд үйлчилнэ:
 - Цахим төлбөрийн хэрэгслийг хуульчлах;
 - Мөнгөн гүйлгээ хийж буй бүх талуудын гэрээгээр хүлээсэн эрх, үүргийн харилцааны ил тод, тодорхой байдал;
 - Клирингийн болон төлбөр тооцооны зохицуулалтын бусад хэсгүүд болон сүлжээг хуульчлах;
- Мэдээллийн технологийн дэд бүтцийн төсөл нь дараахь зүйлд чиглэсэн байна:
 - Харилцаа холбооны дэд бүтэц;
 - Аппаратын техник хангамж, програм хангамжийг сайжруулах;
 - Төлбөрийн гарцын мэдээллийн нууцлалын стандарт;
- Төлбөрийн болон төлбөр тооцооны эрсдэлийн төслүүдэд:
 - RTGS системийг хөгжүүлэх;
 - Клирингийн сүлжээг шинэчлэх;
 - Хил дамнасан төлбөрийг хурдасгах;
- Тусдаа хяналтын нэгжтэй Төлбөрийн системийн газрыг Индонезийн банкинд байгуулах, түүнчлэн Үндэсний төлбөрийн форумыг зохион байгуулах тухай асуудлыг хамарсан үндэсний асуудал.
- Картын төлбөрийн янз бүрийн операторуудын хооронд холбоо тогтооход чиглэгдсэн төсөл бүхий үр ашгийн асуудлууд.

Сүүлийн 6 жилийн хугацаанд 18 төсөл хэрэгжсэн байна.

Одоо Индонезийн банк нь илүү найдвартай, үр ашигтай үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхэд чиглэсэн шинэ төслүүдтэй зэрэгцүүлэн эхний төлөвлөгөөнөөс үлдсэн төслүүдийг нэгтгэсэн үндэсний төлбөрийн системийн хоёр дахь хөтөлбөрийг боловсруулах үйл ажиллагааг явуулж байна.

Төлбөрийн системийг хөгжүүлэх төлөвлөгөөний талаарх санал болгож буй лавлагааны материалууд:

Cirasino, M. (2004): “Model of country assessment report for the clearing and settlement system”, *Western Hemisphere Initiative Working Paper no. 4*, April.

Committee on Payment and Settlement Systems (2003): *Payment and settlement systems in selected countries*, Bank for International Settlements, April.

——— (2005): *Statistics on payment and settlement systems in selected countries*, Bank for International Settlements, March.

European Central Bank (2001): *Payment and securities settlement systems in the European Union*, June.

——— (2002): *Payment and securities settlement systems in accession countries*, August.

EMEAP (2002): *Payment Systems in EMEAP Economies*, Executives’ Meeting of East Asia-Pacific Central Banks and Monetary Authorities, July.

Southern African Development Community (2002): *Guide to developing a strategic framework for payment system modernisation*, SADC Committee of Central Bank Governors, April.

3.3 Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх

Төлбөрийн системийн шинэтгэлийн хөтөлбөр нь ихэвчлэн үндсэндээ дэд бүтцийг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулдаг. Гэхдээ туршлагаас харахад эрх зүйн шинэтгэлийг хамтатган хийх шаардлага гардаг. Төлбөрийн системийн эрх зүйн тогтолцоог шинэчлэх, хөгжүүлэх хариуцлага төв банк, банкуудын холбоо түүнчлэн банкны болон төлбөрийн системийг хөгжүүлэх төрийн бодлогод хамааралтай эрх мэдэл бүхий бусад байгууллагуудад адил ногдоно.

Төлбөрийн шилжүүлгийг гүйцэтгэх зохион байгуулалтын зохицуулалт, дадал туршлага, хууль дүрэм зэргийг агуулсан үндэсний төлбөрийн системийн эрх зүйн тогтолцоог өргөн хүрээтэйгээр тодорхойлдог. Энэ хэсгийн удирдамж нь дараахь зүйлсийг анхаарах болно: (i) төлбөрийн үйлчилгээн дэх зах зээлийн зохицуулалт; (ii) холбогдох талуудтай зөвлөлдөх механизм; (iii) төлбөрийн системд тавих хяналт, системд үзүүлж буй нөлөөллийг зохицуулах; (iv) төлбөрийн талаарх хуулийн зохицуулалт ба эрх зүйн тогтолцоо.

Удирдамж 7. Зах зээлийн хөгжлийг дэмжих: *төлбөрийн үйлчилгээний зах зээлийн зохицуулалтыг бэхжүүлэн, өргөжүүлэх нь үндэсний төлбөрийн системийн хөгжлийн гол хэсэг болдог.*

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээний найдвартай, үр ашигтай зохицуулалтыг хөгжүүлэх явдал хэрэглэгч болон үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд хамгийн чухал. Зах зээлийн зохицуулалт нь төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээний үнэ, мөн бүтээгдэхүүн, тэдгээрийг үйлчилгээ үзүүлэгчээс хэрэглэгчдэд хүргэлт зэргийг зохицуулдаг. Үүнд үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчдийн хоорондын төлбөрийн үйлчилгээ болон гүйлгээг зохицуулах журам заавар, хоорондын гэрээ, хэлэлцээр багтана. Үндэсний төлбөрийн систем хөгжихийн хэрээр төрөл бүрийн төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ төдийгүй, үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчдийн хүрээ мөн өргөжих болно. Үүний үр дүнд чухал ач холбогдол бүхий төлбөрийн үйлчилгээний зах зээл нь ерөнхийдөө бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны хувьд илүү төрөлжиж чадна. Энэ нь төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээг өргөжүүлэх зах зээлийн зохицуулалтаас хамаарна.

(i) Зах зээлийн зохион байгуулалт, харилцан хамаарал

Төлбөрийн үйлчилгээ болон үйлчилгээний зах зээлийг ерөнхийд нь дараахь байдлаар 2 ангилдаг. Үүнд: (i) төлбөрийн дэд бүтэц дэх “бөөний” төлбөрийн зах зээлийн зохицуулалт; (ii) эцсийн хэрэглэгч нарт зориулсан “жижиглэнгийн” гүйлгээний зах зээлийн зохицуулалт. Санхүүгийн байгууллагуудад үзүүлж буй клирингийн болон төлбөр тооцооны үйлчилгээ нь бөөний төлбөрийн үйлчилгээний зах зээлийн жишээ юм. Жижиглэнгийн буюу эцсийн хэрэглэгчийн зах зээлийг картын төлбөр болон чекийн, дансаар эсвэл интернэт болон гар утсаар хийх төлбөрүүд зэргээр төсөөлж болох юм.

Эдгээр нь тус бүрдээ өөр өөрийн онцлогтой төлбөрийн үйлчилгээ, бүтэц, зах зээлийн шинж чанаруудтай байна.

Эдгээр зах зээлүүд хоорондоо маш нягт харилцан хамааралтай байдаг. Тодорхой төлбөрийн үйлчилгээний зах зээл дээр хэрэглэгч болдог ижил төрлийн санхүүгийн байгууллагуудын олонх нь бусдад үйлчилгээ үзүүлэгч байж болно. Зарим тохиолдолд, төлбөрийн үйлчилгээ болон тэдгээрийн зах зээлүүд нь нэг нь нөгөөдөө нэмэлт болж байдаг. Жишээ нь, жижиглэнгийн гүйлгээний зах зээл дээр харилцагч нартаа дебит картны үйлчилгээ үзүүлж буй банк нь бусдаас банк хоорондын клирингийн үйлчилгээ авч ашигладаг. Бусад тохиолдолд, төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээ нь зах зээл дээрх орлох хэрэгсэл эсвэл үйлчилгээ болдог. Жишээ нь, янз бүрийн кредит картын брэндүүд буюу чек болон кредит картууд. Нэмж хэлэхэд, жижиглэнгийн төлбөрийн үйлчилгээний зах зээл дээр санал болгож буй үйлчилгээний үнэ болон түвшинд ерөнхийдөө бөөний гүйлгээний зах зээлээс нэмэлт үйлчилгээ олж авах өртөг болон орлуулах төлбөрийн үйлчилгээ үзүүлснээр хэрэглэгчээс авах шимтгэл, холбогдох хэрэглэгчийн эрэлт зэрэг нь нөлөөлдөг байна.

(ii) Зах зээл дээрх хамтын ажиллагаа болон өрсөлдөөн

Бүхий л төлбөрийн үйлчилгээний зах зээлийн зохицуулалт нь хамтын ажиллагаа болон өрсөлдөөний тодорхой зэрэглэлийг хамардаг. Жишээлбэл, бөөний гүйлгээний зах зээл дээр үзүүлдэг клирингийн болон төлбөр тооцооны үйлчилгээг ашигладаг санхүүгийн байгууллагууд ихэвчлэн тогтоосон үйлчилгээний стандарт, үйл ажиллагааны дүрэм, журам болон хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний аргачлалын хүрээнд хамтран ажилладаг. Мөн эдгээр нь өрсөлдөж буй дэд бүтцийн хоорондын харилцан ажиллах боломжийн стандартыг тогтоох талаар төлбөр тооцооны системийн операторуудтай хамтран ажилладаг. Эсрэгээрээ, эдгээр санхүүгийн байгууллагууд нь жижиглэнгийн гүйлгээний зах зээл дээр эцсийн хэрэглэгч нарт үзүүлж буй төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээгээнийхээ үнэ, эрсдэл хуваах зарчим болон үйлчилгээний гэрээгээрээ өөр хоорондоо өрсөлддөг.

Банкууд өрсөлдөгчдөө өөрийн харилцагчдыг алдаж болзошгүй учраас дангаараа хэтэрхий нэг талыг баримталсан төлбөрийн шинэ хэрэгсэл болон үйлчилгээг нэвтрүүлэх эсвэл заавар журманд өөрчлөлт оруулахыг хүсдэггүй. Хэдийгээр тэд бүх системд тодорхой ашиг гаргахыг харж байгаа ч ийм жишээ байсаар л байдаг. Иймэрхүү өрсөлдөөнт байдал нь хамтын, зохицсон ажиллагааг дэмжихэд олон нийтийн оролцоог бий болгох шаардлага үүсгэдэг. Иймээс төлбөрийн үйлчилгээний хөгжиж буй, үр ашигтай зах зээлийн сорилт нь зах зээл бүрийн өрсөлдөөн болон хамтын ажиллагааны зохистой тэнцвэрийг олох, дэмжих явдал юм. Төлбөрийн төрөл бүрийн үйлчилгээний зах зээл нь өөр өөр шинж чанартай бөгөөд эдгээр нь хамтын ажиллагаа, өрсөлдөөний тэнцвэрт үзүүлэх нөлөөгөөрөө ирээдүйн хөгжил, тогтвортой байдал болон үр ашгийг хязгаарлаж эсвэл дэмжиж байдаг.

(iii) Зах зээлийн бүтэц болон төлөв

Зах зээлийн оролцогчид нь хоорондоо сүлжээний дам нөлөө буюу “network externality” шинжтэй, онцгой харилцан хамаарал бүхий зарим зах зээлүүд хөгжих нь хамгийн хэцүү байдаг. Жишээ нь, дебит карт буюу дундын АТМ сүлжээ болон их дүнтэй төлбөрийн систем. Эдгээр сүлжээний харилцан хамаарал нь оролцогчдын хувьд нэгдсэн өртөг, эрсдэл болон үр ашгийг бий болгодог. Сүлжээнд шинэ оролцогч нэмэгдсэнээр хуучин гишүүдийн өртөг багасч шинээр ашиг олох боломжтой болно. Гэсэн хэдий ч, бусад дам нөлөө нь оролцогч бүрийг шинэ үйлчилгээний технологи, үйлчилгээний стандарт эсвэл сүлжээнд хамтран ажиллах боломжийн зохицуулалт зэрэгт хөрөнгө оруулахад саад болдог. Жишээ нь, хэрвээ оролцогч бүрийн шинэ техник, тоног төхөөрөмж буюу шинэ эрсдлийн хяналтын горимд хөрөнгө оруулах зардал эсвэл санхүүгийн эрсдлийг ирээдүйн олж авахаар хүлээгдэж буй ашигтай харьцуулж авч үзэхэд хэтэрхий их байвал тэдгээрт хөрөнгө оруулах сонирхол бага байж болох юм. Ямар ч гэсэн оролцогчдоос зөвхөн хэдхэн нь хөрөнгө оруулах дургүй байхад бусад нь ихэвчлэн үргэлжлүүлэх хүсэлгүй болдог. Тэдний хөрөнгө оруулалтаас олох ашиг нь бүхий л систем даяар хуваарилагдах ба хөрөнгө оруулалт нь холбогдох үйлчилгээний зах зээл дээр өрсөлдөж байгаа, хөрөнгө оруулаагүй системийн оролцогч нарт үр ашигтай татаас болдог байна. Ийм тохиолдолд хуваарилалт түүнчлэн хөрөнгийн болон үйл ажиллагааны зардлын нөхөн төлбөртэй холбоотойгоор бүх оролцогч нарын хувьд хамтын ажиллагаа нь шийдвэрлэх асуудал болдог.

Бага хэмжээний төлбөр гүйцэтгэдэг зарим байгууллагууд нь төлбөрийн дэд бүтцийн үйлчилгээг дэд бүтцийн сүлжээний шууд оролцогч нараар дамжуулан шууд бусаар олж авдаг. Хэдийгээр эдгээр бүх байгууллагууд эцсийн хэрэглэгчдэд үзүүлж буй үйлчилгээгээрээ зарим жижиглэнгийн зах зээл дээр өөр хоорондоо өрсөлддөг ч, өндөр үр ашигтай байхын тулд ихэвчлэн бөөний зах зээл дээр шууд бусаар оролцдог. Эдгээр шууд бус оролцогчид нь тохиролцсон гэрээний үнэ, үйлчилгээний түвшин, түүнчлэн эцсийн хэрэглэгчдийн зах зээл дээр шууд бус оролцогчдод өрсөлдөөний сул тал болж буй эрсдэл хуваах тухай хэлэлцээр зэрэг хамтын сонирхол бүхий шууд оролцогч байгууллагын эрсдлийг хүлээдэг. Бөөний зах зээлээс авах үйлчилгээгээр шууд бус оролцогчдыг хангах өрсөлдөөн нь энэ зах зээлийн эрсдлийг хязгаарлахад тустай байж чадна.

Өөр нэг жишээ бол ижил төстэй төлбөрийн дэд бүтцүүдийг нэг үйлчилгээ үзүүлэгчид нэгтгэх явдал юм. Энэ нь зах зээлийн оролцогчийн ойрын хугацааны үйл ажиллагааны зардлыг бууруулах ч ирээдүйд зардал хэмнэх, эрсдлийг багасгах эсвэл үйлчилгээг сайжруулах гэх мэт шинэ технологиудад хөрөнгө оруулах сонирхлыг бууруулах талтай. Бөөний зах зээлүүд дээр өрсөлдөж буй үйлчилгээ үзүүлэгчид нь хэрэглэгчдэд үзүүлж буй үйлчилгээний чанар болон үйлчилгээний технологийн шинэчлэлийг урамшуулж чаддаг. Гэхдээ банк хоорондын төлбөр тооцооны сүлжээ мэтийн одоо байгаа нэмэлт зохицуулалттай холбогдоогүй эсвэл бусад бүс нутгийн ижил төрлийн зохицуулалттай холбогдоогүй дэд бүтцүүд нь заримдаа төлбөрийн үйлчилгээний зах зээлийг хэдэн хэсэг

хувааж ч болдог байна. Хэрвээ зах зээлийн хэмжээ хязгаарлагдмал байвал бүхий л системд хэрэглэгчдийн ашиг сонирхол буурах ба хуваагдсан хэсэг бүрийн их хэмжээний үйл ажиллагааны өртөг өрсөлдөж буй системийн хэрэглэгчдийн зардалд нөлөөлнө.

Хэрэгжилт: Энэхүү удирдамжийг хэрэгжүүлэх стратеги нь үр ашигтай зах зээлийг зохицуулах дараахь 4 гол шинж чанарт анхаарах хэрэгтэй болгодог: (i) бие даасан болон харилцан холбоотой төлбөрийн үйлчилгээний зах зээлүүд дээрх үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчдийн хоорондын зохицол; (ii) зах зээл дээр үр ашигтай үнэ тогтох нөхцөл; (iii) төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээний талаарх зах зээлийн мэдээлэл, ил тод байдал; (iv) ижил төрлийн төлбөрийн үйлчилгээний зах зээлүүдэд хувь хүн болон байгууллагууд эрх тэгш оролцох боломж.

(i) Зах зээлийн зохицуулалтыг хөгжүүлэх механизм

Зах зээлийн зохицуулалт нь үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчдийг төлбөрийн үйлчилгээний нөхцөлийг зөвшөөрөх, түүнээс татгалзах болон харилцан зөвшилцөх боломжоор хангасан байхыг шаарддаг. Бодит байдал дээр, энэ нь зөвхөн бие даасан хэрэглэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн үндсэн дээр бус төлөөлөгч банк, бизнесийн болон хэрэглэгчийн бүлгүүдээр дамжуулан хэрэгждэг. Жижиглэнгийн болон бөөний үйлчилгээний зах зээл дээр үндэсний банкны холбоо мэтийн салбар бүлгүүд доторх хамтын ажиллагаа болон өрсөлдөөний хоорондын, мөн салбар болон хэрэглэгчдийн бүлгийн хоорондын зохистой тэнцвэр шаардагддаг. Банк болон бусад бүлгүүд зах зээл дээрх гүйлгээнүүдэд зориулсан зах зээлийн дүрэм журам, стандартуудыг боловсруулах замаар хамтран үр ашигтай төлбөрийн үйлчилгээний тогтолцоог хөгжүүлж чадна. Германы улсын Зээлийн Төв Хороог энэхүү хамтарсан бүлэглэлийн тод жишээ болгож Шигтгээ 12-т тодорхойлон харуулав.

Шигтгээ12

Улс орны жишээ: Герман улсын Зээлийн Төв Хороо /ЗТХ/

Банкны салбарын Зээлийн Төв Хороо /ЗТХ/ нь Германы банк болон төлбөрийн системийн асуудлуудыг хэлэлцдэг хамгийн чухал чуулгануудын нэг юм. ЗТХ-ны хүрээнд:

- Бизнесийн Удирдлагын Дэд Хороо нь төлбөр болон төлбөрийн системийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журмуудыг хариуцан ажилладаг;
- Автоматжуулалтын Ажлын Хэсэг (Бундесбанкны удирдлага дахь) нь төлбөрийн найдвартай болон үр ашигтай байдлыг бэхжүүлэх талаарх хэлэлцүүлгийг зохицуулдаг.

Бундесбанк нь банкны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай төлбөрийн асуудлаар нягт хамтран ажилладаг ба тэднээс хамаарч байдаг:

- Орчин үеийн дэвшилтэд технологи болон төлбөрийн системийн стандартуудыг санаачлан, боловсруулах;
- Бундесбанк болон Банкны холбооны гишүүдэд хуулийн дагуу ноогдсон төлбөр болон төлбөрийн боловсруулалтад хамаарах үйл ажиллагааны, техникийн, хууль тогтоомж стандартуудтай холбоотой бүхий л салбарын гэрээ хэлэлцээрийг боловсруулах.

Эдгээр бүлгүүдийн хамтын ажиллагааны тусламжтайгаар зах зээлийн хөгжилд оруулсан хувь нэмрүүдийг дурьдвал: (i) төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид зориулсан бизнесийг удирдах арга барил болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай салбарын хууль; (ii) төлбөрийн хэрэгслүүдийн стандартууд; (iii) төлбөрийн систем дэх өөрчлөлтүүдийг нэвтрүүлэхэд үйлчилгээ үзүүлэгч талуудын хоорондын төлөвлөгөөний зохицуулалт; (iv) төлбөрийн үйлчилгээний үлгэрчилсэн гэрээний загварыг боловсруулах. Үлгэрчилсэн гэрээ нь заавал байх албагүй боловч ямар нөхцөл нь стандартад нийцсэн, ямар нь банкны шинж чанартайг болон үйлчилгээний түвшин, үнэ өртөг зэрэг харилцан тохиролцож болох нөхцөлүүдийг санал болгох ёстой. Эдгээр бүлэглэлүүд нь зах зээлийн оролцогч бүрийн зөвшилцлийг бий болгох хэлэлцүүлгийг зохион байгуулах болон шийдвэр гаргагч нарт зөвлөгөө үзүүлэх үндсэн бүлэг болдгийн хувьд, төлбөрийн үйлчилгээний зах зээлийг зохицуулах шинэ хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чухал нөлөөтэй байж чаддаг.

(ii) Зах зээлийн үр ашигтай үнэ бүрдэлтийг хөхүүлэн дэмжих нь

Төлбөрийн үйлчилгээний зах зээл дээр “шударга”, “үр ашигтай” үнэ тогтох нь найдвартай, үр ашигтай үндэсний төлбөрийн системийг бий болгох үндэс болдог. Үнэ бүрдэлтийн үр ашиг нь зах зээлийн бүтцийн зохицуулалт болон үйлдвэрлэгчдийн зардлаас тус тус хамаарна. Ерөнхийдөө төлбөрийн үйлчилгээнд үр ашигтай үнэ бүрдэх стратегийн нөлөөлөл нь:

- Төлбөрийн хэрэгсэл болон төлбөрийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх, бий болгох болон зохион байгуулахад гарах үлэмж хэмжээний зардал;
- Хэрэглэгчийн сэтгэл ханамж болон үйлчилгээний чанарын ялгааг тооцон үзснээр зах зээл дээр бэлэн байгаа орлуулагч үйлчилгээний үнэ;

- Төлбөрийн дэд бүтцийн үйлчилгээний хувьд сүлжээний оролцогчид ба үйлчилгээ үзүүлэгчид үзүүлэх сүлжээний эерэг ба сөрөг дам нөлөөлөл.

Төлбөрийн системд янз бүрийн үйлчилгээний зах зээлүүд нь өөр өөр бүтцийн зохицуулалттай байдгаас үр ашигтай зах зээлийн үнэ тогтоох стратеги нь зах зээл бүрт ялгаатай байдаг. Жишээлбэл: сүлжээний үйлчилгээний зах зээл дээрх үр ашигтай үнэ нь гүйлгээ буюу гүйлгээний хэмжээнд суурилсан шимтгэл эсвэл суурь хураамжийн үнийн схемээс хамаарна. Мөн түүнчлэн, картын төлбөрийн системийн карт гаргагч болон карт хүлээн авагч зэрэг ялгаатай оролцогчдын өөр өөр үнээс хамаарч болно. Эдгээр зах зээлүүд хөгжсөнөөр, янз бүрийн оролцогчдод үзүүлэх гадаад нөлөөний үнэ цэнэ мөн өөрчлөгдөж болно. Тиймээс сүлжээний үйлчилгээний зах зээл дээрх хэрэглэгчийн үнэ нь үр ашигтай үнийг мөрдөхийн тулд харьцангуй өөрчлөгдөх боломжтой юм. Үр ашигтай үнэ тогтооход зах зээлийн амжилтгүй болсон баримт байгаа ч эрх мэдэл бүхий байгууллага нь дор дурьдсан зах зээлийн бусад нөхцөлүүдэд бүгдэд тохирсон үр ашигтай үнийн бодлого боловсруулах нь маш чухал юм.

(iii) Зах зээлийн ил тод байдал болон мэдлэгийг дээшлүүлэх механизмуудыг хөгжүүлэх нь

Шинэ төлбөрийн хэрэгсэл буюу үйлчилгээнүүд хүртээмжтэй байдаг учир зах зээлүүд зүгээр л гараад ирдэггүй. Шинэ хэрэгсэл буюу үйлчилгээнд боломжит хэрэглэгчдийг татах, тэдгээрийн хэрэглэгчдийн хэрэгцээтэй харьцуулсан шинж чанарын талаар мэдээлж байх хэрэгтэй. Зах зээлийн талаарх мэдээлэл, түүний ил тод, хүртээмжтэй байдал нь зах зээл дэх үр ашигтай өрсөлдөөн, түүнчлэн хүртээмжтэй, үнэн мэдээллийг бий болгох сахилга батыг бий болгодог.

Зах зээлийн талаарх боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны хүрээнд банкууд бүлэглэл болохынхоо хувьд харилцагч нарт зориулан шинэ төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээний талаар суурь мэдлэгийн материал тараах, хөгжүүлэх боломжтой. Бие даасан банкууд уг материалыг энэхүү шинэ үйлчилгээний өөрийн брэндтэй эмхэтгэн гарын авлага, товхимол хэлбэрээр, "шударгаар сурталчлах" журмын хүрээнд харилцагч нарт түгээх боломжтой. Дээрх мэдээллийн ерөнхий загвар нь дараахь зүйлсийг тайлбарлана: (i) үйлчилгээ авах горим; (ii) ая тухтай байдлыг сайжруулах, төлбөрийн аюулгүй байдал ба зардал; (iii) хэрэглэгч үйлчилгээг буруу, зохисгүй ашиглахаас үүсэх хэрэглэгчийн үүрэг хариуцлага. Банкуудын холбоо болон дэд бүтцийн операторын боловсруулсан төлбөрийн шинэ дэд бүтцийн үйлчилгээ, мэдээлэл, сургалтын хөтөлбөр нь шинээр үйлчилгээ бий болох хугацаанд хэрэглэгч нарын дунд эрэлтийг бий болгоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг.

Мөн түүнчлэн дараахь мэдээллүүд нь зах зээлд нэн чухал үр нөлөөтэй: (i) зарга мэдүүлэх болон маргаан шийдвэрлэх журам, зардал зэргийг тусгасан хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай болон шударга өрсөлдөөний тухай хууль; (ii) төлбөрийн үйлчилгээний

ялангуяа хэрэглэгчийн эрх болон үйлчилгээ үзүүлэгчийн үүргийн талаарх гэрээ хэлэлцээрийн стандарт; (iii) банкны шинж чанартай гэрээ хэлэлцээрийн нөхцөл, ялангуяа хэрэглэгчийн шимтгэл болон үйлчилгээний түвшин; (iv) салбарын хууль тогтоомж болон практик. Үйлчилгээ үзүүлэгч болон төв банкуудын хувьд бусад хэрэгцээт мэдээлэл нь янз бүрийн дэд бүтцээр дамжиж буй төлбөрийн хэмжээ, тоо ширхэгийн талаарх тогтмол тоо мэдээ болон янз бүрийн санхүүгийн болон арилжааны ажил гүйлгээнүүд дэх төлбөрийн хэрэгслийн хэрэглээний талаарх мэдээнүүд юм. Төрөл бүрийн төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээн дэх хэрэглэгчийн үнийг харуулах хавсаргасан мэдээлэл нь үйлчилгээг хэрэглэгч болон үзүүлэгчийн зах зээлийн үнэ цэнэтэй бенчмаркийн суурь болж өгдөг.

(iv) Зохистой зах зээлийн ашиглалтыг хөгжүүлэх нөхцлүүд

Үр нөлөөтэй төлбөрийн үйлчилгээний зах зээлийн зохион байгуулалт болон ил тод байдал нь хамтарсан бүлэглэлүүдийн зан байдлаас хамаарч байхад, зах зээл дээрх гүйлгээнүүд нь эцсийн дүндээ зөвхөн үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчийн хооронд л явагдана. Хэрэглэгч бүрийн хувьд зах зээл дээр сонголт байдаг бөгөөд тэр нь хараат бус байдаг бол, үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд хэрвээ зохион байгуулалттай үйлчилгээний зах зээл дээр ижил төстэй, эрх тэгш оролцогчид байгаа тохиолдолд тодорхой хэмжээгээр зах зээлийн сахилга батыг сахих хэрэгтэй болдог. Энэ нь төлбөрийн зах зээлд хандах хандалт, үнэ бүрдэлт, эрсдэлийн хуваарилалт зэргийн хувьд зах зээлийн нөхцлүүд ижил төстэй оролцогч бүрийн хувьд адилхан байдгийг харуулж байна. Эдгээр нөхцлүүдийн зарим нь зах зээлийн дүрэм журамд үндэслэж байхад, зарим нь зах зээлийн туршлага дээр суурилдаг байна.

Хандалтын нөхцлүүд нь янз бүрийн зах зээлүүд дээрх хамтын ажиллагаа ба өрсөлдөөний хоорондын тэнцвэрийг тодорхойлох хамгийн нөлөө бүхий хүчин зүйл байх боломжтой. Ерөнхийдөө оролцогчдын хувьд харьцангуй цөөн зохицуулалтын хязгаарлал бүхий зах зээлд олноор хандах нь өрсөлдөөний үр ашгийг хөхүүлэн дэмждэг. Хэдий тийм боловч, шууд оролцооны нээлттэй байдлын зохистой хэмжээ нь төлбөрийн үйлчилгээний зах зээлийн тодорхой төрөлд заасны дагуу ялгаатай байж болдог. Жишээлбэл, тодорхой системүүдэд хандалтын сэрэмжтэй байдлын хязгаарлалууд байнга шаардагддаг. Үр ашигтай, найдвартай төлбөрийн системд шаардагдах хамтын ажиллагааг санхүүгийн эрсдэл хуваах зарим хэлбэрийн шаардлагаас ихэвчлэн шалтгаалан ерөнхийдөө ижил төстэй сэрэмжтэй байдлын зохицуулалт бүхий байгууллагууд бэхжүүлж байдаг. Тиймээс зөвхөн банкууд болон ижил төрлийн зохицуулалт бүхий санхүүгийн байгууллагууд ерөнхийдөө төлбөрийн клиринг болон төлбөр тооцооны зохицуулалтад оролцдог байна.

Зарим тохиолдолд эрсдлийн агууламж болон зохицуулалтын хоригт хамааралгүй зах зээлийн хязгаарлалууд байдаг. Жишээлбэл, төлбөрийн дэд бүтцэд одоо байгаа оролцогч нь бусад боломжит өрсөлдөгчдийг оролцохыг хорьсон системийн дүрмийг санал болгож

болно. Энэхүү үйлчилгээний зах зээл дээр зохистой хамтын ажиллагаа эсвэл өрсөлдөөний тэнцвэрийг хадгалж байхад “Шударга өрсөлдөөн”-ий бодлого тусална.

(v) Төв банкны оролцоо

Зах зээлийн хөгжил нь бодит өөрчлөлт болон зардалтай холбоотойгоор нэлээд хугацаа шаарддаг. Гэсэн хэдий ч, төв банк зах зээлийг боловсронгуй болгох бүхий л хэрэгжилтийн арга замд гол үүрэг гүйцэтгэдэг. Жишээ нь, зохистой зах зээлийн нөхцлүүдийн хөгжлийг өдөөгч болохын хувьд төв банк нь банкуудын холбоо болон тухайн салбарын бүлгүүдтэй хамтран ажиллах, түүнчлэн үйл ажиллагаанд оролцох боломжтой юм. Энэ нь төрөл бүрийн төлбөрийн үйлчилгээний зах зээлийн хөгжилтэй холбоотой асуудлуудыг баттай болгож, үйлчилгээ үзүүлэгчдийн хоорондын “шударга үнийн” бодлогыг оролцуулаад, холбогдох бүлэглэлүүдийн үйл ажиллагааны хэлэлцэх асуудлын хэсэг болж чаддаг. Төв банк нь төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйлчилгээний гэрээний нөхцөл, болзлуудыг ил тод болгох, үр нөлөөтэй шийдвэр болон албадлагын арга хэрэгслүүдийг хөгжүүлэх үүднээс хууль эрх зүйн шинэчлэл буюу сайн дурын гэрээ хэлэлцээрийг санал болгох замаар зах зээлийн ил тод байдлыг хөхүүлэн дэмждэг.

Төв банк хянагчийн үүрэг гүйцэтгэдгийн хувьд, хяналт тавих зорилготой холбоотойгоор банкны шинж чанартай хамаатай хууль байхгүй тохиолдолд, бусад эрх мэдэл бүхий байгууллагуудтай хамтран шударга өрсөлдөөний болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай нэгдсэн хууль тогтоомжийг төлбөрийн болон холбогдох банкны үйлчилгээний зах зээлд нэвтрүүлэх санал гаргаж болно. Хэрвээ тодорхой эрх мэдэл байгаа бол, төв банк нь төлбөрийн үйлчилгээний зах зээл дээр шударга өрсөлдөөний болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах талаарх дүрэм, журмыг нэвтрүүлж чадах төдийгүй хэрэглэгчийн гомдол, зарга болон түүнийг шийдвэрлэх арга хэмжээний талаар хэрэглэгчийг хамгаалах тухай салбарын хууль тогтоомжид нэмэлт оруулахад банкуудын холбоонд дэмжлэг үзүүлж чадна.

Банкууд өрсөлдөөнтэй холбоотойгоор тус тусдаа үйл ажиллагаа явуулах сонирхолгүй тохиолдолд, төв банк сайн дурын, системийн хэмжээний хэлэлцээр, эсвэл албадлагын зохицуулалтыг дэмжиж, үйл ажиллагааг зохицуулах шаардлагатай. Гэхдээ л төв банк нь тодорхой хэрэгсэл болон үйлчилгээний зах зээл дээр эрэлт хангалттай бус байх, эсвэл тэдгээрийг нийлүүлэхэд бэлэн бус байх нь зах зээлийн зохицуулалтад хөндлөнгөөс оролцох эсвэл шууд үйлчилгээ үзүүлэгч болох шаардлагатй болох зэрэг зах зээлийн тогтворгүй байдлын үзүүлэлт биш гэдгийг мэдэж байх ёстой. Зах зээлийн нөхцлүүд нь хангалттай хөгжиж амжаагүй, мөн оролцогчид нь санаачлагын талаар хангалттай мэдээлэл авч амжаагүй байж болно. Энэ төрлийн асуудлыг зохицуулахад сургагч, зохицуулагч, хамтрагчийн хувьд төв банкны өдөөгчийн үүрэг илүү тохиромжтой байж болох юм.

Зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг харгалзан үзснээр төв банк нь төлбөрийн системийн үр ашиг, аюулгүй байдлын талаар бодлогын судалгааны ажлуудыг нийтэлж, хэлэлцүүлэг явуулж чадна. Үүнийг нь банкуудын холбоо, дэд бүтэц болон холбогдох олон нийтийн байгууллагуудын нэмэлт нийтлэлд оруулж болох ба төлбөрийн системийн бий болж буй хөгжлийн талаарх мэдээллээр тэдгээрийг хангах ач холбогдолтой. Түүнчлэн төв банк тайлангийн формат болон хуваарийн талаар тохиролцсоноор, холбогдох зах зээлийн талаарх мэдээлэл болон тоон өгөгдлүүдийг цуглуулах, боловсруулах үйл ажиллагаанд хамтран ажиллаж, тусалж чадна. Эдгээр мэдээллийг цуглуулах, боловсруулах, нийтлүүлэхэд тодорхой зардал гардаг учир үүнийг санхүүжүүлэхэд салбарын бүлгүүд болоод тэдгээрийн гишүүд уг үйл ажиллагаанд дурамжхан ханддаг. Гэсэн хэдий ч, нийт салбарын хэмжээн дэх төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээний ашиглалтын талаарх мэдээлэл нь төлбөрийн системийн үйлчилгээ үзүүлэгч бүрт өөрсдийн өрсөлдөх чадвараа үнэлэх, мөн өөрсдийн тодорхой бизнесийн болон зах зээлийн стратегия төлөвлөх боломж олгодог. Шаардлагатай тохиолдолд төлбөрийн системийн оролцогч бүртэй байгуулсан нууцлалын гэрээнийхээ хүрээнд төв банк салбарын нэрийн өмнөөс тоон өгөгдлүүдийг боловсруулан, нийтлүүлж болно.

Эцэст нь, төв банк төлбөрийн системд гүйцэтгэх бусад үүргээрээ дамжуулан зах зээлийн хөгжлийг дэмжиж чадна. Төлбөрийн үйлчилгээний хэрэглэгч болохынхоо хувьд, төв банк нь зах зээлийн хөгжлийг удирдлагаар хангахын тулд өөрийн гүйлгээнд тохирох төлбөрийн хөтөлбөр болон хэрвээ боломжтой бол өөрийн үйлчлүүлэгчдийн (засгийн газрын агентлагуудыг хамруулаад) шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг шинэчилж өөрчлөх боломжтой. Үйлчилгээ үзүүлэгчийнхээ хувьд төв банк нь үйлчилгээний гэрээг аль болохоор стандартчилагдсан, ижил зэрэглэлийн хууль ёсны бүх оролцогч нарыг ялгаварлаагүй байхаар баталгаажуулснаар зах зээлд хандах хандалтын удирдлагыг гартаа авч чаддаг. Мөн түүнчлэн өөрийн үйлчилгээний шимтгэл болон зардал нөхөх бодлогыг оролцуулаад төлбөрийн систем болон үйлчилгээнд оролцох нөхцөл болон өөрийн төлбөрийн үйлчилгээний мэдээллийг нийтлүүлснээр удирдах боломжтой.

Удирдамж 8. Холбогдох бүх талуудыг хамруулах: *үндэсний төлбөрийн системийн холбогдох бүх талууд бүтээлчээр зөвлөлдөн хэлэлцэхийг дэмжих.*

Тайлбар: Өмнөх удирдамжуудад заасны дагуу, холбогдох талуудтай зөвлөлдөх нь төлбөрийн үйлчилгээний зах зээлийг үр нөлөөтэй хөгжүүлэх болон стратеги арга барилаар төлөвлөхөд чухал ач холбогдолтой. Ингэж зөвлөлдөх нь төлбөрийн системийг хөгжүүлэх бодлого, санал, санаачлагыг төв банк болон бусад үндсэн холбогдох талуудад мэдээлэх хэрэгсэл болдгоороо хамтын ажиллагаа болон үүрэг хариуцлагыг сайжруулдаг. Энэ нь мөн үүсч буй хандлага болон хөгжлийн талаарх мэдээллийг олж авахад үр нөлөөтэй хэрэгсэл байж чаддаг.

Зөвлөлдөх процесст хамаарал бүхий төв банкнаас бусад холбогдох талуудад дараахь байгууллагуудыг хамруулдаг. Үүнд: (i) банкууд, төлбөрийн болон үнэт цаасны холбоо, түүнчлэн салбарын үндсэн оролцогчдын зарим хэсэг; (ii) төлбөрийн системийн оператор зэрэг санхүүгийн дэд бүтцийн байгууллагууд, үнэт цаасны арилжаа болон үнэт цаасны төлбөр тооцооны системийн операторууд; (iii) хэрэглэгчийн, жижиглэнгийн, хувийн болон улсын секторын бэлэн мөнгөний удирдлагын холбоо. Бусад олон нийтийн шийдвэр гаргагч байгууллагатай зөвлөлдөх талаар Удирдамж 9-д авч үзнэ.

Зөвлөлдөх ажиллагааг зохион байгуулттай багаар болон албан бус хэлбэрээр явуулдаг. Хоёр болон олон талын зохион байгуулалттай зөвлөлдөх процесс нь шинэтгэлийн үндсэн чиглэл болон нийтлэг зорилгоор зөвшилцөлд хүргэх хүчирхэг хэрэгсэл юм. Зохион байгуулалтад суурилсан зөвлөлдөх процесс нь ирээдүйн хөгжилд хэрэг болохуйц, гол холбогдох талуудын хоорондын итгэлцэл, ойлголцлыг бий болгож хөгжүүлэхэд хувь нэмэртэй.

Хэрэгжилт: Зөвлөлдөх ажиллагааны гол зорилт нь идэвхтэй харилцаа болон тухайн хэлэлцүүлгийн хамаарлыг хэвээр хадгалахад оршино. Зөвлөлдөх ажиллагааны зорилго болон оролцогчдын төрлөөс хамаараад зөвлөлдөх ажиллагаа нь нэгээс дээш бүтцийн ба зохион байгуулалтын хандлагатай байж болно. Төлбөрийн системийн хөгжлийг дагаад зөвлөлдөх ажиллагааны хамгийн үр нөлөөтэй зохицуулалт мөн адил хөгждөг.

(i) Зорилгын хүрээнд зөвлөлдөх ажиллагааг зохион байгуулах

Дэлхийн олон улсуудад төлбөрийн системийн талаар зөвлөгөө өгөх төрөл бүрийн бүлгүүд байгуулагдсан байдаг. Алсын хараатай, өндөр түвшний стратегийн бүлгүүд нь: (i) төлбөрийн системийн асуудлуудад хийх судалгаа болон суурь мэдээллийг зохион байгуулдаг; (ii) үндэсний төлбөрийн системд явагдаж буй хөгжилд дэм болж, тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх бодлогын санаачлагуудад зөвлөгөө өгөх үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр зөвлөх бүлгүүдийн оролцогчид нь төлбөрийн системд олон янзын үүрэг гүйцэтгэдэг байгууллагуудыг төлөөлдөг. Тэд төлбөрийн системийн хөгжил дэх гол асуудлуудыг төлбөрийн, сангийн болон үнэт цаасны ажиллагаа, мөн төлбөрийн үйлчилгээний хөгжлийн тал талаас нь харсан бүх талын, зохион байгуулалттай хэлэлцүүлгийг бий болгодог. Үүнээс гадна, төлбөрийн үйлчилгээний эцсийн хэрэглэгчид болох хэрэглэгч болон бизнесийн бүлгүүдтэй зөвлөлдөх нь чухал.

Шигтгээ 13-т дүрсэлснээр Дэлхийн банк/ЛАМБСТ зэрэг төв банкуудын бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагууд төлбөрийн талаар зөвлөгөө өгдөг бүлгийг зохион байгуулдаг.

Шигтгээ 13

Бүс нутгийн жишээ: Төлбөрийн болон Үнэт цаасны систем хоорондын хамтын ажиллагаа

1999 онд Дэлхийн банк, Латин Америкийн Мөнгөний Бодлого, Судалгааны Төв /ЛАМБСТ/-тэй хамтран Бөмбөрцгийн Баруун хагасын Төлбөр, Үнэт цаасны клиринг болон төлбөр тооцооны санаачлагыг (ББХС) эхлүүлсэн. Уг санаачлагын гол бүрэлдэхүүн нь Олон Улсын Зөвлөх Байгууллага /ОУЗБ/ юм. Үүнд олон улсын байгууллага, төв банк, үнэт цаасны хороог оролцуулаад, бүс нутгийн гадаад дахь хэд хэдэн байгууллагуудын шинжээчид багтдаг. 2003 онд ББХС нь Латин Америк, Карибын тэнгисийн орнуудын төлбөрийн системийн асуудлыг хариуцсан ажлын хэсгийн (ТСАХ-ЛАК) хамтын удирдлага дор байнгын үйл ажиллагаатай форум болж, ББХС, ЛАМБСТ, Америкийн Үнэт Цаасны Зохицуулалтын Зөвлөл (АҮЦЗЗ), Дэлхийн банк болон ОУЗБ-ын ивээл дор байгуулагдсан.

Уг форумын гол зорилго нь бөмбөрцгийн баруун хагасын үр ашигтай, найдвартай, бүрэн бүтэн байдлыг сайжруулах боломжит хэмжигдэхүүнийг тодорхойлсон гэж үзснээр төлбөрийн болон үнэт цаасны системийг үнэлэх, тодорхойлох явдал юм. Энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлэх, чанар болон үр дүнд итгэлтэй байхын тулд бүхий л судалгааг улс орны албан хаагчдын идэвхтэй оролцооны хүчээр зохион байгуулж, орон бүрд байгаа үйл ажиллагаан дээр тулгуурлаж хийсэн. Үүнээс гадна ОУЗБ-аар дамжуулан дотоодын болоод гадаадын шинжээчид удирдамж, зөвлөгөө, дадлага туршлагаар хангаж байсан.

Энэхүү загварын дагуу Дэлхийн банк болон бүс нутгийн төв банкууд, 2004 онд Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөлийн Төлбөрийн болон Үнэт цаасны Санаачлага, 2005 онд Арабын Валютын Сантай хамтран Арабын төлбөрийн болон Үнэт цаасны санаачлагыг тус тус хэрэгжүүсэн.

Бусад зөвлөлдөх бүлгүүд нь төлбөрийн системийг хөгжүүлэх тодорхой бүрэлдэхүүн хэсэгт илүү төвлөрсөн тусгай форумын хэлбэртэй зохион байгуулагддаг. Эдгээр бүлгүүд нь дараахь зүйлсийг хамарч болно. Үүнд: (i) стратеги төлөвлөгөө, (ii) төлбөрийн технологи болон стандарт, (iii) зах зээлийн хөгжил болон эрсдлийн удирдлага. Үр нөлөөтэй байхын тулд, бүх зөвлөлдөх механизмууд нь зорилготой бүлгийн хүрээн дэх хангалттай өргөн төлөөлөл болон оролцогчдын зохистой тооны тэнцвэрийг хангах шаардлагатай.

(ii) Төв банкны оролцоо

Төлбөрийн системийн гол байгууллага болохын хувьд, төв банк төлбөрийн системийн зөвлөлдөх олон ажиллагаанд оролцдог. Чухамдаа, төв банк нь ихэнх тохиолдолд төлбөрийн талаар зөвлөгөө өгөх форумыг зохион байгуулагч болдог ба банкууд болон салбарын бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулттай зөвлөлдөх ажиллагааг хамтран зохион байгуулагчдын нэг нь болдог. Мэргэжлийн өргөн хүрээний ур чадвар, дадлага туршлагатай учраас төв банк нь тодорхой зөвлөлдөх бүлэгтэй хамаарал бүхий тулгамдсан асуудлуудаар хийж буй хэлэлцүүлгийг чиглүүлж өгөхөөс гадна хэтийн үзэл санааг хөгжүүлэх, татан оролцуулах, үйл явцын талаар гүнзгий ойлгох болон баримжаа өгөх зэрэгт дэмжлэг болдог.

Төлбөрийн систем дэх янз бүрийн үүргүүдтэй холбоотой хөгжлийн төсөл болон бодлогын шинэтгэлүүдийн хүрээнд төв банк өөрсдийн шууд хэлэлцүүлгийг зөвлөлдөх бүлгийн хэлэлцүүлэгт албан ёсны олон нийтийн зөвлөгөөнөөр нэмж оруулж болно. Уг үйл явцын хүрээнд төв банк санал болгож буй шинэтгэлийн талаар олон нийтэд мэдээлж, шийдвэрийг эцсийн болгох зорилгоор сонирхогч талуудаас санал хүсэлт хүлээн авах тодорхой хугацааг тогтоодог. Энэ ажиллагааны тусламжтайгаар төв банкууд зөвхөн системийн оролцогч байгууллагуудаас гадна сонирхогч бүх талуудаас өргөн хүрээг хамарсан олон талын зөвлөгөө саналыг олж авдаг байна. Энэ нь мөн төлбөрийн болон банкуудын холбоонд төлбөрийн систем дэх тэдгээрийн эхлүүлж байгаа чухал шинэтгэлүүдэд зориулсан мөн ижил процессыг дагахад дэмжлэг болж чадна.

Удирдамж 9. Хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хамтран ажиллах: *төв банкны зүгээс төлбөрийн системийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай болдог.*

Тайлбар: Хэдийгээр төв банк нь үндэсний төлбөрийн системд хяналтын үүрэг хүлээдэг ч, системд нөлөөлөл үзүүлдэг цорын ганц улсын агентлаг биш юм. Олон улс оронд эрх мэдэл бүхий байгууллага болон тохируулагч агентлагууд төлбөрийн үйлчилгээний зах зээлийн үр ашигтай байдал болон өрсөлдөөн, мөн түүнчлэн эрсдлийн удирдлагын туршлага болон зах зээл дээр үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн төрөл бүрийн байгууллагуудын хэрэглэгчидтэй харьцах харьцаа зэрэгт нөлөө үзүүлж чаддаг. Эдгээр агентлагуудад:

- эцсийн хэрэглэгчдэд төлбөрийн үйлчилгээ үзүүлж байгаа болон зах зээлийн зохицуулалтад оролцож буй санхүүгийн байгууллагуудын эрсдлийн удирдлагын туршлагыг зохицуулж, үнэлэх банкны хянан шалгагч;
- харилцагчийн үйлчилгээ болон үнэт цаасны брокеруудын, сангийн менежерүүдийн эрсдлийн удирдлагын дадал, мөн түүнчлэн үнэт цаасны байгууллагуудын бизнесийн удирдлагын зарим ажлыг хариуцдаг үнэт цаасны зохицуулалтын болон өөрөө-удирдах байгууллага (ӨУБ);
- төлбөрийн дэд бүтцийн үйлчилгээг үзүүлэгч байгууллагууд болон өөр өөр төрлийн аж ахуйн байгууллагуудын өрсөлдөөнийг саармагжуулж буй бизнесийн практикт чиглэсэн шударга өрсөлдөөнийг зохицуулагч байгууллага;
- төлбөрийн системийн хууль, эрх зүйн орчны тогтолцооны үндэс суурь болж буй хууль тогтоомж болон бусад хууль ёсны хэрэгслийг санхүүжүүлэгч Төрийн Сан буюу Сангийн Яамны газар;

- төлбөрийн данс тооцоо болон үйлчилгээний гэрээний нөхцөлд нөлөө үзүүлж, санхүүгийн байгууллагуудын харилцагчдын гэрээгээр хүлээсэн эрхийг хамгаалдаг хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагууд тус тус багтдаг.

Зарим улс оронд эдгээр санхүүгийн системийг зохицуулах үүрэг бүхий байгууллага нь хэд хэдэн агентлагуудад тараагдсан байдаг. Бусад орнуудад хэдийгээр ихэвчлэн өөр өөр хэлтсүүдийн хариуцах ажил ч эдгээр үүргүүдийн ихэнхийг төв банк дангаараа хариуцдаг. Төв банкны хяналтын болон бусад эрх мэдэл бүхий байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хамтран ажилласнаар хамтын зохицуулалт нь байнга хамтран ажиллахаар зохион байгуулагдаж болох юм.

Төв банк болон бусад тохируулах эрх мэдэл бүхий байгууллагууд холбогдох бодлогын санаачлагуудыг зохицуулснаар үндэсний төлбөрийн системийн хөгжил илүү үр дүнтэй байж чадна. Төв банкны төлбөрийн системээр мэргэшсэн мэргэжлийн ур чадвар, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны болон зах зээлийн зан байдлын бусад талууд дээрх эрх мэдэл бүхий байгууллагуудын мэргэжлийн дадал чадварыг нэгтгэснээр төлбөрийн системд нөлөөлөх улсын бодлогын чанарыг сайжруулж чаддаг. Жишээ нь, бусад эрх мэдэл бүхий байгууллагууд заримдаа төлбөрийн системийн шинэтгэлийн хэсэг болохынх нь хувьд банкны болон татварын бодлогын зорилгыг мөрдөхийн хүсдэг. Гэхдээ эдгээр санал болгож буй шинэтгэлүүд нь үндэсний төлбөрийн системийн найдвартай болон үр ашигтай байдлыг санамсаргүйгээр бууруулж болно. Хамтарсан зохицуулалт нь иймэрхүү асуудлуудаас сэргийлж чаддаг.

Хэрэгжилт: Төв банк болон бусад эрх мэдэл бүхий байгууллагуудын хамтарсан зохицуулалтын зорилгууд нь: (i) төлбөрийн системийг хөгжүүлэх хандлага, санаачлага болон асуудлуудыг хэлэлцэх; (ii) тэдгээрийн одоо байгаа хууль, журмууд болон аливаа шинэ актуудтай харилцан ажиллах байдлыг авч үзэх; (iii) системийн хөгжлийг дэмжих, түүнд нөлөө үзүүлэх зорилгоор зохицуулалтын болон төлбөрийн системийн хяналтын бодлогыг боловсруулах. Хамтарсан зохицуулалтууд нь хэд хэдэн улс оронд болон улс орнуудын хооронд олон улсын түвшинд байдаг. Эдгээр зохицуулалтуудыг ихэнх тохиолдолд төлбөрийн болон төлбөр тооцооны системийн хянагч, банкны хянан шалгагч болон үнэт цаасны зохицуулагчдын хүрээнд зохион байгуулдаг. Зарим улс оронд эдгээр нь хэрвээ бүрэн эрх нь төлбөрийн системд болон зах зээлийн зохицуулалтад шууд нөлөө үзүүлдэг бол шударга өрсөлдөөний эсвэл Төрийн сангийн байгууллага болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах агентлагийг оруулдаг.

(i) Хамтарсан зохицуулалтуудын бүтэц

Хамтарсан зохицуулалтууд нь янз бүрийн хэлбэртэй байж болно. Энэхүү хэлбэр нь тухайн улсын засаг төрийн үндсэн хуулийн болон засаг захиргааны зохион байгуулал, мөн оролцогч агентлагуудын тэргүүлэх байр байдлаас хамаарч болно. Зарим нь харилцан

ойлголцлын санамж бичиг эсвэл тогтоол дүрэмд үндэслэсэн албан ёсны, олон талын байдаг. Бусад нь тодорхой зорилгоор байгуулагдсан (ad hoc), албан бус, хоёр талын байдаг. Шигтгээ 14-т зохион байгуулалттай хамтарсан зохицуулалтын зарим үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг харууллаа.

(ii) Мэдээлэл солилцох гэрээ

Нэгэнт л бодлого зохицуулалтын тохиролцооны зорилго нь төлбөрийн системд нөлөөлөх санхүүгийн бодлогын зохицол болон чанарыг сайжруулахад оршдог учир холбогдох агентлагуудын хооронд мэдээлэл солилцох гэрээ, хэлэлцээр зайлшгүй шаардлагатай. Бие даасан эрх бүхий зохицуулагч этгээд болон тэдгээрийг удирдаж буй байгууллагуудын хоорондын мэдээллийн ид тод байдал болон тайлагнах гэрээг хийх эсвэл төлбөрийн системийн холбогдолтой зохицуулагчийн нууц мэдээллийг солилцохын тулд зохицуулагч этгээд зөвшөөрөхүйц өөрчлөлт оруулах шаардлагатай байж болно.

Шигтгээ 14

Эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны үндэс

Хамтарсан зохицуулалтууд нь:

- хорооны сэдэл болон зорилгыг тодорхойлох (жишээ нь, тодорхой тохиолдолд (ad hoc) эсвэл байнгын, хоёр талын мэдээллийн солилцоо, зөвлөгөө өгөх буюу зохицуулалт);
- зохион байгуулалтын зарчмыг тодорхойлох;
 - хуулиар хүлээх хариуцлагын хүрээн дэх хараат бус байдал;
 - хамтарсан хяналтын зохицуулалтын хувьд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчимд нийцэх байдал (жишээ нь, Ламфалуссийн тайлан (1990), ТТСХ-ны хяналтын зарчмууд (2005));
- зохион байгуулалтын бүтцийг нарийвчлан тодорхойлж, ерөнхий ажил хэргийн удирдамжийг мэдээлэх. Энэ нь дараахь зүйлийг агуулна:
 - анхан шатны зохион байгуулагч;
 - оролцооны түвшин;
 - хэлэлцэх асуудлыг тодорхойлох;
 - оролцогчдийн үүрэг, хариуцлага;
 - хэлэлцүүлэг болон зөвлөмжүүдийн ил тод байдал;
 - харилцаа холбооны бодлого

(iii) Төв банкны оролцоо

Төв банкныг төлбөрийн системийн хамгийн сайн бодлогод анхаарлаа хандуулахын зэрэгцээ улсын секторын агент-хоорондын хамтын ажиллагаанд гарах зайлшгүй өөрчлөлтөнд манлайлах үүргийг гүйцэтгэнэ гэж үздэг. Санхүүгийн салбар хороо буюу санхүүгийн системийн тогтвортой байдлын хороо гэх мэтийн төлбөрийн бодлогоос өөр бусад шалтгаанаар аль хэдийн байгуулагдан оршиж байгаа бусад агентлагуудад хамаарал бүхий хоёр болон олон талын зохицуулалт байгаа тохиолдолд шаардлагатай бол төв банк нь төлбөрийн системийн бодлогын хэлэлцүүлгийн бүрэлдэхүүнд оруулах санал гаргаж болно. Ийм зохицуулалт байхгүй тохиолдолд, төлбөрийн системийн бодлогыг зохицуулахын тулд төлбөрийн системийн хянагч, банкны хянан шалгагч болон бусад холбогдолтой агентлагууд хооронд тогтмол хугацааны уулзалтыг зохион байгуулах боломжтой. Хэрвээ төв банк эдгээр үүргүүдийн заримыг хариуцдаг бол төлбөрийн системийн бодлогыг үр нөлөөтэйгээр зохицуулж чадах дотоод хороог байгуулж болно.

Удирдамж 10. Хууль эрх зүйн тодорхой байдлыг хангах: *үндэсний төлбөрийн системийн талаар тодорхой, иж бүрэн, ил тод хуулийн тогтолцоог бий болгоно.*

Тайлбар: Үндэсний төлбөрийн системийн хууль, эрх зүйн орчин нь оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлсон нэгдсэн хууль юм. Энэ нь хууль тогтоомж буюу бусад хууль

зүйн баримт бичиг, нийтлэг эрх зүй, засаг захиргааны эрх зүй, гэрээ (системийн дүрмийг оролцуулаад), буюу олон улсын гэрээ хэлэлцээр болон хэм хэмжээнээс бүрэлдэнэ. Энэ нэгдсэн хууль нь шилжүүлэг болон төлбөр тооцоо эцсийн байхтай хамаарал бүхий удирдлагын журам, зохион байгуулалтын зохицуулалт, төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээ зэрэгтэй холбоотой маргааныг шийдвэрлэх болон шилжүүлэг хийх горим, журмыг агуулдаг. Үндэсний төлбөрийн системийн ул суурьтай эрх зүйн орчин нь төлбөрийн дэд бүтэц болон үйлчилгээний зах зээлийн оролцогч нарын эрсдэл, эрх зүйн тодорхойгүй байдлыг бууруулдаг. Шигтгээ 15-д үндэсний төлбөрийн системийн эрх зүйн үндсэн орчинг харуулав.

Хууль, эрх зүйн орчин нь төлбөрийн системд нөлөө үзүүлэх нийтлэг хэрэглээний хуулиуд (жишээ нь, өмчийн эрхийн, гэрээний, корпорацийн болон дампуурлын тухай хууль) төдийгүй төлбөрийн системийн тусгай хуулиудыг (жишээ нь, төлбөрийн тухай хууль тогтоомж, үр дүнгийн тооцооны тухай хууль болон клирингийн төвийн дүрэм зэрэг) агуулна. Түүнээс гадна энэ нь дээрх хуулиудыг гаргах, тайлбарлах, хэрэг шийдвэрлэх болон гүйцэтгэлийг хангах зэрэгт зориулсан хууль тогтоох болон шүүхийн зохицуулалтыг мөн хамарна. Хавсралт 4-т үндэсний төлбөрийн системийн хууль эрх зүйн тогтолцоонд чухал нөлөө бүхий хууль, журмын төрлүүдийг жагсаан, тэдгээрийн зарим жишээг үзүүлсэн.

Шигтгээ 15
Үндсэн эрх зүйн орчин

Төлбөрийн системд үйлчлэх нийтлэг хэрэглээний хуулиуд:

- Өмчийн эрхийн болон гэрээний хуулиуд – нийтлэг эрх зүй (хууль, эрх зүйн хэм хэмжээний цогц) эсвэл төлбөр хийх болон хүлээн авах хуулийн хүчин төгөлдөр эрх, үүргийг бий болгохтой холбоотой хэрэглээний хууль тогтоомж (иргэний хуулийг оруулан) – ийн үндсэн дээр бий болно.
- Банк, санхүүгийн хуулиуд – хөрөнгө татан төвлөрүүлэх, зээл олгох, барьцаанд үнэт цаасыг авах, хүлээн зөвшөөрөх, түүнчлэн үнэт цаасыг эзэмших болон арилжаалахтай холбоотой санхүүгийн байгууллагуудын эрх, үүргийн үндсэн дээр бий болно.
- Дампуурлын тухай хуулиуд – төлбөрийн чадваргүй болсон аж ахуйн нэгжийн зээлдүүлэгчийн эрх, үүргийн үндсэн дээр бий болно.
- Зээл болон барьцааны ашиглалтын талаарх хуулиуд – зээлийн нөхцөл, зээлдэгчийн эрх, барьцаанд хөрөнгө авах, борлуулах болон төлбөр тооцоог барагдуулах дараалал зэргийг оролцуулна.
- Хэргийг шийдвэрлэхдээ ямар хуулийг хэрэглэх талаар тодорхойлсон хуулиуд – хууль, дүрмийн маргаан болон хуулийн зүйл заалтуудын гэрээний сонголтыг оролцуулна.
- Тоон гарын үсэг ба электрон баримтын тухай хуулиуд

Төлбөрүүдийн системийн тусгай хуулиуд:

- Төлбөрийн хэрэгслүүдийн тусгай хуулиуд – мөнгөн тэмдэгтийн хууль, вексель болон чекийн тухай хууль, цахим төлбөрийн тухай хууль, зөрчилтэй төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээний эсрэг журам, төлбөрийн хэрэгслийн стандарт (хэмжээ, хэлбэр дүрс, шифрлэлт) гаргахтай холбоотой дүрэм зэргийг хамарна.
- Төлбөрийн үүргийг гүйцэтгэх болон тооцоолохтой холбоотой хуулиуд – харилцан суутгах үр дүнгийн тооцоо, өрийн шилжүүлэг, төлбөр тооцоо эцсийн байх зэргийг оролцуулна.
- Төлбөрийн маргаан болон үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд авах арга хэмжээний тухай хуулиуд – төлбөр тооцооны нэхэмжлэлийн эн тэргүүнд барагдуулах дараалал, төлбөр тооцооны баталгаа болон алдагдал хуваах гэрээ, зээлийн төлбөр тооцоон дахь барьцааны давуу эрх, цахим төлбөртэй холбоотой нотолгооны тухай хууль, мөн арбитрын тайлбар мэтийн маргаан шийдвэрлэх механизм.
- Үндэсний төлбөрийн систем дэх төв банкны үүрэг, хариуцлага, бүрэн эрхтэй холбоотой хуулиуд.
- Дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон зах зээлүүдийг эмхлэх, удирдахад хамаарах хуулиуд – клирингийн болон төлбөр тооцооны зохицуулалтын хэлбэр болон үйл ажиллагаа, дэд бүтцийн систем дэх оролцоо болон үнэлгээ, дэд бүтцийн үйлчилгээн дэх үнэ бүрдэлт, цахим мөнгө гаргах болон төлбөр тооцоо хийхтэй холбоотой дүрэм, арилжааны төв түншийг эрсдлээс хамгаалах дүрэм.
- Үнэт цаасны дэд бүтцийн үйлчилгээг зохицуулах хуулиуд – үнэт цаасыг материаллаг бус болгох болон эргэлтэд оруулахгүй байх, үнэт цаасны шилжүүлэг болон үнэт цаасыг бүртгэлийн цахим бичилтийн үндсэн дээр эзэмших, төлбөрийн эсрэг нийлүүлэлт, төлбөр тооцоо болон шилжүүлэг эцсийн байх зэрэгт хамаарна.

Хэрэгжилт: Хамгийн наад зах нь нийтлэг хэрэглээний хуулиудын үндсэн тогтолцоо нь найдвартай, үр ашигтай төлбөрийн системийн хөгжилд зайлшгүй чухал байдаг. Хэрэв энэ нь байхгүй тохиолдолд, хуулийн шинэтгэлийн эн тэргүүнд өмчийн эрхийн болон гэрээний тухай хууль, банк, санхүүгийн хууль болон дампуурлын тухай хууль байна. Энэхүү шинэтгэлүүдийг чиглүүлэхэд анхаарах гол асуудлууд нь:

- ерөнхий гэрээний баримт бичгүүдээр дамжуулан хэрэглэгч, оролцогч болон үйлчилгээ үзүүлэгчид зориулсан хууль, эрх зүйн эрсдлийн хяналт;
- төлбөрийн системд оролцогчдын гэрээгээр хүлээсэн үндсэн эрх, үүрэг болон дампуурлын тухай хуулийн дагуу зээлдүүлэгчийн эрх, үүргийг хүлээн зөвшөөрөх;
- төлбөрийн хууль, эрх зүйн эрсдлийн хяналтаас гадна олон нийтийн тусгай бодлогыг боловсронгуй болгохын тулд ерөнхий хуулийг ижил хэрэглэснээр үүсч болох хууль, эрх зүйн нэмэлт эрсдлүүд.

(i) Хууль, эрх зүйн тогтолцоог системийн хөгжилд тохируулах нь

Хууль, эрх зүйн баримт бичгүүд (хувийн гэрээ эсвэл улсын хууль тогтоомж) нь системийн хэрэгцээнд нийцсэн байх ёстой. Төлбөрийн систем хөгжихийн хэрээр хууль, эрх зүйн орчин мөн адил сайжирна. Төлбөрийн систем дэх хууль, эрх зүйн шинэтгэлийг олон улсын хуулийн байгууллагаас боловсруулсан холбогдох загвар хууль эсвэл бусад орны хуультай харьцуулсан харьцуулалтад үндэслэн, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хүрээнд тохируулах ёстой. Хууль, эрх зүйн орчин нь төлбөртэй холбоотой асуудлуудаар тухайн улсын олон улсын гэрээ хэлэлцээрийг үр нөлөөтэйгээр дэмждэг байх нь маш чухал. Гэхдээ удаашралттай хууль, эрх зүйн шинэтгэлээс шалтгаалан эрх зүйн болон дэд бүтцийн шинэтгэлийн санаачлагууд нь хойшлогдох ёсгүй. Гэрээ, хэлэлцээр зэрэг хууль, эрх зүйн баримт бичгүүдийг системийн шинэтгэлийн хурдацтай гүйцэтгэл болон шаардлага хангасан хуулийн шинэтгэлийн хоорондын цаг хугацааны завсрыг холбоход ашигладаг.

Төлбөрийн систем хөгжихийн хэрээр нийтлэг хэрэглээний хуулиудыг төлбөрийн системийн тусгай хуулиудаар дэмжих шаардлагатай болдог. Жишээлбэл, системийн хувьд чухал төлбөрийн системд, системийн болоод түүний оролцогчдын хууль, эрх зүйн эрсдлийн хяналт нь нийтлэг гэрээний хуулийн боломжоос хэтрэх магадлалтай. Ийм тохиолдолд төлбөрийн системийн тусгай хууль тогтоомж нь гэрээ хэлэлцээр болон нийтлэг эрх зүйгээр зохицуулж чадахгүй байгаа зүйлийг тодорхой болгодог.

Системийн хувьд чухал төлбөрийн систем болон үнэт цаасны төлбөр тооцооны системд зохистой хууль, эрх зүйн орчин маш чухал. Эдгээр системүүдийн оролцогчдын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон хөрөнгийн позицгийн их хэмжээний алдагдал нь хууль зүйн

сорилт тохиолдоход системийн хэмжээний уналтад хүргэдэг байна. Ийм системүүд нь уналтын үед бүхий л системийн алдагдлыг хязгаарлах, төлбөр тооцооны тодорхой байдлыг баталгаажуулахын тулд төлбөр тооцоо эцсийн байх, төлбөрийн харилцан суутгах тооцоо, төлбөр тооцоо болон барьцааны үнэт цаас зэрэгт зориулсан үндэслэл бүхий хууль зүйн хамгаалалттай байх хэрэгтэй.

Төлбөрийн системийн оролцогчдын хүрээ ихсэхийн хэрээр төлбөрийн системд оролцогчдын хоорондын гэрээ, дүрмүүд нь системийн оролцогчид төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд тэдгээрийн хоёр талын эрх, үүргийг зохицуулах боломжтой байх ёстой. Гэхдээ системийн шууд бус оролцогч эсвэл оролцогч биш гишүүдийн (эдгээр нь дампуурсан оролцогчийн хөрөнгөн дээрх нэхэмжлэлээр өрсөлдөх болдог) хүлээх эрх, үүргийг зохицуулах үйл ажиллагаанд бүрэн хамаарахгүй. Хэрвээ энэ нь санаа зовоох асуудал болчихвол энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд одоо байгаа хуульд нэмэлт оруулах эсвэл шинэ хууль гаргах замаар шинэ хууль, тогтоомжоор зохицуулах шаардлагатай болно.

(ii) Зөвлөлдөх замаар эрх зүйн орчинг боловсронгуй болгох

Хууль, эрх зүйг илүү үр нөлөөтэй болгохын тулд, төлбөрийн эерэг практикийг дэмжин, ашиггүй зүйлүүдийг хориглож байх хэрэгтэй. Олон дахин засвар оруулалгүй, үндсэн өөрчлөлтийг хийлгүйгээр шинээр үүсч буй хөгжлийг зохицуулж, мөрдөгдөх чадвартай байхын тулд хууль эрх зүйн орчин хангалттай уян хатан байх ёстой. Холбогдох талуудын бүлэгтэй (үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгч, системийн оролцогчид) болон хууль тогтоогч, зохицуулагчидтай хоёуланттай нь зөвлөлдөх нь хууль, эрх зүйн орчны суурь хөгжилд зайлшгүй чухал юм. Өргөн хүрээг хамарсан зөвлөгөөн нь хууль эрх зүйн санаачлагуудаас үүсэх гэнэтийн үр дагаврын эрсдлийг бууруулж чадна. Төлбөрийн системийн эрх зүйн шинэтгэлтэй холбоотой улс төрийн хөдөлгөгч хүч нь төв банк, эрх зүйн шинжээч зэрэг хууль тогтоогч болон эрх бүхий байгууллагуудын хоорондын үр нөлөөтэй зөвлөгөөнийг шаарддаг.

(iii) Эрх зүйн орчинг ил тод, хүртээмжтэй болгох

Үр нөлөөтэй хууль, эрх зүйн орчинд хамаарал бүхий хуулиуд нь холбогдох талуудад ил тод байдаг. Үүний тулд хууль тогтоомж, журам болон системийн дүрэм нь ойлгомжтой найруулгатай, мөн нийтээр хүлээн зөвшөөрсөн гэрээний хэм хэмжээг хэрэглэсэн байх шаардлагатай. Эдгээр хууль, эрх зүй болон журам нь олон нийтэд хүртээмжтэй, холбогдох талууд шаардлагатай мэдээллүүдээ олж авахад хялбар байх нь зүйтэй. Мөн эдгээр нь холбогдох шүүхийн болон шийдвэр гүйцэтгэх албаны холбогдох албан тушаалтнуудтай холбоотой байж, иргэний, эрүүгийн эсвэл засаг захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа механизм болон шийтгэл дээр суурилах хэрэгтэй.

(iv) Төв банкны үйл ажиллагааны хууль, эрх зүйн үндэслэлийг заах нь

Үндэсний төлбөрийн систем дэх төв банкны янз бүрийн үүрэг, ялангуяа хяналтын үүрэгт хууль, эрх зүйн орчин маш чухал байдаг. Төв банкууд өөрийн хяналтын үүрэг, хариуцлага болон эрх мэдлийг тодорхой хуулийн буюу гэрээний баримт бичгээс эсвэл тэдгээрийн үйл ажиллагааны бүрэн эрхийг зохицуулдаг ерөнхий гэрээнээс тодорхойлж чаддаг. Ямар ч хууль, эрх зүйн баримт бичгийг хэрэглэсэн байсан, төлбөрийн системийн хууль, эрх зүйн орчин нь төв банкны хяналтын үүргийг дэмжих ёстой. Хуулийн болон бусад эрх зүйн баримтыг дараахь зорилгоор боловсруулна: (i) төв банкны зүгээс хяналт тавихыг, мөн боломжтой бол өөрийн нутаг дэвсгэр дээрх улс орны төлбөрийн системүүдийн ажиллагаануудыг оролцуулаад, төлбөрийн системийг зохицуулахыг хүлээн зөвшөөрөх; (ii) санхүүгийн байгууллага болон төлбөрийн систем нь өөрсдийн санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдлийг үр нөлөөтэйгээр удирдаж байгааг баталгаажуулах; (iii) зохистой журмуудтай нийцсэн ажиллагааг зохион байгуулахын тулд төрөл бүрийн төлбөрийн системүүд, санхүүгийн байгууллагуудыг оролцохыг шаардах.

(v) Төв банкны оролцоо

Бусад эх үүсвэрээс авах төлбөрийн системийн хууль, эрх зүйн мэргэжлийн ур чадвар хязгаарлагдмал тохиолдолд, төв банк нь хууль зүйн хөгжлийг удирдахад туслан, төлбөрийн системд нөлөө үзүүлэхүйц хууль, эрх зүйн асуудлуудыг тодорхойлж чадна. Зарим нөхцөлд, төв банк төлбөрийн системийн хууль, эрх зүйн орчны байдлын талаар холбогдох талуудад нээлттэй мэдээлж болно. Үүнийг удирдахдаа, төлбөрийн системд шинэ хэрэгсэл, зах зээлийн зохицуулалт болон дэд бүтцийн талаар тодорхой өөрчлөлтийг хийх гэж байгаа бол төв банк нь төлбөрийн системийн тодорхой талуудад хууль тогтоомж буюу журмын хүрээнд шинэтгэл, өөрчлөлт шаардаж байгаа эсэх, эсвэл энэ нь шүүх байгууллагын тогтолцоо, хувийн хэлэлцээр эсвэл зах зээлийн практикт үлдсэн эсэхийг үнэлэхэд тусалж чадна.

Төв банк нь хууль тогтоогч байгууллага болон бусад холбогдох талуудтай зөвлөлдсөний үндсэн өөрийн хяналтын эрх мэдлийн хүрээнд хууль, эрх зүйн орчны хөгжилд чухал хувь нэмэр оруулах шаардлагатай байж болно. Үүний тулд төв банк хяналтын зорилго, цар хүрээ, горимууд дээр төлбөрийн системийн оператор болон эрх бүхий байгууллагуудын хооронд харилцан ойлголцлын санамж бичиг эсвэл протокол гэх зэрэг цаасан гэрээг ашиглах боломжтой. Ийм төрлийн гэрээнд хууль ёсны баримт бичгээс илүү хурдан өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ нь хууль, эрх зүйн орчин нь шинэтгэлийн урт удаан явцыг туулж байх явцад шинэ хяналтын протоколд үр нөлөөтэйгээр хэрэглэгдэж чадах юм. Шаардлагатай тохиолдолд, төв банк нь өөрийн хяналтын зорилгод хамаарал бүхий төлбөрийн системийн хууль эсвэл бусад хууль ёсны бичиг баримтын төсөлд зориулсан

зөвлөлдөх форумд оролцож байх ёстой. Түүнчлэн төв банк энэ зорилгоор байгуулагдсан зөвлөлдөх бүлгүүдийг зохион байгуулж болно.

Төлбөрийн системийн эрх зүйн орчний орчны хөгжилд санал болгох лавлах материалууд

Balto, D and J McAndrews (1998): “Joint venture payment networks and public policy”, in *Payment systems in the global economy: risk and opportunities*, 34th Annual Conference on Bank Structure and Competition, Federal Reserve Bank of Chicago.

Bank for International Settlements (1990): *Report of the Committee on Interbank Netting Schemes of the central banks of the Group of Ten countries* (the Lamfalussy Report), November.
Bank of England (2005): *Payment System Oversight Report 2004*, January.

Bhala, R (1994): “Legal foundations of large-value transfer systems”, in BJ Summers (ed), *The payment system: design, management and supervision*, IMF.

Cirasino, M (2002): “Cooperation within payment system: terms of reference for payments council”, *Western Hemisphere Initiative Working Paper no 4*, April.

Committee on Payment and Settlement Systems (1999): *Retail payments in selected countries: a comparative study*, Bank for International Settlements, September.

——— (2005): *Central bank oversight of payment and settlement systems*, Bank for International Settlements, April.

Crawford, P (2002): *Payment, clearing and settlement in Canada*, Canada Law Book Inc.

European Central Bank (2000): *Role of the Eurosystem in the field of payment systems oversight*, June.

——— (2004a): *Assessment of euro large-value payment systems against the Core Principles*, May.

——— (2004b): *Standards for securities clearing and settlement in the European Union*, September.

Geva, B (2003): *The law of electronic funds transfers*, Matthew Bender & Co.

Group of Ten (2001): “The effects of consolidation on payment and settlement systems”, *Report on Consolidation in the Financial Sector*, R W Ferguson Jr (Chair), Bank for International Settlements, January.

Heinrich, G (1997): “International initiatives toward legal harmonization in the field of funds transfers, payments and payment systems - annotated bibliography”, in W Hadding and U H Schneider (eds), *Transboundary Payment transactions in the European single market*, Bundesanzeiger, Bonn.

Humphrey, D and L Pulley (1998): “Retail payments instruments: costs, barriers and future use”, in *Payment systems in the global economy: risk and opportunities*, 34th Annual Conference on Bank Structure and Competition, Federal Reserve Bank of Chicago.

Payment System Advisory Committee (1997): “Access to payment networks in the Canadian Payment System”, *Bank of Canada and Department of Finance Discussion Paper 3*, July.

Shy, O (2001): *The economics of network industries*, Cambridge University Press.

Vesala, J (1998): “Delivery networks and pricing behaviour in banking: an empirical investigation using Finnish data”, *Bank of Finland Discussion Paper 18/98*, August.

3.4 Үндэсний төлбөрийн системийн дэд бүтцийг хөгжүүлэх нь:

Үндэсний төлбөрийн системийн гол дэд бүтцүүд нь гүйлгээ, клиринг, төлбөр тооцооны зохицуулалтуудтай холбоотой байдаг. Эдгээр дэд бүтцүүд нь үйлчилгээ үзүүлэгч, сүлжээний төхөөрөмж, мэдээллийн болон компьютерын техник, үйл ажиллагааны дүрэм, журмуудаас бүрдэнэ. Энэхүү дэд бүтцүүдийг санхүүгийн байгууллагууд эсвэл, зарим тохиолдолд гүйлгээний дэд бүтцэд зориулснаар оролцогч байгууллагуудын харилцагчдад үйлчилгээг шууд үзүүлэхээр боловсруулдаг. Эдгээр дэд бүтцүүдийн эзэмшигч, оператор, үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгч болохынхоо хувьд төв банк болон банкны сектор нь Шигтгээ 16-д үзүүлсэн төрөл бүрийн зохицуулалтыг хөгжүүлэхэд гол хамтрагч-батлан даагч (co-sponsors) болж байдаг.

Шигтгээ 16

Төлбөрийн дэд бүтцийн үйлчилгээ

Гүйлгээний дэд бүтэц нь дараахь байдлаар төлбөрийн даалгаврыг хийх, батлах, шилжүүлэх үйлчилгээг үзүүлдэг. Үүнд:

- гүйлгээнд оролцогч талуудын жинхэнэ эсэхийг тогтоох, ингэхдээ зарим тохиолдолд инкрипшн технологи ашиглах;
- системийн стандартуудад төлбөрийн хэрэгслүүд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах;
- төлөгчийн төлбөрийн чадварыг магадлах;
- төлбөр хүлээн авагч болон төлөгчийн санхүүгийн байгууллагуудын хооронд хөрөнгийн шилжүүлэг хийх эрх олгох;
- төлбөрийн мэдээллийг боловсруулах болон бичилт хийх;
- байгууллага хооронд мэдээлэл дамжуулах.

Клирингийн дэд бүтэц дараахь байдлаар дамжуулах, тохируулах болон зарим тохиолдолд санхүүгийн байгууллага хоорондын төлбөрийн даалгаврыг баталгаажуулах, банк хоорондын төлбөр тооцооны позицийг тооцоолох үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- байгууллагуудын хоорондын төлбөрийн даалгаврыг цэгцлэх, тулгах;
- байгууллага бүрээр төлбөрийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, бүлэглэх;
- төлбөрийн мэдээллийн тайланг хадгалах, тэдгээрийг байгууллага бүрт дамжуулах;
- байгууллага бүрийн нэг бүрчилсэн эсвэл харилцан суутгах үр дүнгийн тооцоог (өглөг буюу авлага) тооцоолох.

Төлбөр тооцооны дэд бүтэц нь дараахь байдлаар банк хоорондын хөрөнгийн шилжүүлгийн үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

- төлбөр тооцооны нэхэмжлэлүүдийг цуглуулах, тэдгээрийн бүрдлийг шалгах;
- төлбөр тооцоо гүйцэтгэх банкин дахь оролцогч байгууллагуудын төлбөр тооцоо гүйцэтгэх хөрөнгийн бэлэн байдлыг баталгаажуулах;
- төлбөр тооцоо гүйцэтгэх банкин дахь эдгээр дансаар дамжуулан хөрөнгийн шилжүүлгээр нэхэмжлэлүүдийн төлбөр тооцоог хийх;
- төлбөр тооцооны бичилтүүдийг хийх, оролцогч байгууллагуудад мэдээллийг өгөх.

Эдгээр дэд бүтцийн үйлчилгээнүүд нь төлбөрийн бүх төрлүүдэд хамаатай. Хэдий тийм ч, тэдгээрийн үзүүлж буй дэд бүтцийн загвар болон үйлчилгээний онцгой шинж чанар нь үндэсний төлбөрийн системүүдэд өөр өөр байх төдийгүй үндэсний төлбөрийн систем

дотроо төлбөрийн хэрэгслүүдээрээ ялгаатай байж болно. Төлбөрийн дэд бүтэц дэх хамгийн мэдэгдэхүйц ялгаа нь бага дүнтэй төлбөр болон их дүнтэй төлбөрийн системүүдийн хооронд байдаг. Жишээлбэл, бага дүнтэй төлбөрийн системд гүйлгээний дэд бүтэц зарим талаар төлбөрийн хэрэгслээс хамаарах ба үүнээс болоод систем хөгжихийн хэрээр илүү олон төрөл болж байдаг. Их дүнтэй төлбөрийн системд үндсэндээ цахим кредит шилжүүлгүүд нь цорын ганц төлбөрийн хэрэгсэл болох ба гүйлгээний дэд бүтэц нь ерөнхийдөө банк бүрийн өмчлөлд, мөн дээд зэргээр компьютержсэн байдаг.

Дэд бүтцийн шинэтгэлүүд нь гол төлөв мэдээлэл боловсруулалт болон холбоо харилцааны технологиуд дахь өөрчлөлтүүдээс хамаарна. Гэхдээ энэхүү шинэтгэлийн үйл явц нь зөвхөн технологид суурилсан байх ёсгүй. Хэдийгээр компьютерт суурилсан мэдээлэл болон цахилгаан холбоо харилцааны шийдлүүд орчин үеийн төлбөрийн системийн дэд бүтцийн техник цөм нь боловч, тэдгээр нь арга хэрэгсэл бөгөөд хөгжлийн шалтгаан болж чаддаггүй. Шаардлагатай төлбөрийн дэд бүтцийн үйлчилгээний найдвартай, үр ашигтай байдлыг сайжруулах нь эцсийн зорилго ба энэ үйл явцыг удирдах ёстой шинэтгэлийн бизнесийн нөхцөл юм. Гэхдээ л хэрвээ одоо байгаа технологи нь үүнийг үр ашигтай буюу найдвартай аргаар хийх боломжгүй бол бэлэн байгаа төлбөрийн шинэ технологийг сонгож авах нь уг зорилгод хүрэх хамгийн шилдэг арга байж болно.

Бага дүнтэй төлбөр, их дүнтэй төлбөр, үнэт цаасны дэд бүтцэд хийгдэж буй шинэтгэл нь бүгдээрээ улс орны санхүү, эдийн засгийн хөгжилд маш чухал. Гэхдээ хөгжлийн хязгаарлагдмал нөөцөөр хааш нь хөрөнгө оруулалт хийх вэ гэдэг хэцүү шийдвэр болдог. Жишээ нь, бага дүнтэй төлбөрийн системд автоматжуулсан клирингийн төвийг хөгжүүлэх үү эсвэл тусгайлсан их дүнтэй төлбөрийн системийг хөгжүүлэх үү гэдгийн аль нь эн тэргүүний зүйл болох вэ гэдэг явдал. Их дүнтэй төлбөрийн систем нь үнэт цаасны төлбөр тооцооны системээс түрүүлж хөгжих ёстой, эсвэл зэрэгцэн хөгжих шаардлагатай. Харамсалтай нь энэ нь хялбар зүйл биш бөгөөд улс орон бүрт хэрэглэж болохоор нийтлэг хариулт байдаггүй. Давтан хэлэхэд, хариултууд улс орон бүрийн одоо байгаа болон шинээр үүсч буй хэрэгцээний бодит үнэлгээ болон хүчин чадлаас хамаардаг байна.

Дор дурьдсан дэд бүтцийн удирдамжууд нь ерөнхий нөхцөл болон арга замуудад анхаардаг. Үүнд:

- бага дүнтэй болон их дүнтэй төлбөрийн дэд бүтцүүдийг хөгжүүлэх;
- үнэт цаасны болон их дүнтэй төлбөрийн системүүдэд зориулагдсан дэд бүтцийн хөгжлийг төлөвлөх;
- үндсэн системүүдийн төлбөр тооцооны ажиллагааг зохицуулах.

Удирдамж 11. Бага дүнтэй төлбөрийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх: *бага дүнтэй төлбөрийн дэд бүтцийг сайжруулж, өргөжүүлэх замаар хэрэглэгч, аж ахуй нэгж, засгийн газрын байгууллагад үзүүлэх үйлчилгээ, үр ашигтай, найдвартай бэлэн бус төлбөрийн хэрэгслийн сонголт, хүртээмжийг нэмэгдүүлэх ёстой.*

Тайлбар: Улс орны арилжааны, үйлдвэрлэлийн, цаашлаад санхүүгийн салбарын хөгжил нь ерөнхийдөө бэлэн бусаар хийх бага дүнтэй төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээний хэрэглээг, мөн түүнчлэн илүү олон төрлүүд болгох хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлж байдаг. Бага дүнтэй төлбөр дэх шинэтгэлийн санаачлагууд нь төрөл бүрийн бага дүнтэй төлбөрийн хэрэгслүүд болон үйлчилгээний тодорхой хэрэглэгч болон олон нийтэд хүртээмжтэй байдлыг дээшлүүлэхэд, түүнчлэн найдвартай, үр ашигтай гүйлгээ, клиринг, төлбөр тооцооны үйлчилгээний зохицуулалтыг дэмжихэд анхаардаг. Эдгээр үйлчилгээнүүдийг зөвхөн найдвартай, аюулгүй, үр ашигтай дэд бүтцийн зохицуулалтаар хангана.

Бага дүнтэй гүйлгээний системийг хөгжүүлэх санаачлагуудыг дараахь зүйлд чиглүүлэх хэрэгтэй байж болох юм. Үүнд:

- өдрийн турш болон илүү олон байршилд төлбөрийн хэрэгслүүдийн ашиглалтыг өргөжүүлэх;
- ялангуяа кредит шилжүүлгийн хэрэгслүүдтэй холбоотой стандартчилагдсан цаасан эсвэл цахим төлбөрийн хэрэгслүүдийн хүрээг өргөжүүлэх;
- төлбөрийн мэдээллийн дамжуулалт дахь нууцлал болон аюулгүй байдлыг сайжруулах;
- төлбөрийн хэрэгсэл болон системийн оролцоо, мөн төлбөрийн дансны талаар үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчид зориулсан хууль зүйн үндэслэл бүхий үйлчилгээний гэрээ байгуулах;
- төлбөрийн карт болон АТМ-ийн сүлжээ зэрэг төлбөрийн хэрэгслүүдийн тусгай төрлүүдэд зориулсан ПОС-ийн гүйлгээний сүлжээнүүдийн хоорондын харилцан ажиллах боломжийг сайжруулах.

Клиринг болон төлбөр тооцооны зохицуулалтын хувьд ашигтай хөгжлийн санаачлагууд нь дараахь зүйлсийг агуулна. Үүнд:

- хэрвээ боломжтой бол үндэсний клирингийн төхөөрөмжүүд болон бүс нутгийн клирингийн төвүүдийн хоорондын холбоогоор дамжуулан бүс нутаг хоорондын төлбөрийн клиринг болон төлбөр тооцоог сайжруулах;
- бүсийн төв банкуудын салбаруудад зориулагдсан нэгдсэн төлбөр тооцооны дансны удирдлагын систем болон хамгийн гол нь бүхий л үндэстний төвлөрсөн дансны удирдлагын системийг хөгжүүлэх;
- бага дүнтэй төлбөрийн хэрэгслүүдийн клирингийн ялгаатай төрлүүдэд зориулсан горим, нийтлэг клирингийн төвийн стандартууд, төлбөрийн хэрэгслүүдийн тодорхой төрлүүдэд зориулсан энгийн стандартуудыг тогтоох.

Бүх үндсэн дэд бүтцүүдэд нийтлэг байдаг чухал шинэтгэлийн санаачлагууд нь дараахь зүйлстэй хамааралтай байж болно:

- дэд бүтцийн үйлчилгээнд эрх тэгш хандлагыг хангах, ялангуяа системд шууд оролцож байгаа байгууллагуудтай холбоотойгоор ойлгомжтой бодлогыг тодорхойлж заах;
- үнийн бодлого, үйл ажиллагааны дүрэм, журам, мөн үйл ажиллагааны болон санхүүгийн эрсдлүүдийн ил тод байдлыг сайжруулах;
- шаардлагатай үед сүлжээний ажиллагаан дахь бизнесийн болзошгүй байдлын төлөвлөгөө болон уян хатан байдлын түвшин, мөн эрсдлийн хяналт болон эрсдэл хуваах тохиролцоог бэхжүүлэх;
- хэрвээ зайлшгүй шаардлагатай бол, бүх оролцогч байгууллагуудын шаардлагыг харуулах удирдамжийг бэхжүүлэх, хянаж үзэх.

Хэрэгжилт: Банкны сектор болон цахилгаан холбооны салбар дахь бусад холбогдох хувийн секторын үйлчилгээ үзүүлэгчид, эдгээр олон шинэтгэлүүдийг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэхээр санагдаж болох юм. Хэдий тийм ч, банкны систем эдгээр бүх дэд бүтцийн шинэтгэлүүдийг зохион байгуулах ёсгүй. Зарим дэд бүтцүүд дэх, ялангуяа хувь хүн болон бизнесийн байгууллагуудыг банкны төлбөрийн үйлчилгээнд хүргэдэг гүйлгээний системүүд дэх шинэтгэлүүдийг гуравдагч этгээд – бие даасан оператор хөгжүүлж чаддаг байна. Эдгээр бие даасан операторууд байгууллага бүрт тэдгээрийн тодорхой хувь хүн болон бизнесийн харилцагчдад нь зориулан төлбөрийн сүлжээний үйлчилгээг үзүүлдэг. Бага дүнтэй төлбөрийн дэд бүтцийн шинэтгэлүүдийг хэн санаачилж, хэрэгжүүлэхийг үл харгалзан эдгээр санаачлагууд дараахь үйл ажиллагаандаа эрх зүйн өөрчлөлтийг шаардаж болно: (i) үйл ажиллагааны дүрэм, сүлжээний зохицуулалтын горим; (ii) үйлчилгээний зах зээлийн хэвшил, журам, гэрээ болон оролцоо; (iii) бага дүнтэй төлбөрийн хууль, эрх зүйн тогтолцоо.

(i) *Стандартчилах, автоматжуулах, хамтран ажиллах*

Нэг хугацаанд найдвартай, үр ашигтай байдлыг нэмэгдүүлж чадах гүйлгээний систем, холбогдох клирингийн болон төлбөр тооцооны зохицуулалтаар дамжуулан бага дүнтэй төлбөрийн хэрэгслийг хэрэглэгчдийн хэрэглээг өргөжүүлэх ерөнхийдөө гурван арга зам байдаг. Эдгээр арга замууд нь төлбөрийн хэрэгслийн стандартчилал буюу нэг жишигт оруулах явдал, мэдээллийн технологийг ашигласнаар хийсэн автоматжуулалт болон сүлжээний харилцан ажиллах боломж юм. Тус арга замуудыг хэрэгжүүлэх зарим аргачлалыг Шигтгээ 17-д харуулав.

Шигтгээ 17

Бага дүнтэй төлбөрийн дэд бүтэц дэх хөгжлийн санаачлагууд

Автоматжуулсан, стандартчилагдсан төлбөрийн гүйлгээний дэд бүтэц: Картын төлбөрийн янз бүрийн төрлүүд, зайны банк болон интернет төлбөр зэрэг цахим харилцаа холбооны сүлжээ нь харилцагчдад бага дүнтэй төлбөрийг бодит цагаар үүсгэх, батлах боломж олгодог. Эдгээр сүлжээг боловсронгуй болгох, хөгжүүлэх энгийн санаачлагууд нь дараахь зүйлсийг багтаадаг. Үүнд:

- (i) цаасан төлбөрийн хэрэгслүүдийн хувьд стандартчилагдсан гүйлгээний процессыг бий болгох;
- (ii) хэрэглэгчдийн хувьд зардал багатай цахим гүйлгээний сүлжээг нэвтрүүлэх;
- (iii) цахим клиринг болон төлбөр тооцоонд зориулан цаасан төлбөрийн хэрэгслийг тоон системд шилжүүлэх эсвэл тэдгээрийг цахим хэлбэрт хөрвүүлэх процесс болон технологийг нэвтрүүлэх.

Гүйлгээний дэд бүтцүүдийн хоорондын харилцан ажиллах боломж: Энэхүү гүйлгээний дэд бүтцүүдийн харилцан ажиллах боломж буюу нэгдэл нь эдийн засгийн далайц, цар хүрээнд хүргэн, дараахь байдлаар зардлыг бууруулж чадна:

- (i) хамтран ажиллах боломжтой үйлчилгээг үзүүлж буй бүх сүлжээнүүдэд холбоо харилцаа болон дамжуулалтын аюулгүй байдал, төлбөрийн хэрэгслийн нийтлэг стандартыг хүлээн зөвшөөрөх;
- (ii) ялангуяа АТМ болон ПОС (EFTPOS) - ийн сүлжээ гэх зэрэг хувийн сүлжээний зохицуулалтын хоорондын холболтыг хялбаршуулах;
- (iii) өрсөлдөж буй сүлжээнүүдийн хоорондын ПОС төхөөрөмж дээр (өөрөөр хэлбэл, АТМ, карт уншигч, интернетийн холбогч) харилцан ажиллах байдлыг хүлээн зөвшөөрөхийн тулд нийтлэг төхөөрөмж (жишээ нь, компьютер, свитч) болон програм хангамжийн стандартуудыг сонгож авах.

Хамтран ажиллах чадвартай, автоматжуулсан бага дүнтэй төлбөрийн клиринг болон дэд бүтэц: энгийн харилцан холбогдсон мэдээллийн технологиор болон одоо байгаа зохицуулалтуудыг бодитоор төвлөрүүлэх эсвэл нэгтгэх замаар хангагдана. Эдгээр дэд бүтцүүдийн зохицуулалтыг боловсронгуй болгох нийтлэг санаачлагууд дараахь зүйлсийг багтаана:

- (i) бага дүнтэй төлбөрийн найдвартай байдал болон хурдыг сайжруулахдаа үндэсний эсвэл бүс нутгийн харилцан холбогдсон автомат клирингийн төвийг байгуулах;
- (ii) бүс нутгийн болон үндэсний төвүүдээр дамжуулан салбар хоорондын буюу банк хоорондын клирингийн болон төлбөр тооцоог төвлөрүүлэх эсвэл харилцан ажиллах боломжтой болгох.

(ii) Дэмжлэг үзүүлж буй эрх зүйн зохицуулалтуудыг боловсронгуй болгох

Хэдийгээр автоматжуулалт болон харилцан ажиллах боломжийг нэмэгдүүлэх олон тооны шинэтгэлийн санаачлагууд том хэмжээний техникийн болон журмын шинжтэй санагддаг ч, эдгээр нь үнэндээ урагшлахын тулд хууль, эрх зүйн буюу зохицуулалтын өөрчлөлтийг шаардаж болно. Энгийн жишээ болгож цахим төлбөр болон банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн зөвшөөрлийн хууль, эрх зүйн үндэслэлийг оруулж болох юм. Удирдамж 8-д дурьдсан хувийн болон улсын секторт хамаарах холбогдох талуудын зөвлөгөөн болон

бодлого зохицууллын механизмууд нь зах зээлийн хандалт, автоматжуулалт, харилцан ажиллах боломжид тохиолдох аливаа эрх зүйн болон зохицуулалтын саад хоригийг үгүй болгох явдлыг санаачлах, нөлөө үзүүлэхэд ашиглагдах ёстой. Энэхүү зөвлөгөөн болон зохицуулалт нь шинэ технологи, үйлчилгээг хэрэглэхэд системийн оролцогчдод сургалт, мэдээлэл явуулах хэрэгслээр хангаж өгч болно.

Доорх асуудлуудад хориг тавьж байгаа нь гол хууль, эрх зүйн саад хориг гэж тооцогддог:

- бага дүнтэй гүйлгээний хэрэгсэл, эцсийн хэрэглэгчдэд үзүүлэх гүйлгээний үйлчилгээ, эсвэл тэдгээрийн клирингийн зохицуулалтад шууд бусаар оролцох банк бус үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрөл;
- стандартчилагдсан цахим төлбөрт цаасан төлбөрийн хэрэгслийг шилжүүлэх, зураг болгох, тоон мэдээлэлд хөрвүүлэх;
- засгийн газрын төлбөрүүд зэрэг зарим их дүнтэй төлбөрүүдийг найдвартай, үр ашигтай төлбөрийн хэрэгсэл болон дэд бүтцийн систем рүү шилжүүлэх;
- цахим төлбөрийн болон дэд бүтцийн загварт зориулагдсан хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын стандартыг бүрэн авч хэрэглэх.

Шинэ дүрэм, журам, зах зээлийн стратегиуд нь цаашид шинээр хөгжиж буй төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээний эрэлт, мөн түүнчлэн тэдгээр шинэ зохицуулалтуудад шилжих төлбөрийн шилжилтэд дэмжлэг үзүүлж чадна. Жишээ нь, зарим улс орнууд бага дүнтэй клирингийн болон төлбөр тооцооны системээс илүү найдвартай, үр ашигтай их дүнтэй төлбөрийн системд их дүнтэй төлбөрүүдийг шилжүүлэхэд банкууд болон тэдгээрийн харилцагчдыг дэмжих зорилгоор их дүнтэй, цаасан төлбөрийн хэрэгслийн клирингийг хориглосон клирингийн төвийн дүрмийн боловсруулсан. Шууд дебит болон кредит шилжүүлгүүдийн цахим боловсруулалтад зориулан автомат клирингийн төвийг хөгжүүлсэн бусад улс орнууд нь чекийг гүйлгээнээс татан, цахимаар төлбөр хийх явдлыг хөгжүүлэх, мөн цахим дебит болон кредит шилжүүлгийг ашиглахыг дэмжих үүднээс клирингийн процесст цаасан чек зэрэг цаасан төлбөрийн хэрэгслүүдийн шилжүүлгийг хориглодог.

(i) Төв банкны оролцоо

Төв банк нь тодорхой шинэтгэлийг хариуцахдаа үйл явцад дэмжлэг үзүүлэх, магадгүй хувийн сектор болон эрх бүхий байгуулагыг өдөөхөд гол үүрэг гүйцэтгэх шаардлагатай байж болно. Төлбөрийн тохиромжтой төрлүүдийн (жишээ нь, цалин болон худалдааны бага дүнтэй төлбөрүүд) хувьд, төв банк шинэ, зардал багатай, аюулгүй бага дүнтэй төлбөрийн хэрэгсэл болон дэд бүтцүүдийн идэвхтэй хэрэглэгч байх болно. Түүнчлэн засгийн газрын санхүүгийн агент болохынхоо хувьд, төв банк нь тэдгээр шинээр үүсч буй

системүүдээр дамжуулан өөрийн бага дүнтэй төлбөрүүдийг шилжүүлэх, клиринг хийх, төлбөр тооцоо гүйцэтгэх зэрэгт хамгийн сайн журмуудын зөвлөгөөг өгч чаддаг. Эдгээр засгийн газрын төлбөрүүд илүү найдвартай, үр ашигтай шилжин, клиринг болон төлбөр тооцоо нь хийгдэх төдийгүй дэд бүтцийг сайжруулах шинэ санаачлагыг бий болгон, цаашлаад ирээдүйн тийм санаачлагуудыг урамшуулдаг.

Мөн төв банк өөрийн үйл ажиллагааны үүргээрээ дамжуулан эдгээр шинэтгэлүүдийн заримыг хялбарчилж чадна. Жишээлбэл, хамгийн наад зах нь төв банк банкны системийн бага дүнтэй төлбөрийн үйл ажиллагаанаас үүсэх банк хоорондын өр төлбөрийн төлбөр тооцоог хийх нөхцөл боломжоор хангадаг. Наад захын нөхцөл боломж гэдэгт төлбөр тооцооны данс болон төв банкнаас олгох зээлийн зохистой зохицуулалтыг оруулж болно. Үүнээс гадна төв банк нь бага дүнтэй төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээний шинэ, эрх бүхий үйлчилгээ үзүүлэгчид зориулан өөрийн клирингийн болон төлбөр тооцооны нөхцөл боломжийг ашиглахыг зөвшөөрсөн бодлогыг боловсруулж чадна. Зарим улс оронд, ийм наад захын ажиллагаа нь төв банкны бүрэн эрхэд хамаарах үүрэг хариуцлага байх нь ч бий.

Төв банк нь мөн их дүнтэй төлбөрийн эсвэл бага дүнтэй төлбөрийн дэд бүтцийг бие даан эсвэл банкны системтэй хамтран ажиллуулж болно. Төв банк бага дүнтэй төлбөрийн систем дэх өөрийн үйл ажиллагааны үүргээ үе үе хянан үзэж, энэхүү үүргийг гүйцэтгэж байгаа хувийн зах зээлийн чадавхийг үнэлдэг. Хэрвээ нийцэж байвал, төв банк бага дүнтэй төлбөрүүд дэх өөрийн дэд бүтцийн ажиллагааг магадгүй хувьчлах эсвэл аутсорсинг хийхдээ банкны системтэй хамтран төлөвлөгөө боловсруулах талаар бодож үзэх боломжтой. Хамгийн наад зах нь, хэрвээ шаардлагатай бол төв банк ижил төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа хувийн секторын зохицуулалтуудтай “шударгаар” өрсөлдөх өөрийн үйлчилгээний бодлогыг хянан үзэж, нэмж засварлаж болно.

Түүнчлэн төв банк өөрийн хяналтын болон бодлого боловсруулах үүргээрээ дамжуулан хувь нэмрээ оруулах боломжтой. Үүнээс гадна төв банк гол, бага дүнтэй төлбөрийн хэрэгсэл болон бага дүнтэй төлбөрийн дэд бүтцэд зориулагдсан технологийн дундын стандартын хөгжлийг хянах болон боловсруулахад дэмжлэг үзүүлж чадна. Бага дүнтэй төлбөрийн системийг их дүнтэй төлбөрийн дүн болон тоо хэмжээ өссөнөөр, мөн их дүнтэй төлбөрийн систем байгаа тохиолдолд системийн эрсдлээс хамгаалахын тулд, төв банк бага дүнтэй төлбөрийн клирингийн болон төлбөр тооцоонд хүлээн зөвшөөрөгдсөн нэгж гүйлгээний дүнд хязгаар тогтоох эсэх асуудлыг анхааран үзэж болно.

Удирдамж 12. Их дүнтэй төлбөрийн системийг хөгжүүлэх: банк хоорондын, хугацааны хувьд яаралтай төлбөрүүдийн өсөлт болон санхүүгийн зах зээлийн хэрэгцээнд үндэслэн их дүнтэй төлбөрийн системийг хөгжүүлэх шаардлагатай.

Тайлбар: Санхүүгийн зах зээл цаашид хөгжихийн хэрээр, их дүнтэй төлбөрийн систем нь банк хоорондын төлбөрийн шилжүүлгийн хамгийн зохистой дэд бүтэц болж байна. Санхүүгийн зах зээлийн хөгжлийг дагаад санхүүгийн гүйлгээтэй холбоотой банк хоорондын их дүнтэй төлбөрийн хувь хэмжээ өссөөр байна. Их дүнтэй төлбөрүүд нь өдөр дундын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын позицид нөлөөлдөг учраас харилцагчдын явуулж буй санхүүгийн гүйлгээнүүд нь цаг хугацааны хувьд яаралтай байдаг.

Гэхдээ санхүүгийн болон бусад бизнесийн гүйлгээтэй холбоотой төлбөрийн урсгалын дүн болон хэмжээ нь шууд гүйлгээнүүдэд эсвэл их дүнтэй төлбөрийн үйлчилгээнд оролцож буй санхүүгийн байгууллагын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын болон хөрөнгийн позицид аюул занал учруулахаар хангалттай их хэмжээтэй байдаг. Бага хэмжээгээр төрөлжсөн, үндсэн системд төлбөр тооцооны сүлжээний нэг оролцогч төлбөр тооцооны үүргээ биелүүлэхгүй байх нь бусад оролцогчдын төлбөрийн үүргээ биелүүлж чадахгүй болох шалтгаан нь болж чаддаг. Ийм төлбөрийн үүргээ гүйцэтгэх чадваргүй болох явдал нь бусад төлбөрийн сүлжээ болон санхүүгийн зах зээл рүү тархааж, “бохирдуулж” болох учраас халдвартай байдаг. Энэ эрсдэл нь бүх системийн болон систем хоорондын санхүүгийн эрсдлийг бууруулахад зориулагдаагүй төлбөр тооцооны зохицуулалтын хувьд системийн шинжтэй байж болно. Тиймээс ч их дүнтэй төлбөрт зориулагдсан системийг хөгжүүлэх үндсэн шалтгаан нь оролцогчдын төлбөр түргэн гүйцэтгэх болон зээлийн бодит алдагдлын системийн нөлөөллийг хянах явдал юм.

Их дүнтэй төлбөрийн системийн төрлүүдийн бизнес шинжилгээг маш болгоомжтой хийх ёстой. Уг системийн загвар нь эдийн засгийн чадавхи болон тодорхой төлбөрийн хэрэгцээ шаардлагаас хамаарна. Ихэнх тохиолдолд, их дүнтэй төлбөрийн систем нь дараахь гурван зорилгын тэнцвэрийг хангахад зориулагддаг: (i) цаг хугацааны хувьд яаралтай төлбөрүүдийн төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх (төлбөрийн дүнгээс үл хамааран); (ii) системийн эрсдлийг бууруулах; (iii) оролцогчдын хувьд төлбөр түргэн гүйцэтгэх болон үйл ажиллагааны зардлыг боломжит хамгийн бага түвшинд хүргэх.

Хэдийгээр их дүнтэй төлбөрийн системийн шууд хэсэг биш ч, үр нөлөөтэй банк хоорондын зээлийн зах нь хэтэрсэн үлдэгдэлтэй байгаа төв банкны хөрөнгөөс шаардлагатай байгаа төв банкны хөрөнгө рүү дахин хуваарилалт хийдэг. Тиймээс энэ нь банк хоорондын төлбөр тооцоог үр ашигтайгаар, цаг тухайд нь гүйцэтгэхэд дэм болдог байна. Түүнчлэн, зөвхөн төлбөрийн шилжүүлэг төдийгүй өдөр дундын зээл, овернайт буюу богино хугацааны зээл болон банк хоорондын зээлийн захтай холбоотой ихэнх санхүүгийн гүйлгээнүүд нь санхүүгийн байгууллагуудад өөрсдийн харилцагчдын төлбөрийг түргэн гүйцэтгэх хэрэгцээг санхүүжүүлж, үүний үр дүнд эцсийн хэрэглэгчийн

зах зээл дээрх төлбөрийн шилжүүлгийг хурдасгахад тусалж чаддаг байна. Эцэст нь санхүүгийн систем хөгжсөнөөр, үүний төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шаардлага өсч болох юм. Банк хоорондын зээлийн зах нь төв банкинд байршуулах мөнгөн хөрөнгийн банк тус бүрийн хэрэгцээ, шаардлагыг бууруулж чадна.

Хэрэгжилт: Энэхүү удирдамжийг хэрэгжүүлэх дараахь гурван бүрэлдэхүүн хэсэг байна: (i) төлөвлөлтийн шатан дахь бизнесийн болон бусад шинжилгээ; (ii) их дүнтэй төлбөрийн системийн тохиромжтой загвар; (iii) төв банкны үүрэг.

(i) Бизнесийн бодит шинжилгээнд тулгуурлах нь

Шинэ дэд бүтцийг хянан үзэхдээ, их дүнтэй төлбөрийн системд хийх бизнесийн шинжилгээг хийхийн тулд тусгайлсан, их дүнтэй төлбөрийн системийг хөгжүүлэх зайлшгүй шаардлага байгаа эсэх, эсвэл одоо байгаа клирингийн болон төлбөр тооцооны дэд бүтэц нь систем дэх их дүнтэй төлбөрийн одоогийн болон таамаглаж буй гүйлгээний тоо ширхгийг төлбөр тооцоонд оруулан, клиринг хийхэд зардлын хувьд хэмнэлттэй байж чадах эсэх талаар анхаарах ёстой. Бодит шинжилгээг хэрэгжүүлэхдээ дор дурьдсан гол хүчин зүйлүүдийг анхаарах хэрэгтэй:

- их дүнтэй, цаг хугацааны хувьд яаралтай төлбөрүүдийн одоогийн болон ирээдүйд таамаглагдаж буй дүн болон тоо хэмжээ;
- их дүнтэй төлбөр тооцооны үйлчилгээний эрэлтэд түлхэц өгдөг үнэт цаасны болон бусад банк хоорондын зээлийн захын гүйлгээг оролцуулаад санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх санаачлагууд;
- одоо байгаа төлбөр тооцооны системийн их дүнтэй төлбөрүүдийн төлбөр тооцооноос үүсч болох системийн эрсдлийн боломж;³
- тусгайлсан, их дүнтэй төлбөрийн системийн зардалтай харьцуулсан төлбөрийн тодорхой урсгал дахь бага дүнтэй төлбөрүүд болон их дүнтэй буюу цаг хугацааны хувьд яаралтай төлбөрүүдийн хоёулангийн төлбөр тооцоог гүйцэтгэхийн тулд одоо байгаа системийг сайжруулах зардал;

³ Төлбөрийн системд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, зээлийн болон системийн эрсдлүүдийг хэмжих янз бүрийн аргууд байдаг. Эдгээрээс хамгийн энгийн нь болзошгүй алдагдлын ирээдүйг төсөөлсөн хэмжигдэхүүнээс илүүтэйгээр абсолют буюу харьцангуй нөхцөл дэх алдагдлын өнгөрсөн үед суурилсан хэмжигдэхүүн байдаг. Системийн эрсдлийн илүү нарийн төвөгтэй хэмжигдэхүүн нь төлбөр тооцооны системийн “дуураймал загвар”-ыг ашигладаг. Энэ нь оролцогчдын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын болон зээлийн алдагдлыг үнэлэхдээ тэдгээрийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон хөрөнгийн позицгийг оролцогчийн саатлаас учирч болох нөлөөллийн боломжид харьцуулж сүлжээний оролцогчдын хоорондын хоёр талын төлбөрийн урсгалын загварыг авч үздэг.

- бусад их дүнтэй төлбөрийн системд төв банкнаас үзүүлж буй холбогдох дэд бүтцийн үйлчилгээ болон зээлийн хэрэгслүүдийн зардал, шинж;
- хил дамнасан арилжаа, түүнчлэн санхүүгийн зохицуулалт болон байгууллагуудад оролцоход их дүнтэй төлбөрийн системийн ач холбогдол.

Харьцангуй энгийн загвар бүхий их дүнтэй төлбөрийн системийг суурилуулах технологийн зардлууд хэт өндөр биш байж болно. Илүү их хэмжээний зардал нь оролцогчдын дотоод систем дэх шаардлагатай технологийн болон аргачлалын өөрчлөлтөөс, түүнчлэн зайлшгүй хийгдэх эрх зүйн шинэтгэлүүдийг хэрэгжүүлэх болон хөгжүүлэх үл анзаарагдам зардлуудаас үүсч болох юм.

(ii) Төлбөрийн хэрэгцээнүүдэд тохирох дэд бүтцийн загварыг сонгох нь

Их дүнтэй төлбөрийн системийг хөгжүүлэхийн тулд одоо байгаа зохицуулалтад нөлөөлж чадах өөрчлөлтүүдийг байнга хийж байх шаардлагагүй юм. Зарим тохиолдолд, одоо байгаа арга хэрэгсэл, технологийн үйлчилгээ нь мөнгөний бодлогын гүйлгээнүүдтэй холбоо бүхий их дүнтэй гүйлгээнүүдийг оролцуулаад, их дүнтэй төлбөрүүдийн найдвартай, үр ашигтай төлбөр тооцооны тусгай шаардлагад зохицсон байж болох юм. Жишээлбэл, олон төрлийн төлбөрийн урсгалын системийн хөгжил их дүнтэй, цаг хугацааны хувьд яаралтай төлбөрүүдэд зориулагдсан урсгалуудын ядаж л нэгэнд нь оролцож болно. Хэдийгээр их дүнтэй төлбөрийн системийг одоо байгаа дэд бүтцийн хүрээнд боловсруулсан ч, тус системийн найдвартай, үр ашигтай төлбөр тооцоонд тусгайлан зориулагдсан дүрмүүд, эрсдэл бууруулах хяналтын хэрэгсэлтэй байх шаардлагатай.

Гэхдээ, бодит шинжилгээ нь салангид, тусгай зориулалтын их дүнтэй төлбөрийн системийн зайлшгүй хэрэгцээг харуулж болно. ТТСХ-ны 2005 онд хэвлэгдсэн *Их дүнтэй төлбөрийн системийн шинэ хөгжлүүд* хэмээх тайланд тусгай зориулалтын их дүнтэй төлбөрийн системийн төрөл бүрийн загваруудыг тодохойлсон байна. Энэ нь бодит цагийн их дүнтэй төлбөр тооцооны систем (БЦИДТТС/RTGS) – ийн янз бүрийн төрлүүдийг болон БЦИДТТС болон тодорхой цагийн үр дүнгийн төлбөр тооцооны системийн онцлог шинжүүдийг хослуулсан системүүдийн бусад төрлүүдийг судлан үзсэн байна.

Сонгосон загвараас үл хамааран, их дүнтэй төлбөрийн системийн эрсдлүүдийг ТТСХ-ны Системийн хувьд чухал төлбөрийн системийн үндсэн зарчмуудад (CPSIPS(2001)) нийцүүлэн удирдах ёстой.⁴ Эдгээр бүх системүүд дэх санхүүгийн эрсдлийн хязгаар нь

⁴ Нэгэнт Үндсэн Зарчмууд хамгийн наад захын стандартуудыг тоймлон харуулснаар үндэсний төлбөрийн системийн эрх мэдэл бүхий байгууллага өөрсдийн улс орны их дүнтэй төлбөрийн дэд бүтэц болон бусад

дараахь зүйлсийг багтаасан хууль, эрх зүйн үндэслэлийг шаарддаг: (i) банк хоорондын төлбөр тооцоо эцсийн байх болон төлбөрийг нэг бүрчлэн гүйцэтгэх; (ii) үр дүнгийн төлбөр тооцоог хийх тохиролцоо; (iii) зээл, төлбөр түргэн гүйцэтгэх нөхцөл, алдагдал хуваах болон төлбөр тооцоог баталгаажуулсан барьцаа. Үйл ажиллагааны эрсдлийн хүрээ нь нөөц төхөөрөмж, сэргээхэд шаардагдах хамгийн их хугацаа, байгууламжийн хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал болон кибер аюулгүй байдлын талаар үүсч буй олон улсын “шилдэг туршлагауд” – тай нийцсэн найдвартай, тасралтгүй байдлын зохицуулалттай хамаатай байж болно. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын болон зээлийн эрсдлийг мөн үр нөлөөтэйгээр удирдаж, тодорхойлох ёстой бөгөөд төлбөр тооцоо гүйцэтгэх хөрөнгө нь төв банкны мөнгө буюу бусад найдвартай хөрөнгө байна. Дарааллын алгоритм эсвэл үр дүнгийн тохиролцоо зэрэг механизмуудыг эрсдэл агуулсан механизмуудтай нийцүүлэн, тэдгээрийн хуулийн үндэслэлтэй тохируулах ёстой.

Шинээр систем байгуулахдаа түүний хэрэглэгчдийн тодорхой хэрэгцээг хангахад юу хамгийн чухал вэ гэдгээс эхэлнэ. Загвар нь хангалттай уян хатан, ирээдүйд бий болох хэрэгцээг хангаж чадахуйц, өргөжүүлж болохоор байх ёстой. Гэхдээ, хязгаарлагдмал нөөцтэйгээр оролцож буй санхүүгийн байгууллагууд зарим үед хүний нөөцийн сургалт болон илүү боловсронгуй бүрдэл хэсгүүдэд тасралтгүй хөрөнгө оруулах шаардлагатай байж болно.

(iii) Төв банкны оролцоо

Төв банк их дүнтэй төлбөрийн системийг хөгжүүлэхэд гол хувь нэмрийг оруулах хэрэгтэй. Жишээлбэл, өөрийн үйл ажиллагааны үүргийн хүрээнд төв банк нь ядаж л дараахь үйлчилгээг үзүүлэхийн тулд өөрийн арга хэрэгслээ боловсронгуй болгох ёстой: (i) оролцогч байгууллагуудын хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэх хөрөнгө болон ашиглагддаг харилцах данс; (ii) сүлжээний оролцогчдод олгох өдөр дундын болон овернайт зээл; (iii) тухайн системд зориулагдсан эрсдлийн хяналтын болон эрсдлийг удирдах аргуудын загварын талаарх мэргэжлийн ур чадвар. Ерөнхийдөө, их дүнтэй төлбөрийн систем дэх төв банкны үүрэг роль илүү өргөн цар хүрээтэй байдаг. Төв банкууд их дүнтэй төлбөрийн системийн эзэмшигч буюу оператор болж байдаг. Олон улс оронд цорын ганц тусгай зориулалтын, их дүнтэй төлбөрийн систем байдаг бол, зарим улсад нэгээс олон байдаг байна.

Төв банкууд өөр өөр шалтгаанаар их дүнтэй төлбөрийн системийн эзэмшигч болон оператор болох эсэхээ шийддэг. Зарим тохиолдолд жишээ нь, бодит цагийн нэг бүрчилсэн төлбөр тооцооны систем бүхий загвар нь санхүүгийн байгууллагуудын нээсэн төлбөр тооцоо болон зээлийн дансыг удирдан, үйл ажиллагаа явуулдаг төв банкны дотоод системтэй маш хялбар холбогдож чаддаг. Хэрвээ төв банк их дүнтэй төлбөрийн системийн

холбогдох нэн чухал системүүд дэх үйл ажиллагааны болон санхүүгийн эрсдлийг хязгаарлах илүү нарийн стандартуудыг хэрэглэхээр сонгох боломжтой юм.

оператор бол ялангуяа мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх арга хэрэгсэлд илүү үр ашигтай байж болно. Үнэндээ төв банк системийн оператор мөн ч байсан биш ч байсан, төв банкны мөнгөний бодлоготой холбоотой бүх гүйлгээнүүд болон бусад банк хоорондын гүйлгээнүүд, түүнчлэн засгийн газрын агентлагуудын том хэмжээний, их дүнтэй төлбөрүүд одоо байгаа ямар нэгэн найдвартай, үр ашигтай их дүнтэй төлбөрийн системээр дамжин хийгдэх ёстой. Эцэст нь, ерөнхийдөө санхүүгийн системд их дүнтэй төлбөрийн системийн, системийн хэмжээний ач холбогдлоос шалтгаалан, оролцогчдыг дүрэм, журмыг сахин биелүүлэх болон албадан гүйцэтгэлийг хангуулах илүү баталгаатай байлгахын тулд төв банкныг шууд их дүнтэй төлбөрийн системийн ажиллагааг удирдах нь илүү дээр гэж үзэх нь бий.

Их дүнтэй төлбөрийн системийг хувийн сектор удирдаж байна уу эсвэл төв банк эзэмшиж, ажиллагааг нь удирдаж байна уу гэдгээс үл хамааран төв банк уг системийг хянаж байх ёстой. Төв банкны их дүнтэй төлбөрийн хяналт нь тус системүүдийн загвар болон ажиллагаанд зориулагдсан ТТСХ-ны Үндсэн Зарчмууд гэх зэрэг хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын стандартыг ашиглах ёстой. Үүний тулд төв банк дараахь зүйлсийг анхаарах ёстой: (i) системийг ажиллуулах хууль, эрх зүйн үндэслэл; (ii) зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын болон үйл ажиллагааны эрсдлийг удирдах техникийн, дүрэм журмын болон үйл ажиллагааны загвар; (iii) системийн үр ашиг, жишээ нь, төлбөр тооцоонд оролцогчдын үйлчилгээний түвшин, боломжит үнийн бодлого болон арга зүй; (iv) төлбөр тооцооны арга хэрэгслүүдийг хэрэглэх нөхцлүүд; (v) системийн удирдлагын зохицуулалт.

Их дүнтэй төлбөрийн системийг шинэтгэх болон боловсронгуй болгоход, эзэмшигч эсвэл операторын аль нэг байсан ч, төв банк эрх бүхий байгууллага болон бусад байгууллагын зайлшгүй үйлдлийг өдөөх үүргээ үр дүнтэйгээр гүйцэтгэж чаддаг. Жишээлбэл, дараахь байдлаар зөвлөлдөн, дэмжлэг үзүүлж болно:

- их дүнтэй төлбөрийн систем дэх янз бүрийн өртөг болон эрсдэл бууруулах талаар эрхэмлэж буй бодлого болон тодорхой хэрэгцээг үнэлэх болон тодорхойлоход банкны байгууллагатай;
- мэдээллийн технологийн тусгай шийдлийг хөгжүүлэхэд мэдээллийн технологийн шинжээчидтэй;
- их дүнтэй төлбөрийн системд зориулагдсан үндэслэл бүхий хууль, эрх зүйн болон зохицуулалтын орчинг боловсруулахад хууль, эрх зүйн шинжээчид болон холбогдох зохицуулалтын агентуудтай;
- санхүүгийн гүйлгээнүүдийн үр ашигтай, найдвартай байдлыг дэмжих зорилгоор их дүнтэй төлбөрийн болон үнэт цаасны системүүдийг холбоход туслахын тулд үнэт цаасны эрх бүхий байгууллагуудтай.

Хэдийгээр энэ нь үндсэндээ банк хооронд хөрөнгийг шилжүүлэх болон хүлээн авахад зориулагдсан зах зээлийн хэвшил, стандартчилагдсан гэрээ, журам, технологид шаардлагатай банкны системийн хүрэн дэх хамтын ажиллагаа боловч, банк хоорондын

зээлийн захыг хөгжүүлэхэд төв банк мөн дэмжлэг үзүүлэх ёстой. Түүнчлэн төв банк нь банк хоорондын зээлийн захыг хөгжүүлэхэд зээлийн бодлогынхоо үзүүлж чадах нөлөөллийг мэдэж байх учиртай. Зайлшгүй үед банк хоорондын зээлийн болон бусад мөнгөний зах зээлийн гүйлгээнүүдтэй холбоотой төлбөр тооцооны дансдаар хийгдэх банк хоорондын хөрөнгийн шилжүүлгийг хялбарчлахын тулд өөрийн үйл ажиллагааны систем болон бодлогоо дахин боловсруулж болно.

Удирдамж 13. Төлбөрийн болон үнэт цаасны системийг хослуулан хөгжүүлэх: *санхүүгийн системийн үр ашигтай, аюулгүй байдлыг хангахын тулд үнэт цаасны болон их дүнтэй төлбөрийн системүүдийг нийцүүлэн хөгжүүлэх ёстой.*

Тайлбар: Шигтгээ 18-д үзүүлснээр, үнэт цаасны системийн дэд бүтэц нь үнэт цаасны гүйлгээний, бүртгэлийн, хадгаламжийн (кастодианы), депозитын, клирингийн болон төлбөр тооцооны үйлчилгээний нөхцлөөс шалтгаалан өөр өөр байгууллагуудаас хамаарч байна.

Үнэт цаасны систем болон их дүнтэй төлбөрийн систем нь харилцан хамааралтай юм. Төлбөрийн эсрэг нийлүүлэлтийг (DVP) хангахын тулд үнэт цаасны төлбөр тооцоо (ҮЦТТ)-ны системийн үнэт цаасны гүйлгээ талын (settlement leg) тооцоо нь үндсэндээ их дүнтэй төлбөр (ИДТ)-ийн системд хийгдэх мөнгөн хөрөнгийн талын (cash leg) тооцоотой хамааралтай байна. Үүний адилаар ИДТ-ийн системийн зээлийн хэрэгсэл нь үнэт цаасны систем дэх барьцааны гэрээ нөхцөлтэй уялдсан байдаг. Иймээс эдгээр дэд бүтцүүдийн шаардлагын хоорондын харилцан ажиллагаа нь үр ашигтай, найдвартай, аюулгүй байх ёстой.

Төлбөрийн болон үнэт цаасны төлбөр тооцоог аюулгүй, үр ашигтай хийх нийтлэг зорилгыг хангахын тулд ҮЦТТ-ны болон ИДТ-ийн системийн дүрэм журмыг боловсронгуй болгох шаардлагатай. Цаашилбал, нэг систем дэх төлбөрийн эцсийн байх (finality) нөхцөл бусад системүүдийнхтэй нийцэж байх ёстой. Ингэснээр үнэт цаасны болон их дүнтэй төлбөрийн дэд бүтцүүд нэг нь нөгөөгөөсөө салангид хөгжих боломжгүй болох юм.

Шигтгээ 18.

Үнэт цаасны системийн дэд бүтэц

Арилжааны систем

- Жижиглэнгийн арилжааны систем нь харилцагчийг дилертэй захиалга оруулах болон баталгаажуулах зориулалт бүхий төрөл бүрийн харилцаа холбоогоор, харилцагчдын арилжааг хийж буй дилерүүдийг хооронд нь төвлөрсөн болон төвлөрсөн бус төрөл бүрийн гүйлгээний системүүдээр холбож байдаг.
- Бөөний арилжааны систем нь дилерүүдийн өөрсдийн дансдаар дамжуулан, дилер хоорондын их дүнтэй болон их хэмжээний гүйлгээг хийхэд зориулагдсан байдаг. Үндсэн систем нь телефон эсвэл компьютер дээр суурилсан болон дэлгэц дээр суурилсан брокерийн системүүд байдаг.
- Квотод суурилсан (quote-driven), цахим захиалга бүртгэх, арилжаа тулгах (trade matching) зэрэг бусад системүүдийг зарим тохиолдолд арилжааны орлох систем гэж нэрлэдэг. Харилцагч бүр шууд хандах боломжтой жижиглэнгийн систем нь харилцагчийн арилжааны үнийн санал (bid-ask) болон хэмжээ, түүнчлэн интернэтэд суурилсан холболтоор сүлжээний төв төхөөрөмжид харилцагчийн оруулж, баталгаажуулж буй хоёр талын арилжааг харуулдаг. Үүнтэй адил төстэй системүүдийг дилер хоорондын арилжаанд ашигладаг.

Бүртгэл болон хадгаламж (кастоди)

- Үнэт цаасны бүртгэл гэдэг нь гаргасан үнэт цаас нэг бүрээр үнэт цаас өмчлөгчийг тодорхойлж, эзэмшигч хооронд хүү болон ногдол ашгийн төлбөр, эрх, баталгаа, нөхцөл зэргийг хуваарилах позицйн хэмжээг тогтоон үнэт цаас гаргагчид үзүүлж буй үйлчилгээ юм. Үнэт цаасны бүртгэлийн ажилтан биет болон цахим үнэт цаасны гэрчилгээг бүртгэгдсэн эзэмшигч эсвэл тэдгээрийн бүртгэгдсэн агентад (өөрөөр хэлбэл, брокерууд болон эзэмшигчийг төлөөлж буй кастодиан буюу хөрөнгө оруулалтын дилер) гаргаж өгч болдог.
- Үнэт цаасны хадгаламж (кастоди) гэдэг нь үнэт цаасны эзэмшилтэй холбоотой биет болон цахим шилжүүлгийн үйлчилгээг үзүүлэх болон үнэт цаасны дансуудыг удирдах зорилго бүхий үнэт цаас эзэмшигч (эзэмшигч болон барьцаа хөрөнгийн эзэмшигч) буюу тэдгээрийн агентад үзүүлж буй үйлчилгээ юм. Кастодианы үйлчилгээ үзүүлдэг банкууд харилцагчдадаа үнэт цаасны дансаа удирдах үйлчилгээг үзүүлдэг байна.
- Кастодианы үйл ажиллагаа эрхэлдэг банкууд харилцагчдадаа төлбөртэй холбогдолтой үйлчилгээ үзүүлж болно.

Үнэт цаасны депозитор

- Үнэт цаас депозитор гэж үнэт цаасны кастодиан банк (ҮЦКБ) болон агент, брокер, хөрөнгө оруулалтын дилер, хөрөнгө оруулалтын сангийн менежер зэрэг өөрийн гишүүдийн үнэт цаасыг хадгалж буй байгууллага. Гишүүн бүр тус байгууллагад үнэт цаасны данстай байж болно.
- Ерөнхийдөө үнэт цаасны олон төрлийн депозитор нь байгууллага хоорондын цахим шилжүүлэг хийхийн тулд харилцан бие биендээ эсвэл ҮЦИБ-нд харилцах данс нээдэг.
- Гишүүн хоорондын бүх шилжүүлгүүд ихэвчлэн цахим шилжүүлгүүд (өөрөөр хэлбэл, биет бус шилжүүлэг) байх ба гаргасан үнэт цаас нь депозиторуудын дотор эргэлтэд орохгүй байх төдийгүй үнэт цаас гаргагч болон бүртгэлийн ажилтнуудын гаргадаг биет хэлбэрээс илүүтэйгээр материаллаг бусаар байж болно.

Үнэт цаасны төлбөр тооцооны систем

- Үнэт цаасны төлбөр тооцооны систем (ҮЦТТС) нь гишүүдээ үнэт цаасны клирингийн

болон төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг. Төлбөр тооцооны системийн гишүүдэд төв банк, арилжааны банк, ҮЦИБ, брокерууд, хөрөнгө оруулалтын дилер болон менежерүүд хамаарна. Эдгээр төлбөр тооцооны системийн гишүүд нь үнэт цаасны төлбөр тооцооны системийн оператор буюу түүний агент болохын хувьд үнэт цаасны данс, мөнгөн хөрөнгийн болон барьцаа хөрөнгийн дансуудыг нээж ашигладаг.

- Үнэт цаасны клиринг болон төлбөр тооцоо нь олон төрлийн үнэт цаасны арилжаа хийгдсэнээр үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн шилжүүлэг хийхэд оролцогчдын харилцан хүлээх төлбөрүүдийг тооцоолохтой холбоотой юм. Үнэт цаасны төлбөр тооцоо нь гүйлгээ нэг бүрээр (арилжаа бүрээр) эсвэл тухайн оролцогчийн үнэт цаасны дансыг дебитэлж мөнгөн хөрөнгө/барьцаа хөрөнгийн дансанд бичилт хийснээр үнэт цаас бүрийн үр дүнгийн тооцооны үндсэн дээр (net basis) гүйцэтгэгддэг. Үнэт цаасны өр төлбөрийн шилжүүлэг нь төлбөр тооцоо хийгдэж буй тухайн өдөртөө мөнгөн хөрөнгийн төлбөртэй харьцан төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн үндсэн дээр хийгдэнэ.
- Зарим системд арилжааны хэд хэдэн төрлүүд дээр бүх төлбөр тооцооны гишүүдийн хувьд арилжааны төв түнш (АТТ/Central counterparty) нь хууль ёсны оролцогч түнш (counterparty) болдог байна. Ихэнхдээ АТТ нь төлбөр тооцооны агент-системийн төлбөр тооцооны банк болох төв банкин дээр мөнгөн хөрөнгийн төлбөр тооцооны дансыг нээдэг. АТТ нь мөнгөн хөрөнгө шилжүүлж буй төлбөр тооцооны гишүүдээс хөрөнгийг хүлээн авч тухайн өдөрт нь үнэт цаас шилжүүлж буй оролцогчид шилжүүлдэг.

Хэрэгжилт: Хэдийгээр ҮЦТТС ба ИДТС-үүдийг боломжтой бол хослуулан хөгжүүлэх нь зохимжтой ч хязгаарлагдмал нөөцөөс шалтгаалан аль нэгийг нь эрчимтэй хөгжүүлэх нь илүү дээр байж болох юм. ИДТС-ийг зөвхөн үнэт цаасны арилжаанд хамаарал бүхий системтэй харьцуулахад банк хоорондын зээл, мөнгөний бодлогын гүйлгээ зэрэг гүйлгээний өргөн хүрээг хамардаг учраас ИДТС нь илүү чухал систем. Иймээс ерөнхийдөө өөрчлөлт шинэчлэлт, хөгжлийн нэн тэргүүний чиглэл бол их дүнтэй төлбөрийн систем юм. Хэдий тийм ч үнэт цаасны системийн өөрчлөлт нь дагаж явах шаардлагатай гэдэг үүднээс их дүнтэй төлбөрийн системийн дэд бүтэц болон үнэт цаасны гол дэд бүтцийн харилцан хамаарлыг судлан төлөвлөх хэрэгтэй. Ерөнхий удирдамж үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэхэд чиглэж байгаа учраас энэ тусгайлсан удирдамжийг хэрэгжүүлэх гол стратеги бол найдвартай, үр ашигтай төлбөрийн системийг дэмжихэд их дүнтэй төлбөрийн системд үнэт цаасны дэд бүтцийн хөгжлөөс юу шаардлагатайг анхаарах явдал юм.

- (i) *Үнэт цаасны гол дэд бүтцүүдийн найдвартайгаар харилцан ажиллах боломжийг дэмжих*

Кастоди болон бүртгэлийн зохицуулалт дахь ажиллагааны үр ашигтай, найдвартай, аюулгүй байдал нь үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны системд төдийгүй ИДТС-ийн хувьд ч чухал. Зарим зохицуулалтад оролцогчдын үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн дансууд өөр өөр системүүдэд нээгдсэн байж болно. Жишээ нь: ҮЦТТС-д үнэт цаасны данс, ИДТС-д мөнгөн хөрөнгийн данс нээгдсэн байдаг. Төлбөрийн эсрэг нийлүүлэлтийг хангахын тулд ИДТС-ийн болон ҮЦТТС-ийн мэдээллийн технологи өндөр төвшинд харилцан холбогдох ёстой.

Хэрвээ өөр өөр байгууллагууд олон төрлийн үнэт цаасны дэд бүтцийн үйлчилгээ үзүүлж байвал үнэт цаасны болон төлбөрийн системийн хоорондын үр ашгийг сайжруулах санаачлагууд нь дараахь шаардлагыг агуулсан байна:

- Үр ашигтай төлбөрийн эсрэг нийлүүлэлтээр болон боловсруулалтын алдааг бууруулах нэвт боловсруулалтаар (straight through processing) хангах зорилгоор биет нийлүүлэлтээс илүү үнэт цаасны цахим шилжүүлэгт зориулагдсан мэдээллийн технологи;
- Тэдгээрийн мэдээллийн болон харилцаа холбооны технологийн харилцан ажиллах боломж болон стандарт; эсвэл
- Үнэт цаасны депозит, клиринг, төлбөр тооцоо болон АТТ-ийн үйлчилгээ зэрэг зарим үйлчилгээг төвлөрүүлэх боломж.

Олон төрлийн үйлчилгээний зохион байгуулалтын төвлөрөл буюу техникийн нэгдэл нь салангид системүүдийг зохицуулахтай холбогдон үүсэх үйл ажиллагааны эрсдлийг бууруулах ач холбогдолтой. Гэвч энэ нь нэгдсэн технологийн платформ буюу нэг оператор-байгууллагад санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдлүүд төвлөрөх боломжийг өсгөх талтай. Иймээс ИДТС-ийн болон үнэт цаасны гол дэд бүтцүүдийн харилцан ажиллах боломж өндөр төвшинд байх тусам дэд бүтцийн тасралтгүй байдлын төлөвлөгөө болон тогтвортой байдалд илүү чухал нөлөөтэй.

(ii) Төлбөрийн гүйлгээ талын (payment leg) найдвартай, үр ашигтай төлбөр тооцоог хангах ҮЦТТС-ийг тодорхойлох нь

ИДТС-тэй үр ашигтай, найдвартайгаар харилцан холбогдож чадах үнэт цаасны төлбөр тооцооны хэд хэдэн систем байдаг. Зарим үнэт цаасны системд оролцогч нь үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн дансыг хоёуланг нь эзэмшиж байдаг. Тийм системд гүйлгээ нэг бүрээр хийгдэх ажил гүйлгээний хувьд төлбөрийн эсрэг нийлүүлэлт нь хялбар байх боловч төлбөр тооцоо эцсийн байх тухайд санхүүгийн болон хууль зүйн хамгаалалтгүй гүйлгээ бүрийн мөнгөн хөрөнгийн тал (cash leg) нь мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоог төв банкин дахь хөрөнгөөрөө хийдэг системтэй харьцуулахад илүү эрсдэлтэй байх талтай. Ерөнхийдөө тэдгээр системүүдийн мөнгөн хөрөнгийн данс ИДТС-ээр хийгдэж байгаа төлбөрийн шилжүүлгүүдээр санхүүжигдэж, эс санхүүжигдэж байдаг. Оролцогчдоо мөнгөн хөрөнгийн дансаар хангадаггүй ҮЦТТС нь үнэт цаасны төлбөр тооцоог төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмаар гүйцэтгэхийн тулд ИДТС-тэй нягт холбогдох шаардлагатай.

ИДТС-ийн нэгэн адилаар ҮЦТТС-д системийн дотоод үр ашиг болон найдвартай байдлаараа ялгаатай төрөл бүрийн загварууд байдаг. Аль загвар нь тухайн оронд илүү тохиромжтой эсэх нь санхүүгийн системийнх нь хэрэгцээ шаардлага, боломж, бусад үнэт цаасны дэд бүтцийн зохион байгуулалт, түүнчлэн тодорхой хэмжээгээр ИДТС-ийн загвараас хамаардаг байна.

Юутай ч ҮЦТТС-ийн загвар нь тухайн орныхоо санхүүгийн системийн хэрэгцээ шаардлага, боломжтой маш сайн нийцсэн ч Төлбөр тооцооны ситемийн хороо - Үнэт

цаасны комиссын олон улсын байгууллагын (CPSS-IOSCO) ҮЦТТС-д зориулсан Зөвлөмж болон АТТ-д зориулсан Зөвлөмжийг бүрэн хангасан байх шаардлагатай. Эдгээр нь бүгд төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарим хэлбэр, мөн үнэт цаасны болон төлбөр тооцоо эцсийн байх зарчмыг хангаж байх ёстой. Тодорхой загварууд нь эрсдлийн удирдлагын журмуудын дараахь ялгаанаас хамаарч болно. Үүнд: (i) дансны улайлтын дээд хэмжээ (net debit caps) болон хоёр талын зээлийн хязгаар (bilateral credit limits); (ii) барьцааны үнэт цаасны зохистой маржинтай (margin) төлбөр тооцооны үүргийн хуулийн үндэслэл бүхий тогтвортой барьцаа; (iii) алдагдал хуваах механизм болон төлбөр тооцооны баталгаа. Цаашид системийг боловсронгуй болгохын тулд оролцогчдод өдрийн туршид өөрсдийн үнэт цаас болон мөнгөн хөрөнгийн позицио удирдахад болон операторуудад гүйлгээ хийх үед бэлэн байлгах үнэт цаас болон мөнгөн хөрөнгийг үнэлэхэд тусалж буй оролцогчдын үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн төлбөр тооцооны позицитайн талаарх бодит цагийн мэдээллийг багтаах хэрэгтэй.

(iii) Үнэт цаасны гүйлгээний мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоог дэмжих эрх зүйн зохицуулалт

Үнэт цаасны системийн хууль зүйн тогтолцоо нь эрх зүйн шинэтгэлийн урьдчилсан нөхцөл болох ёстой. Энэ нь ИДТС-ийн эрх зүйн тогтолцооны нэгэн адил тогтвортой байх ба энэхүү хоёр систем нь харилцан нийцэж, бие биенээ дэмжих шаардлагатай. Үнэт цаасны цахим шилжүүлэг болон бүртгэлийн талаарх хууль зүйн тогтолцоог үнэт цаасыг гаргах, хадгалах, барьцаалах, үнэт цаасны гүйлгээний шилжүүлэг болон төлбөр тооцоо хийхэд зориулагдсан хууль зүйн үндэстэй хамтад нь хурдан бий болгох ёстой. Зөвхөн ИДТС-ийн хувьд үнэт цаасны төлбөр тооцоотой хамаатай хууль зүйн тогтвортой үндэс нь дараахь зүйлүүдээс хамаарна: (i) үнэт цаасны төлбөр тооцоо эцсийн байх нөхцөл; (ii) хэлцлийн өмнө хүлээсэн үүргийг шинэ үүргээр солих болон үр дүнгийн тооцоо (netting); (iii) хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрсдлийн хяналт, барьцааны эрх болон алдагдал хуваах тохиролцоо; (iv) үнэт цаасны төлбөр тооцоонд мөрдөх дүрэм болон гэрээ; (v) үнэт цаасыг материаллаг бус болгохтой холбоотойгоор цахим үнэт цаасны шилжүүлэг болон эзэмшил.

Үнэт цаасны системийн үйлчилгээний зах зээлийн зохион байгуулалтай холбоотойгоор энгийн оролцогчдын үнэт цаасны гол төлбөр тооцоо болон их дүнтэй төлбөрийн дэд бүтцийг ашиглах зохицуулалтын, хууль зүйн, бодлогын тогтолцоо нь шинэтгэлийн үйл явцын эхний шатанд харилцан нийцсэн байх ёстой. Үнэт цаасны болон их дүнтэй төлбөрийн дэд бүтцийн үйлчилгээг үзүүлэгч болон хэрэглэгчийн хоорондын гэрээ хэлцлийн хууль зүйн тогтвортой байдал, үйл ажиллагааны зохицлыг сайтар хянах шаардлагатай. Үнэт цаасны болон ИДТС-ийн энгийн оролцогчдын хувьд үйлчилгээний нөхцөл болон ашиглалтын явцад гарч буй хууль зүйн болон зохицуулалтын саад хориг нь тэдгээрийг нэгтгэх техникийн болон журмын шинэтгэлтээс олж буй аюулгүй, үр бүтээлтэй ололтыг сааруулж байна.

(iv) *Төв банкны оролцоо*

Төв банк нэг бол ИДТС-тэй үр ашигтай болон найдвартай харилцан үйлчилж чадах үнэт цаасны системийг хөгжүүлэх болон ажиллуулах эсвэл ийм системийг хөгжүүлж, ажиллуулж буй хувийн секторт туслах чухал хүчин юм. Хамгийн наад зах нь хувийн сектортой идэвхтэй хамтран ажиллагч, үнэт цаасны клиринг болон төлбөр тооцооны дэд бүтцийг хөгжүүлэхэд зөвлөгч байх ба үнэт цаасны системийн хууль зүйн болон зохицуулалтын дэглэмийн зайлшгүй шинэтгэлийг дэмжих ёстой болдог. Өмнө хийсэн шинэтгэлүүдийн ихэнх нь компаниудын үнэт цаас гаргах дэд бүтцийн ирээдүйн хэрэглээг дэмжиж чадах засгийн газрын үнэт цаасанд эхлээд анхаарсан.

Хэрвээ энэ нь үнэт цаасны дэд бүтцүүдийг ажиллуулж чадахгүй байвал төв банк тэдгээрт нь оролцож, үйлчилгээ үзүүлэх ёстой. Ялангуяа, энэ нь (i) өөрийн гүйлгээнд холбогдох үнэт цаасны дэд бүтцийн үйлчилгээг хэрэглэх; (ii) үнэт цаасны системийн төлбөр тооцооны банкны үүрэг гүйцэтгэх; болон (iii) нийцэж байвал үнэт цаасны төлбөр тооцооны зорилгоор санхүүгийн байгууллагуудыг зээлийн хэрэгслүүдээр хангах ёстой.

Үүрэг хариуцлагад нь хамаарахаар бол, төв банк бүхий л системийн эрсдлийн хяналтад голлон анхаарч үнэт цаасны төлбөр тооцооны хяналтын бодлогыг нарийвчлан боловсруулах ёстой.

Удирдамж 14. Бага дүнтэй, их дүнтэй болон үнэт цаасны системийн төлбөр тооцоог зохицуулах: *Үндсэн системүүдийн төлбөр гүйцэтгэх чадварын харилцан хамааралтай хэрэгцээ болон тэдгээрийн хоорондын төлбөр тооцооны эрсдлүүдийг үр дүнтэй удирдахын тулд төлбөр тооцоог гүйцэтгэх ажиллагааг зохицуулах ёстой.*

Тайлбар: Бага дүнтэй төлбөрийн систем (БДТС), ҮЦТТС болон ИДТС-ийн дэд бүтцүүд хөгжихийн хэрээр ерөнхийдөө улс орны гол санхүүгийн байгууллагууд нь эдгээр бүх системүүдийн оролцогчид болж байдаг. Тиймээс нэг системийн төлбөр тооцоо нөгөө системийн төлбөр тооцооны найдвартай болон үр ашигтай байдалд нөлөөлнө. Гол дэд бүтцүүдээр төлбөр тооцоог үр ашигтай гүйцэтгэх ажиллагаа нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын болон үйл ажиллагааны зардлыг бууруулж, цаашлаад оролцогч санхүүгийн байгууллагуудын төлбөр тооцооны эрсдлийг багасгадаг байна. Жишээлбэл, бага дүнтэй төлбөр бүр ерөнхийдөө багцлагдан, зардлын хувьд хэмнэлттэй байхын тулд ихэвчлэн тодорхой цагийн үр дүнд суурилан (deferred net basis) хийгддэг. Энэхүү багцлагдсан бага дүнтэй төлбөрөөс үүсч буй банк хоорондын төлбөрийн дүн нь нэлээд их, мөн яаралтай хугацаатай байж болох бөгөөд банк хооронд ИДТС-ээр хийгдэж болно. Үүний адилаар үнэт цаасны болон гадаад валютын гүйлгээнээс үүсэх банк хоорондын төлбөр нь ИДТС-ийг ашиглан найдвартай, үр ашигтайгаар хийгдэж болох юм.

Үүний зэрэгцээ систем хоорондын зохицол нь (i) системүүдийн доторх харилцан уялдаа; (ii) систем дамнасан үйл ажиллагааны эрсдэл; (iii) аль нэг системийн урьдчилан таамаглагдаагүй төлбөрийн урсгалтай холбоотойгоор тухайн өдрийн төлбөр түргэн

гүйцэтгэх чадварын хэрэгцээнээс үүсэх цочролын нөлөөлөх боломжийг өсгөж болох юм. Хууль зүйн, үйл ажиллагааны, санхүүгийн болон системийн эрсдэл гэх мэт систем дамнасан боломжит эрсдлийг сайтар хянаж, удирдаж байх ёстой. Энэ нь журам, сүлжээ хоорондын холболтын загвар, програмын уян хатан болон тасралтгүй байдлын төлөвлөгөө зэргийн тохиромжтой зохицуулалтаас хамаарна. Үүний зорилго нь системийн эрсдэл болон түүнийг систем хооронд тархаах боломжийг багасгах явдал юм.

Хэрэгжилт: Энэхүү удирдамжийг хэрэгжүүлэхэд төлбөр тооцооны хуваарь болон процессыг зохицуулах, систем дамнасан эрсдлийг удирдах гэсэн үндсэн хоёр асуудал үүсдэг.

(i) Төлбөр тооцооны хуваарь болон процессыг зохицуулах

Янз бүрийн төлбөр тооцооны процессуудыг зохицуулах, холбох үйл ажиллагаанд цор ганц техникийн платформ ашигладаг салангид дэд бүтцүүд шаардлагагүй. Системүүдийг програм хангамжийн интерфэйсүүдээр шууд холбож болно. ИДТС-ийг ашиглаж буй үнэт цаасны ба гадаад валютын гүйлгээтэй (жишээлбэл, CLS г.м) холбоотой төлбөрүүд болон бага дүнтэй төлбөр тооцооны (БДТТ) хувьд тухайн өдрийн туршид тодорхой цагуудад зохицуулах үйл ажиллагаа нь ерөнхийдөө төлбөр түргэн гүйцэтгэх чадварийн хэрэгслээр хангагддаг зах зээлүүдийн (liquidity market) ажиллах цаг болон өдрийн турш бэлэн байлгах мөнгөн хөрөнгөөс хамаарч байна. ИДТС-ийн оролцогчдод өдрийн туршид төлбөр тооцооны хэрэгцээг тасралтгүй санхүүжүүлэхэд хүрэлцэхүйц хугацаа шаардагддаг. Жишээ нь CLS-ийн төлбөр тооцооны цагуудыг олон төрлийн валютуудын тооцоог хийх ажиллагааных нь хуваарьт үндэслэн CLS урьдчилан тодорхойлдог. Үнэт цаасны системийн хувьд их дүнтэй төлбөр тооцооны системүүдэд хийгдэх өдрийн зээлийн барьцааг шилжүүлэх болон тухайн өдрийн мөнгөний зах зээлийн ажил гүйлгээтэй нийцүүлэн өдрийн нэлээд хожуу төлбөр тооцоог хийх шаардлага гарч болно. Иймээс БДТ-ийн банк хоорондын төлбөр тооцооны хуваарийн тухайд оролцогчдын төлбөр гүйцэтгэх чадварын позицийг тодорхойлох боломж болон санхүүжилтийг хялбар гүйцэтгэхийн тулд тухайн өдөртөө аль болох эрт хийж байх шаардлагатай. Үүнтэй холбоотойгоор дараахь саналыг дэвшүүлж байна:

- Янз бүрийн системүүдийн төлбөр тооцооны цагийн хуваарийг маш болгоомжтой гаргах, ялангуяа бүгд ИДТС-д тооцоо хийгдэж байгаа үед;
- Янз бүрийн системүүдийн ажиллагааны дүрэм, журам нь нягт уялдсан ба хэрвээ боломжтой бол төлбөрийн даалгаврын нэвт боловсруулалтыг дэмжихээр тодорхойлогдсон байх;
- Янз бүрийн системүүд болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хэрэгслээр хангадаг зах зээлүүдийн ажиллах цагуудыг систем бүрийн төлбөр тооцооны процесс бүрд нийцэж байхаар зохицуулах.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хэрэгслээр хангадаг зах зээлүүдийн журам, ажлын гэрээний шинэтгэл нь зах зээлийн нийцэл, ил тод байдал, хэрэглэх боломжийг хөгжүүлэх эрх зүйн механизмд түшиглэх шаардлагатай байж болох юм.

Зураг 4-т Үндсэн дэд бүтцүүдийн хоорондын холбоог Францын жишээгээр харууллаа.

(ii) Систем дамнасан эрсдлийг удирдах нь

Систем дамнасан эрсдлийн эх сурвалжийг тодорхойлох, тэдгээрийг удирдах аргачлал болон тохирох хяналтыг боловсруулах явдал нэн чухал. Хамгийн наад зах нь систем дамнасан эрсдлийг удирдах стратеги нь дараахь зүйлийг багтаасан байх ёстой. Үүнд:

- Харилцаа холбооны стандарт болон форматын тохиролцоо, ялангуяа, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын стандартыг ашиглавал илүү тохиромжтой;
- Харилцан уялдаатай системүүдийг холбох хэмнэлттэй, хурдан, найдвартай харилцаа холбоо;
- Системийн нэг оролцогчийн саатлаас үүдэн дагалдан гарах гарз хохиролтой холбоотойгоор хууль зүйн болон санхүүгийн эрсдлийг хуваарилах харилцан холбоотой системүүдийн хоорондын тохиролцоо;
- Систем бүрийн (ихэнхдээ нөөцийн бэлтгэл ажилд хамаарах) үндсэн төхөөрөмжийн тасалдал болон бүхэл системийн (тухайлбал, бага дүнтэй төлбөрийн системийн онцгой байдал) тасалдлыг уялдаатайгаар шийдэх аргачлал;
- Үнэт цаасны систем, ИДТС, магадгүй цаашлаад БДТС-тэй харилцаж буй холбоог тасалдуулах боломжтой гол оролцогчдын компьютерын дотоод системийн эвдрэл гэмтлийг шийдэх журмууд.

Үүнээс гадна бүх хамаарал бүхий оролцогчдын тасралтгүй байдлын төлөвлөгөөг нийцүүлэн зохион байгуулах хэрэгтэй. Жишээлбэл, үүнд тасралтгүй байдал болон болзошгүй нөхцлийн төлөвлөгөөг шалгах, сорих явдал хамаарч болно. Ийм сорилын нэг жишээ бол оролцогч байгууллагуудын хуучин ажиллагааг эргүүлэн сэргээх болон дахин үргэлжлүүлэх бэлтгэл ажлыг хангахад үнэлгээ өгөх үүднээс нөөц төхөөрөмжид нь шилжүүлэх явдал юм.

(iii) Төв банкны оролцоо

Энэхүү удирдамжийг хэрэгжүүлэх хариуцлага нь ерөнхийдөө дэд бүтцийн эзэмшигчид, оператор, оролцогчдод хамаарах ба төв банк зөвхөн эдгээрийн нэг нь юм. Гэхдээ төв банкны шаардлага нь төв банкны үйлчилгээг ашиглаж буй төлбөр тооцооны системийн шаардлагатай нийцсэн байна. Төв банк өөрийн журмуудыг бусад гол дэд бүтцүүдийн журмуудтай зохицуулах болон нэгтгэх идэвх санаачлагуудад зөвлөх мэргэжлийн ур чадвараар хангах тал дээр дэмжлэг үзүүлж болно. Энэ нь ажиллах журам болон ажиллах цаг, түүнчлэн үндсэн дэд бүтцүүдэд төлбөр тооцооны шинэ зохион байгуулалтыг дэмжих журам, шинэ үйлчилгээний технологийг хүлээн авахад бэлэн байх зэрэгт илүү уян хатан байна гэсэн утгатай юм.

Мөн төв банк нь төлбөр тооцооны зохион байгуулалтад хамаатай олон төрлийн дэд бүтцийн операторуудын хоорондын хэлэлцүүлэг явуулахад дэмжлэг үзүүлж байх ёстой. Үүний гол анхаарах зүйл бол үндсэн дэд бүтцүүд дээр гарч буй үйл ажиллагааны болон

нэгтгэлийн эрсдлийг удирдахын тулд уялдаа шүтэлцээтэйгээр, бүх системийн стратегийг хөгжүүлэх явдал юм.


Зураг 4

Францын дэд бүтцүүдийн нэгтгэл

Дэд бүтцүүд

Одоогийн байдлаар Францын төлбөрийн систем бүтцийн хувьд банк хоорондын төлбөр тооцооны 4 системийг багтаадаг ба эдгээр нь бүгд системийн хувьд нэн чухал төлбөрийн систем төдийгүй солилцож буй төлбөрийн даалгаврын мөнгөн дүн болон төрөлтэй холбоотойгоор тус бүрдээ өөр зориулалт бүхий системүүд юм.

- Их дүнтэй төлбөрийн гүйлгээнүүд Европын TARGET системийн Францын бүрэлдэхүүн болох бодит цагийн нэгбүрчилсэн төлбөр тооцооны (real-time gross settlement) TBF (Transfert Banque de France) системээр эсвэл бодит цагийн үр дүнгийн төлбөр тооцооны (real-time net settlement) PNS (Paris Net Settlement) системээр хийгддэг. Энэ хоёр систем нь Банк хоорондын хөрөнгийн шилжүүлгийн төв CRI (Centrale des Règlements Interbancaires)-ийн ажиллуулдаг нэг платформыг ашигладаг байна.
- Бүх бага дүнтэй төлбөрийн (чек, 800,000 еврогоос бага дүнтэй кредит шилжүүлэг, шууд дебит) хувьд ганц л бага дүнтэй төлбөрийн систем байдаг.
- Үнэт цаасны төлбөр тооцоо хийх хоёр суваг байна. Үүний нэг нь бага дүнтэй гүйлгээний, гүйлгээг буцаан дуудах боломжтой (RELIT), нөгөө нь мөнгөний бодлогын үйл ажиллагааны болон их дүнтэй гүйлгээний ихэвчлэн тогтмол орлоготой үнэт цаасанд хэрэглэдэг эргэлт буцалтгүй (RGV) суваг юм.



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын болон барьцааны нэгдсэн удирдлага

Ажлын өдөр, цагийг клирингийн сүүлийн хугацаа ба туслах системүүдийн төлбөр тооцооны цонхуудтай цагийн хуваарийн тусламжтайгаар зохицуулдаг.

Үүний зэрэгцээ бодит цагийн гүүр нь өдрийн аль ч цагт, ямар нэгэн хязгаарлалтгүй эдгээр системүүдийн хооронд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хангах эргэлт буцалтгүй шилжүүлгийг хүлээн авч, төв банкны мөнгийг хэрэглэхтэй холбоотойгоор үндсэн төлбөрийн болон үнэт цаасны

системүүдийн (RGV, TBF болон PNS) хооронд оршиж байдаг.

Болзошгүй нөхцөл байдлын зохицуулах журам

Төлбөрийн болон үнэт цаасны системийн төлөөллийг багтааж буй Санхүүгийн хямралыг удирдах хороо дараахь зүйлсийг баталгаажуулдаг. Үүнд:

- Бүх системүүд шаардлага хангахуйц, бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн болзошгүй байдлын журмуудтай байх;
- Систем даяараа нэгэн зэрэг нөөц байрлалд шилжих туршилтыг байнга хийх.

Төлбөрийн системийн дэд бүтцийг хөгжүүлэхтэй холбоотойгоор санал болгож буй лавлах материалууд

Adams, R M, P W Bauer and R C Sickles (2004): “Scale economies, scope economies and technical change in Federal Reserve payment processing”, *Journal of Money, Credit and Banking*, vol 36, no 5,

October.

54 CPSS - General guidance report - January 2006

Arango, C, and J Bernal (2003): “Systemically important payment systems in Latin America and the

Caribbean: results of self-assessment exercises”, *CEMLA/World Bank Payments and Securities Clearance and Settlement Systems Research Series*, June.

Committee on Payment and Settlement Systems (1992): *Delivery versus payment in securities settlement systems*, Bank for International Settlements, September.

——— (1996): *Settlement risk in foreign exchange transactions*, Bank for International Settlements,

March.

——— (1997): *Real-time gross settlement systems*, Bank for International Settlements, March.

——— (2000): *Clearing and settlement arrangements for retail payments in selected countries*, Bank

for International Settlements, September.

——— (2001): *Core principles for systemically important payment systems*, Bank for International Settlements, January.

——— (2003): *Policy issues for central banks in retail payments*, Bank for International Settlements,

March.

——— (2005): *New developments in large-value payment systems*, Bank for International Settlements, April.

CPSS-IOSCO (2001): *Recommendations for securities settlement systems*, Bank for International Settlements, November.

——— (2004): *Recommendations for central counterparties*, Bank for International Settlements, November.

Deutsche Bundesbank (2005): Recent trends in individual payments, *Deutsche Bundesbank Monthly Report*,

September.

European Central Bank (1998): *Assessment of EU securities settlement systems against the standards for their use in ESCB credit operations*, September.

——— (1999): *Improving cross-border retail payment services in the euro area - the Eurosystem's view*, September.

——— (2001): *Towards an integrated infrastructure for credit transfers in euro*, November.

——— (2003a): *Oversight standards for euro retail payment systems*, June.

——— (2003b): *Towards a single euro payments area - progress report*, June.

——— (2004a): *The use of central bank money for settling securities transactions*, May.

——— (2004b): *Standards for securities clearing and settlement in the European Union*, November.

Guadamillas, M and R Keppler (2001): “Securities clearing and settlement systems: a guide to best practices”, *Policy Research Working Paper 2581*, The World Bank, Washington DC, April.

Heller, S (2002-03): “The new CHIPS: intraday finality - revolutionary or evolutionary?” in *Banking and Finance Law Review*, vol 18.

Kemppainen, K (2003): “Competition and regulation in European retail payment systems”, *Bank of Finland Discussion Paper 16/2003*, June.

Group of Thirty (2003): *Global clearing and settlement: a plan of action*, Washington, DC.

Leinonen, H (2000): “Re-engineering payment systems for the e-world”, *Bank of Finland Discussion Paper 17/2000*, November.

Northcott, C-A (2002): “Estimating settlement risk and the potential for contagion in Canada's automated clearing settlement system”, *Bank of Canada Working Paper 2002-41*, December.

O'Connor, S (2003): “Developments, issues and initiatives in retail payments”, *Bank of Canada Review*, Autumn.

Хавсралтууд

Хавсралт 1: Удирдамжийн жагсаалт

Хавсралт 2: Тодорхой жишээ (Шри-Ланка)

Хавсралт 3: Хэтийн төлвийг дахин үнэлэх бүрэлдэхүүн хэсгүүд

Хавсралт 4: Хууль зүйн тогтолцоо ба төлбөрийн системийн үлгэрчилсэн хуулиуд

Хавсралт 5: Нэр томъёоны тайлбар

Хавсралтб: Ажлын хэсгийн гишүүд

Хавсралт 1: Удирдамжийн жагсаалт

А. Банкны систем

Удирдамж 1. Төв банк гол үүрэгтэй байх: үндэсний валютын тогтвортой байдлыг хангах ерөнхий үүргийнхээ дагуу төв банк нь үр ашигтай төлбөрийн хэрэгсэл болох мөнгөний хэрэглээг хөгжүүлэхэд гол үүргийг гүйцэтгэнэ.

Удирдамж 2. Банкны системийн тогтвортой байдлыг хангах: банкууд болон бусад ижил төстэй санхүүгийн байгууллагуудаас эцсийн хэрэглэгчид үзүүлж буй төлбөрийн данс, хэрэгсэл, үйлчилгээ нь хоорондоо өрсөлдөх хэдий ч системийнхээ хувьд үргэлж хамтран ажиллах шаардлагатай.

Б. Төлөвлөлт

Удирдамж 3. Үндэсний төлбөрийн системийг цогцоор нь авч үзэх: төлөвлөлт нь үндэсний төлбөрийн системийн гол бүрэлдэхүүн хэсгүүд болон түүний хөгжилд нөлөөлөх үндсэн хүчин зүйлүүдийн бүх талын ойлголтод суурилсан байх ёстой.

Удирдамж 4. Эрэлт хэрэгцээг голчлон анхаарах: үндэсний төлбөрийн системийн бүх хэрэглэгчийн төлбөрийн хэрэгцээг, мөн эдийн засгийн боломжийг тодорхойлж, тэдгээрт нийцсэн үйл ажиллагаа явуулна.

Удирдамж 5. Эн тэргүүний зорилтуудыг тодорхойлох: үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх эн тэргүүний зорилтуудыг тодорхойлж, стратегийн арга барилаар төлөвлөнө.

Удирдамж 6. Гол нь хэрэгжүүлэх: стратеги төлөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэх баталгаатай байх ёстой.

В. Эрх зүйн орчин

Удирдамж 7. Зах зээлийн хөгжлийг дэмжих: төлбөрийн үйлчилгээний зах зээлийн зохицуулалтыг бэхжүүлэн, өргөжүүлэх нь үндэсний төлбөрийн системийн хөгжлийн гол хэсэг болдог.

Удирдамж 8. Холбогдох бүх талуудыг хамруулах: үндэсний төлбөрийн системийн холбогдох бүх талууд бүтээлчээр зөвлөлдөн хэлэлцэхийг дэмжих.

Удирдамж 9. Хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хамтран ажиллах: төв банкны зүгээс төлбөрийн системийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай болдог.

Удирдамж 10. Хууль эрх зүйн тодорхой байдлыг хангах: үндэсний төлбөрийн системийн талаар тодорхой, иж бүрэн, ил тод хуулийн тогтолцоог бий болгоно.

Г. Дэд бүтэц

Удирдамж 11. Бага дүнтэй төлбөрийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх: бага дүнтэй төлбөрийн дэд бүтцийг сайжруулж, өргөжүүлэх замаар хэрэглэгч, аж ахуй нэгж,

засгийн газрын байгууллагад үзүүлэх үйлчилгээ, үр ашигтай, найдвартай бэлэн бус төлбөрийн хэрэгслийн сонголт, хүртээмжийг нэмэгдүүлэх ёстой.

Удирдамж 12. Их дүнтэй төлбөрийн системийг хөгжүүлэх: *банк хоорондын, хугацааны хувьд яаралтай төлбөрүүдийн өсөлт болон санхүүгийн зах зээлийн хэрэгцээнд үндэслэн их дүнтэй төлбөрийн системийг хөгжүүлэх шаардлагатай.*

Удирдамж 13. Төлбөрийн болон үнэт цаасны системийг хамтад нь хөгжүүлэх: *санхүүгийн системийн үр ашигтай, аюулгүй байдлыг хангахын тулд үнэт цаасны болон их дүнтэй төлбөрийн системүүдийг нийцүүлэн хөгжүүлэх ёстой.*

Удирдамж 14. Бага дүнтэй, их дүнтэй болон үнэт цаасны системийн төлбөр тооцоог зохицуулах: *Үндсэн системүүдийн төлбөр гүйцэтгэх чадварын харилцан хамааралтай хэрэгцээ болон тэдгээрийн хоорондын төлбөр тооцооны эрсдлүүдийг үр дүнтэй удирдахын тулд төлбөр тооцоог гүйцэтгэх ажиллагааг зохицуулах ёстой.*

Хавсралт 2: Тодорхой жишээ – Шри Ланка

Төв банкны шинэчлэл ба түүний Шри Ланкийн төлбөрийн системийн хөгжилд үзүүлэх нөлөө

1. Танилцуулга

Байнга өсөн нэмэгдэж байгаа санхүүгийн системийн нарийн төвөгтэй байдал, эдийн засгийн бодлогын шинэ үзэл бодол, өөрчлөгдөн буй дэлхий дахины төв банкуудын үүрэг роль нь төв банкуудад эдийн засагтаа үр бүтээлтэй ажиллах хүчин чадлаа бэхжүүлэх, өөрчлөх шаардлагыг өсгөн нэмэгдүүлсэн. Энэхүү шаардлагын бодит жишээ болж, Шри Ланкийн төв банк (ШЛТБ) 2000 оны эцсээр одоогийн төв банкныг зохион байгуулах, сорилт бэрхшээлийг давах чадварыг өсгөх зорилгоор шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

2001 онд эхэлсэн шинэтгэлийн үйл явцын үр дүнд үндсэн зорилго болон үйл ажиллагаанд анхаарч, энэхүү систем, системийн удирдлага, журмыг боловсронгуй болгон, ажилтнуудын мэргэшлийн ур чадварыг өсгөснөөр, мөн цаашилбал үйл ажиллагааны өртгийг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, найдвартай байдлыг хангах, зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, системийн эрсдлүүдийг бууруулах гэх мэт янз бүрийн зорилгуудыг хооронд нь тэнцвэржүүлснээр хөгжиж буй эдийн засгийн хэрэгцээг хангаж чадах санхүүгийн системийн үндсэн дэд бүтцийг бий болгох замаар орчин үеийн, үр ашигтай төв банкныг байгуулах хүлээлт бий болсон байсан. Үр ашигтай төв банк нь өрсөлдөх чадвартай, зохистой удирдлагатай санхүүгийн секторыг бий болгоход шийдвэрлэх үүрэгтэй байдаг учраас Шри Ланкийн төв банкны (ШЛТБ) шинэтгэл нь улс орны санхүүгийн секторын өөрчлөлтийн чухал хэсэг болсон юм. Өөрчлөгдөн буй санхүүгийн систем нь Шри Ланкийн төв банкны шинэтгэлийн төлөвлөгөөний чухал бүрэлдэхүүн болсон.

2. Үндсэн зорилгуудад оруулсан өөрчлөлт

Шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд ШЛТБ зорилгуудаа дахин тодорхойлж, дараахь хоёр шинэ зорилгыг нэмж оруулсан байна. Үүнд: (а) эдийн засгийн болон үнийн тогтвортой байдал; (б) 2002 оны 12 дугаар сард хүчин төгөлдөр болсон Валютын хууль (ВХ)-д оруулсан нэмэлтийн дагуу Шри Ланкийн нөөцийн үр ашигтай хөгжлийг дэмжих зорилготой санхүүгийн системийн тогтвортой байдал.

Шинэ үндсэн зорилго тодорхойлохын зэрэгцээ ШЛТБ нь төлбөрийн системийн шинэтгэл болон дэд бүтцийн хөгжил, бага дүнтэй чекийн клирингийн үйл ажиллагаа зэрэг үндсэн бус үүргийг оруулан хэд хэд зохион байгуулалтын болон удирдлагын шинэтгэлийг хариуцах болсон.

3. Их дүнтэй, системийн хувьд нэн чухал төлбөрийн систем болон хууль тогтоомжийн өөрчлөлт

Системийн хувьд нэн чухал, их дүнтэй төлбөрийн системд хамаарах төлбөр тооцооны эрсдлийг бууруулах, шинээр үүсч буй шилдэг туршлагатай нийцүүлэн үнэт цаасны төлбөр тооцоонд дэмжлэг үзүүлэх, засгийн газрын өрийн үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор ШЛТБ нь 2001 онд нэгдсэн Бодит Цагийн Нэгбүрчилсэн Төлбөр Тооцоо (БЦНТТ)/Цахим Үнэт Цаасны Төлбөр Тооцооны (ЦҮЦТТ) системийг шинээр нэвтрүүлэх үйл явцыг эхлүүлсэн.

БЦНТТ/ЦҮЦТТ системийг шинээр нэвтрүүлэхэд хэд хэдэн хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай болсон. Жишээлбэл ВХ (ШЛТБ-ны гол хууль), Орон нутгийн Өрийн Бичгийн Тухай Тогтоол (ОНӨБТТ), Бүртгэгдсэн Хувьцаа болон Үнэт Цаасны Тухай Тогтоол (БХҮЦТТ) гэх мэт.

2002 оны 12 дугаар сарын эхэн хүртэл ШЛТБ арилжааны банкууд болон анхдагч дилерүүдийн хоорондын хөрөнгийн шилжүүлгийг төв банкин дахь тэдгээрийн харилцах дансаар дамжуулан гүйцэтгэхэд зориулж төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлж байв. Их дүнтэй гүйлгээ болон төлбөр тооцоог бодит цагт гүйцэтгэх БЦНТТ/ЦҮЦТТ Системийг нэвтрүүлэх зайлшгүй шаардлагыг харгалзан үзэхийн зэрэгцээ доор дурдсан зорилтод хүрэхийн тулд ВХ-д нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан байна. Үүнд:

- Системийг бий болгох болон талуудын эрх үүргийг тодорхойлох;
- БЦНТТ/ЦҮЦТТ системийн тасралтгүй ажиллагааг хангахын тулд ШЛТБ өдрийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын нөхцлийг хангах барьцаатай байх боломж бүрдүүлэх;
- Гүйлгээ эргэлт буцалтгүй, эцсийн байх боломжийг хангах;
- Цахим бичилт болон гүйлгээний хүчин төгөлдөр байдал болон хэрэгжилтийг хүлээн зөвшөөрөх;
- Төлбөр болон тооцоотой холбоотой үйл ажиллагаанд аутсорсинг хийх;
- Төлбөрийн чадваргүй болох үед эдгээр системүүдийн гүйлгээг хамгаалах.

БЦНТТ систем 2003 оны 9 дүгээр сарын 8-ны өдрөөр хүчин төгөлдөр болж, их дүнтэй, яаралтай төлбөрүүдийн эрсдлийг бууруулж, шилжүүлгийг хялбаршуулсан. 2002 онд байгуулагдсан Төлбөр Тооцооны Газар (ТТГ) нь БЦНТТ/ЦҮЦТТ системийг хариуцах үүргийг хүлээсэн байна.

Засгийн газрын үнэт цаасны зах зээл нь богино хугацаат өрийн бичиг (БХӨБ) буюу бондыг худалдаалагдах тухай бүрт эзэмшил өөрчлөх зөвшөөрөл болон шилжүүлэг хийх зориулалттай цаасан хэлбэрээр өрийн бичиг болон бондыг гаргах үйл ажиллагаа эрхэлдэг. Цаасан сертификатыг эзэмшигч зөвшөөрөн, дараа нь хэд хэдэн газруудад биет байдлаар шилжсэн талаар анхдагч дилер буюу банк баталгаажуулсан байх ёстой. Хугацааны эцэст

өрийн бичиг буюу бонд тус бүрийн бодит баталгаажуулалтыг гараар хийсний дараа үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэдэг. Энэ нь засгийн газрын үнэт цаасны анхдагч, цаашлаад хоёрдогч зах зээлийн хөгжлийг боогдуулж байгаа удирдлагын нүсэр дэг журамтай холбоотой юм. Түүнээс гадна, үнэт цаас нь тусгай цаасан дээр хэвлэгдэж, кастодианд аюулгүй хадгалагдах ёстой. Анхдагч дилер төлбөрийн кастодианы үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ үнэт цаас гээгдэх, буруу байрлуулах буюу буруу хэрэглэх тал дээр ямар нэгэн баталгаа байхгүй. Энэхүү процесс үр ашиггүй, анхдагч дилерийн болон хөрөнгө оруулагчийн гүйлгээний зардлаар өсч байдаг ба цаашилбал засгийн газрын үнэт цаасны хөрөнгө оруулалтаас гадны хөрөнгө оруулагчид эзэмших болдог байна.

Цахим Үнэт Цаасны Төлбөр Тооцооны системийг нэвтрүүлэх ажлыг дэмжихийн тулд ШЛТБ нь ОНӨБТТ болон БХҮЦТТ-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэхүү хоёр тогтоомжид оруулсан нэмэлт өөрчлөлт 2003 оны сүүлээр парламентаар орж, ШЛТБ нь үнэт цаасыг цахим бүртгэлд оруулах замаар үнэт цаас гаргах, бичилт хийх, шилжүүлэг хийх, төлбөр тооцоо хийх, анхдагч дилер болон тэдгээрийн харилцагчдын үнэт цаасны дансыг байршуулах бололцоотой болсон. Цахим үнэт цаасны гүйлгээ хийгдэхэд үнэт цаас нь ЦҮЦТТ-ы системийн бүрэлдэхүүн - төв банкинд байршиж буй төвлөрсөн хадгаламжийн төвийн нэг үнэт цаас эзэмшигчийн данснаас нөгөө үнэт цаас эзэмшигчийн дансанд шилжинэ. Үнэт цаас арилжаалагдамагц төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн үндсэн дээр БЦНТТ-ы системээр мөнгөн төлбөр нэгэн зэрэг хийгдэнэ. БЦНТТ/ЦҮЦТТ нэгдсэн систем 2004 оны 2 дугаар сарын 3-ны өдрөөс үйл ажиллагаагаа эхэлсэн. ЦҮЦТТ-ны системийн хувьд бүх л анхдагч дилерүүд өөрсдийн болон харилцагчдынхаа дансыг төвлөрсөн хадгаламжийн системд нээдэг. Тиймээс ШЛТБ нь засгийн газрын бүх үнэт цаасны хууль ёсны өмчлөгчийг бүртгэх бүртгэгч болон төвлөрсөн хадгаламжийн төв болдог. Мөн систем нь цаасан хэлбэрээр байгаа үнэт цаасыг цахим хэлбэрт хөрвүүлэх эрхтэй болсон юм. Энэхүү систем мөнгөн төлбөр хийгдмэгц үнэт цаас хөрөнгө оруулагчид шилжих төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг хангаж ажилладаг. Бүхэлдээ, энэ систем цаасан хэлбэртэй засгийн газрын өрийн бичиг буюу бондын төлбөр тооцоотой холбоотой эрсдлийг бууруулж, мөнгөн шилжүүлэг болон арилжааг илүү хурдан, илүү найдвартай, илүү үр ашигтайгаар хийдэг. ЦҮЦТТ систем үнэт цаасыг анх гаргахаас эхлэн эцсийн төлбөр хийгдэх хүртэлх бүхий л хугацаанд баталгаажуулж байх бөгөөд хугацааны эцэст хийгдэх төлбөр болон хүүг тооцоолох, түүнд нөлөөлөх эрхтэй байдаг байна.

4. Үндсэн биш үүргүүдийг хариуцах нь

Үндсэн биш үүргүүдийн хувьд ШЛТБ бага дүнтэй төлбөрийн системийн ихэнх хэсгийг эзэлж буй чекийн (системийн хувьд нэн чухал хоёр дахь төлбөрийн систем) үйл ажиллагаанд аутсорсинг хийсэн. Иймээс 1988 оноос ШЛТБ-ны Мэдээллийн технологийн газрын харьяа хэлтсийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байсан Автоматжуулсан Клирингийн Төв нь 2002 оны 4 дүгээр сард арилжааны банкууд болон төв банкны хамтын эзэмшлийн LankaClear (Pvt) Limited гэсэн бие даасан байгууллага болсон. Энэ тусгаарлах үйл ажиллагааны зорилго нь шинэ удирдлага, технологийн болон зардал хэмнэх шийдвэрийн дагуу Клирингийн төвөөр хийгдэж байгаа клирингийн болон цахим

хөрөнгийн шилжүүлгийн системийн үр ашгийг сайжруулах явдал байсан. Аутсорсинг хийснээр LankaClear маш сайн ажиллаж, өөрийн үйлчилгээний өртөг болон клирингийн цагийг багасгаж, ингэснээр үр ашгийг нэмэгдүүлж чадсан байна.

ШЛТБ өнөөг хүртэл t+3, t+7 дээр хийгдэж байгаа бүс нутгийн чектэй холбоотойгоор бага дүнтэй чекийн (retail and low-value) клирингийн үйл ажиллагаанд хамаатай зарим эрсдэл болон үр ашиггүй байдалд санаа зовнисоор л байна. Төв банк, LankaClear хамтран эрсдлийг үгүй болгож, үр ашгийг сайжруулах, чек дүрслэлийн системийг нэвтрүүлэх үйл явцыг эхлүүлээд байна. Энэ санаачлагаар цахим чекийг төлбөрт өгөх болон цахим баталгааг хүлээн зөвшөөрөхийн тулд Векселийн тухай Тогтоол болон Нотолгооны тухай Тогтоолд өөрчлөлт оруулах шаардлагатай болсон. ШЛТБ төлбөрийн гүйлгээ болон үнэт цаасны төлбөр тооцоог зохицуулах төлбөрийн болон төлбөр тооцооны бие даасан хууль, журмыг батлуулах бэлтгэл ажлыг хийсэн бөгөөд 2005 онд парламентаар оруулахаар хүлээгдэж байна.

5. Хяналт шалгалтын үүргийг анхааран үзэх нь

2002 оны Валютын Хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр ШЛТБ Шри Ланкийн төлбөрийн систем, санхүү, мөнгөний бодлогыг удирдах, хянан шалгалт хийх, зохицуулахаас гадна төлбөрийн системд хяналт тавих үүргийг хүлээсэн. Найдвартай, үр ашигтай төлбөр тооцооны системийг нэвтрүүлж, төлбөрийн системтэй холбоотой зарим үйл ажиллагааны хариуцлагад аутсорсинг хийхийн зэрэгцээ ШЛТБ төлбөрийн системийнхээ хяналтын асуудал дээр анхаарч байна. Одоогоор төлбөрийн системийг хянаж байгаагийнхаа хувьд төв банк бүхий л төлбөр тооцооны системийн найдвартай, аюулгүй, үр ашигтай ажиллагааг батлан, харилцагчдын итгэлийг алдахгүй байж, мөнгөний бодлогын холбогдолтой мөнгөн шилжүүлгийн арга хэрэгслүүд болон дамжуулах сувгуудыг хамгаалахыг хичээж байна. Санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах зорилгын гол хэсгийг төлбөрүүд бүрдүүлж байсан бөгөөд энэхүү зорилгодоо хүрэхдээ ШЛТБ нь төлбөрийн системийн хяналтын дүрэм, журам, хууль, заавар, удирдамж болон албан бусаар бол ёс суртахуунд тулгуурлаж байна.

Хяналтын үйл ажиллагааны дүрэм, журам нь Төлбөр тооцооны системийн хорооноос гаргасан Үндсэн 10 зарчимд болон үнэт цаасны төлбөр тооцооны хувьд Төлбөр тооцооны системийн хороо – Үнэт цаасны комиссын олон улсын байгууллага (CPSS-IOSCO)-аас гаргасан хяналтын стандартад суурилсан байна. Иймээс хяналтын арга нь системийн оператор болон оролцогчидтой байнгын хэлэлцүүлэг хийх, статистикийн тоон мэдээлэл цуглуулах замаар төлбөрийн хэрэгсэл болон төрөл бүрийн төлбөрийн системүүдийн зайны хяналтыг (ажиглалт) багтааж байна.

Төлбөрийн системийн газар нь LankaClear-ээр хийгдэж байгаа рупигийн чекийн дотоод клиринг болон америк долларын чекийн клирингийн ажиллагааг хянадаг. ШЛТБ-ны эзэмшин, үйл ажиллагаа явуулж байгаа БЦНТТ/ЦҮЦТТ систем дүрэм журамтайгаа нийцэн ажиллаж байгаа эсэхэд баталгаа өгөхийн тулд банкны Хяналт шалгалтын газар газар дээр нь хяналт тавих үүргийг гүйцэтгэдэг. Мөн ШЛТБ нь зах зээлийн удирдлагын

дүрэм, журам, Олон улсын төлбөр тооцооны банктай хамтран өөрийн улсын одоогийн төлбөр тооцооны системийн зохион байгуулалтын талаар хийсэн “Улаан ном”-ыг нийтлүүлээд байна.

Хавсралт 3: Хэтийн төлвийг үнэлэх бүрэлдэхүүн хэсгүүд

Энэхүү хавсралт нь хэтийн төлвийг үнэлэхтэй холбоотой бүрэлдэхүүн хэсгүүдийн ерөнхий төсөөлөл ойлгоцыг өгөх болно. Бүгд бүрэлдэхүүн хэсэг бүх тохиолдолд хамаарахгүй байж болно.

1. Төлбөрийн хэрэгсэл болон мэдээллийн гол хэрэгсэл (медиа)

- Мөнгөн хөрөнгө
- Чекийн төлбөр болон бусад цаасан хэрэгсэл (жишээ нь, мөнгөний ордер, банкны драфт буюу банкнаас өөрийн нэр дээр гаргасан шилжих вексель)
- Автомат дебит, кредит шилжүүлгүүд
- Төлбөрийн картууд (кредит карт, дебит карт)
- Бусад

2. Төлбөрийн системийн дэд бүтэц

Дэд бүтцүүд

- Гүйлгээний системүүд
 - Банкны хөрөнгөнд суурилсан системүүд (салбарууд, АТМ-үүд буюу бэлэн мөнгөний машинууд, е-банк буюу электрон банкны үйлчилгээ)
 - Хамтын эзэмшлийн сүлжээний системүүд (EFTPOS буюу ПОС дээр хийгдэх хөрөнгийн цахим шилжүүлэг, АТМ-үүд буюу бэлэн мөнгөний машинууд, е-төлбөр буюу цахим төлбөрүүд)
- Клирингийн болон төлбөр тооцооны систем (төв банк болон хувийн хэвшлийн операторууд)
 - Бага дүнтэй төлбөрийн клиринг болон төлбөр тооцоо
 - Их дүнтэй төлбөр тооцооны системүүд

Үндсэн шинж чанарууд

- Системийн оролцогчид
- Гүйлгээний төрөл
- Шилжүүлгийн системийн ажиллагаа, түүний дүрэм
- Нөөцийн шийдэл
- Төлбөр тооцооны журмууд
- Зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл
- Үнийн бодлого

Санхүүгийн бус үндсэн дэд бүтцүүд

- Харилцаа холбоо
- Тээвэр (авто зам, төмөр зам, агаарын болон усан зам)
- Түлш, эрчим хүч (цахилгаан, эрчим хүч, газрын тос, хий, нүүрс)

3. Эрх зүйн байдал

- Төлбөрийн үйлчилгээ үзүүлж байгаа санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагуудын ялгаатай үүрэг
 - Төв банк (жишээ нь, төлбөр тооцооны төхөөрөмж ба үйлчилгээ, хэрэглэгчийн шаардлага, хяналт)
 - Арилжааны банкууд
 - Орон сууцны корпораци
 - Шуудан
 - Кредит карт гаргагч компаниуд
 - Бусад санхүүгийн бус төлбөр буюу төлбөртэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчид (жишээ нь, СВИФТ, нэгтгэгчид – гуравдагч этгээд, гуравдагч этгээдийн төлбөрийн процессор, мэдээллийн технологийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчид)
- Сүлжээний болон үйлчилгээний зах зээлийн харилцан холбоо
 - Энгийн оролцоо
 - Үйлчилгээ эсвэл гэрээгээр хүлээсэн холбоо – шууд буюу зуучлагчаар дамжуулан
 - Үнийн бодлого
- Улсын болон бусад хувийн секторын байгууллагын үүрэг
 - Банкуудын зөвлөл
 - Клирингийн төвийн операторууд
 - Төлбөрийн ассоциаци
 - СВИФТ хэрэглэгчдийн ассоциаци
 - Сангийн операторуудын чуулган
 - Карт гаргагч банкуудын ассоциаци
- Хууль эрх зүйн орчин
 - Төлбөрийн үндсэн хууль тогтоомж ба журмууд

4. Санхүүгийн гүйлгээн дэх төлбөрийн системийн хэрэглээ

Санхүүгийн гүйлгээний (банк хоорондын зээл, валютын болон мөнгөний зах зээл, үнэт цаас) талаарх ойлголт

- Үнэт цаасны гүйлгээнд зориулагдсан арилжааны систем
 - Үнэт цаасны (хувьцаа ба бонд) бирж
 - Фьючерс ба деривативын бирж
 - Биржийн гадуурх (over-the-counter) болон автомат арилжааны систем
- Үнэт цаасны гүйлгээний төлбөр тооцооны систем ба клиринг

- Үнэт цаас хадгаламжийн байгууллагууд (депозиторууд) болон клирингийн байгууллагууд
- Бүртгэл болон кастодийн зохицуулалт
- Үнэт цаасны төлбөр тооцооны систем
- Үндсэн шинж чанарууд
 - Системийн оролцогчид
 - Гүйлгээний төрлүүд
 - Системийн ажиллагаа, түүний дүрэм
 - Нөөцийн шийдэл
 - Төлбөр тооцооны журмууд
 - Зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл
 - Үнийн бодлого

Санхүүгийн гүйлгээний болон кросс-валютын ба хил дамнасан төлбөрийн дэд бүтцүүд

- Бага дүнтэй болон их дүнтэй гадаад гүйлгээний төлбөр тооцоо, клиринг, гүйлгээ
- Үндсэн шинж чанар:
 - Системийн оролцогчид
 - Гүйлгээний төрлүүд
 - Системийн ажиллагаа, түүний дүрэм
 - Нөөцийн шийдэл
 - Төлбөр тооцооны журмууд
 - Зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл
 - Үнийн бодлого

5. Төлбөрийн системд нөлөөлж буй өнөөгийн хөгжлүүд

- Төлбөрийн системийн удирдлагын болон зөвлөлийн зохион байгуулалт
- Гүйлгээ, клиринг, төлбөр тооцооны дэд бүтцийн, мөн бага ба их дүнтэй төлбөрүүд, үнэт цаасны системийн үйлчилгээний зах зээлийн талаарх үндэсний ба бүсийн хөгжлийн санаачлага
- Төлбөрийн болон үнэт цаасны системд нөлөөлөх хууль зүй, зохицуулалтын шинэчлэлүүд

6. Төлбөрийн системийн статистик тоон мэдээлэл

- Хэрвээ бэлэн байвал, үр дүнтэй шинэтгэлийг дэмжих, шууд тус нэмэр болж чадах үндэсний төлбөр тооцооны системийн үндсэн бүрэлдэхүүн хэсгийг хөгжүүлэх, чиглүүлэх мэдээллээр хангахуйц тоон мэдээллийг ашиглах хэрэгтэй.

Хавсралт 4: Хууль зүйн тогтолцоо ба төлбөрийн хуулиудын загвар

1. Төлбөрийн хэрэгслийн тухай хууль эрх зүйн орчин

Мөнгөн тэмдэгтийн хууль:

- Төв банкнаас баталсан эсвэл гаргасан албан ёсны валютыг (мөнгөний нэгжийг) тогтоох;
- Гүйлгээний дүн, эрх бүхий гүйлгээ (өөрөөр хэлбэл, төлбөрийн хэрэгслийн тухай хууль) – нээс хамаарч нэрлэсэн дүнгээр нь төлбөрт хүлээн зөвшөөрсөн валютыг зохицуулах;
- Албан ёсны валютыг хуурамчаар үйлдвэрлэх болон мөнгө угаахыг хориглох ба шийтгэл ноогдуулах, сэжиг бүхий төлбөрийн талаар мэдээлэх, хянах боломж олгох.

Эдгээр бүх нөхцлүүд гэрээнээс илүүтэйгээр хууль тогтоомжоор зохицуулагдах хэрэгтэй.

Чек (гүйлгээний хэрэгсэл)-ийн тухай хууль:

- Чек гаргах, хүлээн авах, гүйлгээнд оруулах үйл ажиллагааг зохицуулах (эхэн үедээ нийтлэг эрх зүй (common law) эсвэл гэрээгээр зохицуулагдаж болох ч цаашид хууль тогтоомжоор зохицуулагдах ёстой) ;
- Эрүүгийн хууль эсвэл чекийн тухай хууль тогтоомжийн хэсэг болох залилангийн нөхцөл үүсэхэд төлбөр төлөгч, төлбөр хүлээн авагчийн эрх үүргийг тодорхойлох;
- Цахим чекийг төлбөрт өгөх, гүйлгээнээс татах, дүрсийг боловсруулах боломж олгох (одоо байгаа хуулийг сайжруулах хэрэгтэй байгаа учраас хууль тогтоомжоор зохицуулах нь хамгийн зохимжтой механизм).

Кредит шилжүүлгийн тухай хууль:

- Цаасан кредит шилжүүлэг болон цахилгаан сүлжээгээрх цахим шилжүүлгийг зөвшөөрөх;
- Төлбөр эцсийн байх, буруу шилжүүлсэн төлбөр, төлбөртэй холбоотой залилан, харилцагчдын мөнгөн хөрөнгийг бэлэн байлгах зэрэгтэй холбоотой асуудлыг зохицуулах (ямар нэгэн хэмжээгээр нийтлэг эрх зүй (common law) болон гэрээгээр зохицуулагддаг байж болох ч хууль тогтоомжоор зохицуулах нь тохиромжтой).

Картын хэрэгслийн тухай хууль:

- Хэрвээ одоо байгаа гэрээний хуулиар баталгаажуулаагүй бол карт гаргагч, карт эзэмшигч, картаар үйлчлэгч байгууллагын (КҮБ) эрх үүргийг зохицуулах.

Зохицуулалт нь бүхэлдээ гэрээ болон нийтлэг эрх зүй (common law)-ээр эсвэл тэдгээрийн харилцааны зарим талыг хууль тогтоомжоор зохицуулахаар байж болно (жишээ нь, харилцагчийн эрхийг хамгаалах).

Цахим төлбөрийн ба худалдааны тухай хууль:

- Цахим мөнгө гаргалт ба хэрэглээг зохицуулах;

- Хэрвээ мөнгөн тэмдэгтийн хуулиар зохицуулахаар заагаагүй бол цахим мөнгөөр хийх төлбөр тооцооны төлбөрийн үүргийг хууль зүйн дагуу гүйцэтгэхийг баталгаажуулах.

Одоо үйлчилж байгаа хуулийн зохицуулалтад цахим мөнгө хамрагдахгүй байвал ерөнхийдөө хууль тогтоомж шаардлагатай болдог.

Нотолгооны хууль:

- Дижитал гарын үсэг эсвэл цахим төлбөрийн эрх олгосон бусад төлбөрийн хэрэгслийг ашиглан цахим төлбөрийн жинхэнэ эсэхийг шалгах нотолгоогоор хангах.

Хууль, эрх зүйн баримтын зарим жишээ:

- Худалдааны нэгдмэл хууль (ХНХ/УСС): Зүйл 4А (мөнгөн хөрөнгийн автомат шилжүүлгийн тухай) (АНУ)
- Хил дамнасан кредит шилжүүлгийн тухай Европын Холбооны Удирдамж 97/5ЕС
- Мөнгөн тэмдэгтийн тухай хууль (албан ёсны валютын тухай) (Канад)
- Векселийн тухай хууль (чекийн тухай) (Канад, Их Британи)
- 21-р зуунд чекийн клиринг хийх тухай Check 21 хууль (цахим чекийн тухай) (АНУ)

2. Төлбөрийн үүргийн дагуу төлбөр тооцоо хийх талаарх хууль эрх зүйн орчин

Гэрээний хуулиас илүүтэйгээр тусгай хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай үр дүнгийн болон өмнө хүлээсэн үүргийг шинэ үүргээр орлуулах тухай хууль:

- Санхүүгийн хоёр талын гэрээ, клиринг болон төлбөр тооцооны системд төлбөрийн үр дүнгийн тооцоог зөвшөөрөх, хаалттай позицитай үед ялангуяа, төлбөрийн чадваргүй болсон нөхцөлд, бүх дүнг дайчлан ашиглах боломжоор хангах (гэрээ, өмнөх туршлагаас илүүтэйгээр хууль тогтоомжоор зохицуулах);
- Үр дүнгийн ба хаалттай позицитай журмыг зохицуулах, үр дүнгийн схемд оролцогчдын эрх үүргийг тодорхойлох (гэрээ эсвэл хууль тогтоомжоор зохицуулах);
- Төлбөрийн системд оролцогч төлбөрийн чадваргүй болсон үед төв банк эсвэл арилжааны банкин дахь төлбөр тооцооны дансыг өр төлбөрт дайчлан гүйцэтгэхээр үлдээхээс (“царцахаас”) хамгаалах.

Хэрвээ өмнө хүлээсэн үүргийг шинэ үүргээр орлуулан хэрэглэж байгаа бол үүнийг (хууль тогтоомжоор бол илүү тохиромжтой) хуулийн хүчин төгөлдөр болохыг танилцуулж байх ёстой.

Гэрээнээс илүүтэйгээр хууль тогтоомжоор зохицуулах нь тохиромжтой байдаг төлбөр тооцооны тухай хууль:

- Төлбөр тооцоо эцсийн байхыг тодорхойлох;

- Тусгайлан зааснаас бусад нөхцөлд төлбөр эцсийн болон эргэлт буцалтгүй байхыг тодорхойлох;
- Төв банкин дахь төлбөр тооцооны эрсдэлгүй дансны үлдэгдлийг “царцахаас” буюу төлбөр тооцооны данс нээсэн байгууллагын зээлдүүлэгчдэд битүүмжлүүлэхээс хамгаалах.

Хууль, эрх зүйн баримтын зарим жишээ:

- Төлбөрийн систем болон үр дүнгийн тооцооны тухай хууль (Австрали)
- Төлбөрийн системийн тухай хууль (10, 214) (Бразил)
- Төлбөр, Клиринг болон Төлбөр тооцооны тухай хууль (Канад)
- Худалдааны нэгдмэл хууль (ХНХ/UCC): Зүйл 4А (АНУ)
- Журам J, Холбооны нөөцийн систем (АНУ)
- Гишүүн орнуудын төлбөрийн системийн тухай журам 15/2002/CM/UEMOA (Баруун Африкийн эдийн засаг, валютын холбоо)
- Төлбөрийн болон үнэт цаасны төлбөр тооцооны системд төлбөр тооцоо эцсийн байх тухай Европын Холбооны Удирдамж 98/26/ЕС

3. Зээл болон барьцааны талаарх хууль эрх зүйн орчин

Зээлийн хууль:

- Худалдааны гүйлгээнд зээлдэгч-зээлдүүлэгчийн хоорондын харилцааг зохицуулах
- Нийтлэг эрх зүй (common law), гэрээний хууль, иргэний хууль эсвэл тусгай хууль тогтоомжийн хүрээнд зохицуулагддаг байж болно. (жишээ нь, мөнгө хүүлэх тухай хууль, банкны тухай хууль, зээлдэгч-зээлдүүлэгчийн харилцааны тухай хууль)

Барьцааны тухай хууль:

- Гэрээ болон нийтлэг эрх зүй (common law)-гээр зохицуулахаас илүүтэйгээр нийтлэг буюу тусгай хэрэглээний хууль тогтоомжоор зохицуулах нь илүү зохимжтой байх барьцаа хөрөнгийг тогтоох, албадан хэрэглэх;
- Төлбөрийн чадваргүй буюу үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд ижил хөрөнгөн дэх баталгаажуулсан эсвэл баталгаажуулаагүй төрөл бүрийн нэхэмжлэл дотор нэн тэргүүний дарааллыг тогтоох (нийтлэг буюу тусгай хэрэглээний хууль тогтоомж шаарддаг).

Хууль, эрх зүйн баримтын зарим жишээ:

- Худалдааны нэгдмэл хууль (ХНХ/UCC): Зүйл 9 (АНУ)
- Санхүүгийн барьцааны зохицуулалтын талаарх Европын Холбооны Удирдамж 2004/47/ЕС
- Барьцаа хөрөнгийн эрхийн тухай 1997 оны OHADA-ын нэгдмэл хууль
- Барьцаатай гүйлгээний тухай 1994 оны ЕСББ(EBRD)-ын үлгэрчилсэн хууль

- Барьцаатай гүйлгээний UNCITRAL хууль тогтоомжийн удирдамж
- Хөдөлгөөнт төхөөрөмжийн олон улсын ашиг сонирхлын талаарх Кейптауны (Cape Town) Конвенц
- Гишүүн улсуудын төлбөрийн системийн 15/2002/CM/UEMOA журам (Баруун Африкийн эдийн засаг, валютын холбоо)

4. Төлбөрийн сүлжээнд оролцох, зохион байгуулах талаарх хууль эрх зүйн орчин

Зохицуулах хууль (хууль тогтоомж, дүрэм буюу гэрээ):

- Сүлжээ буюу системийн операторын нэгдсэн удирдлага ба зохион байгуулалтын хэлбэр (өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийн эрх зүйн дүрэм);
- Сүлжээний оролцогчид, операторуудын хамтын эрх, үүрэг;
- Сүлжээнд оролцох;
- Сүлжээний ажиллагаа (цаг, шимтгэл, торгууль, мэдээ дамжуулалт, формат гэх мэт);
- АТТ буюу оролцогчид үүргээ биелүүлж чадахгүй болох;
- Үйл ажиллагааны болон санхүүгийн эрсдлийн хяналт, тасралтгүй байдал;
- Санхүүгийн алдагдал хуваах байдал.

Хууль, эрх зүйн баримтын зарим жишээ:

- CHIPS, Fedwire, CHAPS, Clearstream зэрэг бусад клирингийн болон төлбөр тооцооны системийг зохицуулах системийн дүрэм;
- Репо арилжааны ерөнхий гэрээ (Олон улсын, үнэт цаасны зах зээлийн ассоциаци)

5. Үнэт цаасны төлбөр тооцооны системийн хууль эрх зүйн орчин

(2), (3), (4)-т дурьдсан хууль эрх зүйн баримтын төрлөөс гадна:

- Үнэт цаасны хадгалагч байгууллага (дерозитор) болон бусад үнэт цаасны зуучлагчдад үнэт цаасыг цахим хэлбэрээр байршуулахад үнэт цаасыг эргэлтэд гаргахгүй байх, эзэмших, шилжүүлэх, барьцаалах талаарх зохицуулалтын хууль тогтоомж;
- Цаасан хэлбэрээс илүүтэйгээр цахим мэдээнд тусгаж буй биет бус эсвэл “гэрчилгээгүй” үнэт цаасыг гаргах, эзэмших, шилжүүлэх үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж;
- Санхүүгийн дериватив, буцаан худалдан авах гэрээ, үнэт цаасны зээл болон давуу эрхтэй үнэт цаасны кастоди, шилжүүлэг, барьцаатай холбоотой үүсэх бусад гүйлгээ зэрэг үнэт цаасны хувьд хийгдэх давуу эрхтэй гүйлгээг хүчин төгөлдөр болгох гэрээ буюу хууль тогтоомж.

Хууль, эрх зүйн баримтын зарим жишээ:

- Худалдааны нэгдмэл хууль (ХНХ/UCC): Зүйл 8, шинэчилсэн найруулга (АНУ);
- Үнэт цаасыг шууд бусаар эзэмшихтэй холбоотой бие даасан хууль дүрмийн зохицол дээр хийсэн UNIDROIT судалгааны багийн илтгэл;
- Үнэт цаасны шилжүүлгийн нэгдмэл хууль (Канадын үнэт цаасны зохион байгуулагчдаас гаргасан төсөл) (Канад)

6. Хуулийн маргаан

- Төлбөрийн системийн хил дамнасан янз бүрийн нөхцлүүдэд (жишээлбэл, гадны оролцогчид, хил дамнасан төлбөр, хил дамнасан барьцаа, гадаадын үнэт цаас) хэргийг шүүн шийдэхдээ аль хуулийг хэрэглэхийг тодорхойлсон дүрэм.
- Харилцан гэрээ болон нийтлэг эрх зүй (common law) хангалттай ч хууль тогтоомжоор зохицуулах нь илүү тохиромжтой.

Дүрмийн жишээ:

- Худалдааны нэгдмэл хууль (ХНХ/UCC): Зүйл 8, шинэчилсэн найруулга (АНУ);

Олон улсын конвенци:

- Зуучлагчаар дамжуулан эзэмшиж байгаа үнэт цаасны тодорхой эрхэд хууль хэрэглэх тухай Hague-ийн конвенци

7. Төв банкны хяналтын хууль зүйн үндэс

Хяналтын эрх мэдлийг зохицуулах хууль эрх зүйн хэрэгсэл: хууль тогтоомж; журам; гэрээ; ойлголцлын санамж бичиг.

Хяналтын эрх мэдлийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн хэрэгсэл: зохицуулалт; удирдамж; тушаал эсвэл дүрэм; заавал биелүүлэх шаардлагагүй удирдамж болон тайлбар.

Хуулийн жишээ:

- Төлбөрийн системийн зохицуулалтын тухай хууль (Австрали)
- Төлбөр, Клиринг болон төлбөр тооцооны тухай хууль (Канад).

8. Төлбөрийн системтэй холбоотой олон улсын хууль эрх зүйн стандартууд

Төлбөрийн хэрэгслийг гэмт хэрэгт ашигласан үед хэрэглэх дүрэм:

- ФАТФ – ын 40 Зөвлөмж (мөнгө угаахтай тэмцэх)
- Терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг ФАТФ – ын тусгай зөвлөмж
- Терроризмыг санхүүжүүлэхийг зогсоох Нэгдсэн Үндэстний Олон Улсын Конвенци

Дүрэм болон гэрээний үлгэрчилсэн хуулиуд:

- Олон Улсын Худалдааны Гэрээний UNIDROIT – ын Зарчмууд

- Европын Гэрээний Хуулийн Комисс: Европын Гэрээний Хуулийн Зарчмууд
- Свопын хүү, валютын своп, өргөн хэрэглээний барааны деривативууд, бусад свопын болон деривативын гүйлгээний ISDA-ын ерөнхий хэлэлцээр
- Бондын зах зээлийн холбооны үлгэрчилсэн гэрээнүүд

Төлбөрийн хэрэгслийн дүрэм болон үлгэрчилсэн хуулиуд:

- Олон улсын шилжих болон энгийн векселийн тухай UNCITRAL-ийн Конвенци
- Олон улсын кредит шилжүүлгийн тухай UNCITRAL-ийн үлгэрчилсэн хууль
- Цахим худалдааны тухай UNCITRAL-ийн үлгэрчилсэн хууль (баталгаат гарын үсэг болон цахим худалдааны гүйлгээний нотолгоотой талаар)
- Хил дамнансан кредит шилжүүлгийн тухай Европын Холбооны 97/5/ЕС Удирдамж
- Цахим худалдааны тухай Европын Холбооны 2000/31/ЕС Удирдамж
- Цахим гарын үсгийн Нийгэмлэгийн эрх зүйн үндсийн тухай Европын Холбооны 99/93/ЕС Удирдамж

Клиринг болон төлбөр тооцооны талаарх дүрэм, үлгэрчилсэн хууль:

- Төлбөрийн болон үнэт цаасны төлбөр тооцооны системд төлбөр тооцоо эцсийн байх тухай Европын Холбооны 98/26/ЕС Удирдамж
- Үнэт цаасыг шууд бусаар эзэмшихтэй холбоотой бие даасан хууль дүрмийн зохицол дээр хийсэн UNIDROIT судалгааны багийн илтгэл

Барьцааны үнэт цаасны тухай дүрэм болон үлгэрчилсэн хууль:

- Хөдөлгөөнт төхөөрөмжийн олон улсын ашиг сонирхлын талаарх Кейптауны (Cape Town) Конвенц
- Санхүүгийн барьцааны зохицуулалтын тухай Европын Холбооны 2002/47/ЕС Удирдамж
- Барьцаа хөрөнгийн эрхийн тухай 1997 оны OHADA-ын нэгдмэл хууль
- Барьцаатай гүйлгээний тухай 1994 оны ЕСББ(EBRD)-ын үлгэрчилсэн хууль
- Барьцаатай гүйлгээний тухай 2002 оны Америк тивийн үлгэрчилсэн хууль
- Барьцаатай гүйлгээний тухай UNCITRAL-ийн хууль тогтоомж

Хуулийн маргааныг зохицуулах дүрэм:

- Зуучлагчаар дамжуулан эзэмшиж байгаа үнэт цаасны тодорхой эрхэд хууль хэрэглэх тухай Hague-ийн конвенци

Хавсралт 5: Нэр томъёоны тайлбар

Нэр томъёо

Автоматжуулсан клирингийн төв
automated clearing house
(ACH)

Тайлбар

Санхүүгийн байгууллагуудын хооронд төлбөрийн даалгаврыг гол төлөв соронзон мэдээллийн хэрэгслээр эсвэл харилцаа холбооны сүлжээгээр солилцож, өгөгдөл боловсруулах төвд боловсруулж буй цахим клирингийн систем.

Автомат теллер машин
automated teller machine
(ATM)

Карт-уншигч машинаар идэвхждэг пластик картыг ашиглан данснаасаа бэлэн мөнгө авах эсвэл дансны үлдэгдэл шалгах, мөнгө шилжүүлэх буюу орлого хийх зэрэг бусад үйлчилгээг авах зорилгоор эрх бүхий хэрэглэгчдийн ашиглаж буй цахилгаанаар ажилладаг механик төхөөрөмж.

Алдагдал хуваах (хуваарилах)
тохиролцоо
loss-sharing (or loss allocation)
agreement

Системийн оролцогч эсвэл систем өөрийн үүргээ биелүүлээгүйгээс үүсэх ямар нэгэн алдагдлыг хуваах талаар клирингийн буюу төлбөр тооцооны системийн оролцогчдын хооронд байгуулсан тохиролцоо.

Арилжааны төв түнш
central counterparty (CCP)

Тодорхой бирж эсвэл биржүүд дээр хийгдэж байгаа гэрээ зэрэг тусгайлан байгуулсан гэрээний үндсэн дээр бүх худалдагчийн хувьд худалдан авагч, бүх худалдан авагчийн хувьд худалдагч болдог байгууллага.

Бага дүнтэй төлбөр
retail payment

Төрөл бүрийн харилцагч, аж ахуйн нэгж, засгийн газрын байгууллагуудын хооронд

**Бага дүнтэй төлбөрийн дэд бүтэц
retail payment infrastructure**

хийгдэж буй харьцангуй бага дүнтэй, яаралтай бус төлбөр. Энэ нь их дүнтэй төлбөрийн тодорхойлолтод багтдаггүй төлбөр.

**Багц
batch**

Чек, кредит шилжүүлэг, шууд дебит, төлбөрийн карт зэрэг төлбөрийн хэрэгслүүдээр үүсгэгдсэн харьцангуй бага дүнтэй, яаралтай бус төлбөрүүдийг шилжүүлэх, клиринг, төлбөр тооцоо хийхэд хэрэглэгддэг механизмууд.

**Банкны систем
banking system**

Хугацааны тодорхой интервалд багцлагдсан бүлэг төлбөрийн даалгаврууд болон/эсвэл үнэт цаасны шилжүүлгийн даалгавруудын боловсруулалт эсвэл дамжуулалт.

**Барьцаа хөрөнгө
collateral**

Бусдаас хөрөнгийг татан төвлөрүүлж, зээл олгох болон/эсвэл үндсэн үүргийнхээ хүрээнд хэрэглэгчдэд төлбөрийн үйлчилгээг шууд хүргэдэг бүх санхүүгийн байгууллагууд. Төв банк хамаарна.

**Баталгаа
confirmation**

Барьцаалуулагчийн хүлээсэн үүргийн баталгаа болж буй, барьцаалагчийн хүлээн зөвшөөрсөн хөрөнгө эсвэл гуравдагч этгээдийн амлалт.

**Бодит цагийн шилжүүлэг
real-time transfer**

Зах зээлийн оролцогч нь эсрэг талууд эсвэл харилцагчдадаа хийгдсэн арилжааны талаар мэдэгдэж, тэдгээрт арилжааны талаар асуулга тавих буюу хүлээн зөвшөөрөх хугацаа олгох процесс.

**Зээлийн эрсдэл
credit risk**

Мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны шилжүүлгийн даалгаврыг үүсгэсэн тухай бүрт хийж буй боловсруулалт, дамжуулалт, төлбөр тооцоо.

Төлбөр тооцооны системд оролцогч түнш тухайн үед эсвэл ирээдүйд төлбөрийн үүргээ бүтэн дүнгээр биелүүлэх боломжгүй болохтой холбогдон гарах эрсдэл. Хөрөнгийн дүнгээр

солилцох системүүд (exchange-for-value systems)-ийн хувьд энэхүү эрсдэл нь солилцох зардлын эрсдэл болон үндсэн дүнгийн эрсдлийг багтаадаг.

**Кастоди
custody**

Бусад этгээдийн нэрийн өмнөөс үнэт цаас болон санхүүгийн хэрэгслийг хадгалах болон зохицуулах ажиллагаа.

**Их дүнтэй төлбөр
large-value payment**

Банкуудын хооронд эсвэл санхүүгийн зах зээлд оролцогчдын хооронд солилцож буй гол төлөв яаралтай ба цаг тухайд нь төлбөр тооцоог хийхийг шаарддаг маш их дүнтэй төлбөр.

**Их дүнтэй төлбөрийн систем
large-value payment system**

Их дүнтэй төлбөрүүдийг боловсруулж буй систем.

**Клиринг
clearing/clearance**

Төлбөрийн даалгавар буюу үнэт цаасны шилжүүлгийн даалгаврын дамжуулалт, хуваарилалт болон зарим тохиолдолд төлбөр тооцоо хийгдэхийн өмнөх баталгаажуулалтын процесс. Энэ процессод төлбөрийн даалгаврын үр дүн болон төлбөр тооцооны хаалтын позицийг тодорхойлох ажиллагаа багтаж болно. Зарим үед (оновчтой бус ашиглалтад) энэ нэр томъёонд төлбөр тооцоог багтаан ашигладаг.

**Корреспондент банк
correspondent banking**

Нэг банк (корреспондент) нь өөр банкуудын (респондент) мэдлийн татан төвлөрүүлсэн хөрөнгийг байршуулан, тэдгээрт төлбөрийн болон бусад үйлчилгээ үзүүлэх тохиролцоо. Энэхүү тохиролцоог зарим үед дотоодын нөхцөлд агентын харилцаа холбоо гэдэг. Гадаадын банкуудын хувьд респондент банкны дансны үлдэгдлийг гадаад валютын арилжааны гүйлгээг хийхэд ашиглаж болдог. Харилцан корреспондент банкуудын харилцаа нь гадаад валютын арилжааны гүйлгээг хийхэд ностро болон востро гэгдэх дансуудыг ашиглахтай хамаатай байж болно.

**Материаллаг бус болгох
dematerialization**

Үнэт цаасны эзэмшлийг төлөөлж буй эрхийн бичиг болох биет гэрчилгээ буюу баримтыг халж, ингэснээр үнэт цаасыг зөвхөн бүртгэлийн бичилтийн үндсэн дээр гэрчлэх үйл ажиллагаа.

**Нэвт боловсруулалт
straight through processing
(STP)**

Баталгаажуулалтын, тохируулалтын, үүсгэлтийн, клирингийн, төлбөр тооцооны даалгаврын автомат гүйцээлтүүдийг агуулсан арилжаа буюу төлбөрийн шилжүүлгийн автоматжуулсан шууд боловсруулалт.

**Нэгбүрчилсэн төлбөр
тооцооны систем
gross settlement system**

Мөнгөн хөрөнгийн буюу үнэт цаасны шилжүүлгийн даалгаврын төлбөр тооцоо нэг бүрээр (шилжүүлгийн даалгавар тус бүрээр) хийгдэх шилжүүлгийн систем.

**Оролцогч түнш
counterparty**

Үнэт цаасны арилжаа эсвэл своп хэлцэл зэрэг санхүүгийн гүйлгээнд оролцож буй эсрэг тал.

**Өдөр дундын зээл
intraday credit**

Нэг ажлын өдрөөс бага хугацаанд олгогдох зээл. Өдрийн эцэст сүүлчийн төлбөр тооцоог хийдэг кредит шилжүүлгийн системд өдөр тутмын зээл нь хэрвээ ажлын өдрийн эцэс хүртэл сүүлчийн хөрөнгийг хүлээн авч чадахгүй байхаар байсан ч төлбөрийн даалгаврыг хүлээн авч, гүйцэтгэж байгаа л бол автоматаар сунгагддаг. Үүнээс гадна энэхүү зээлийг өдрийн овердрафт (daylight overdraft), өдрийн нээлттэй позици (daylight exposure), өдрийн зээл (daylight credit) гэж нэрлэдэг.

**Өдрийн төлбөр
түргэн гүйцэтгэх чадвар
intraday liquidity**

Ихэвчлэн санхүүгийн байгууллагууд бодит цагт төлбөр гүйцэтгэхийн тулд ажлын өдрийн туршид ашиглаж болох хөрөнгө.

**Системийн хувьд нэн чухал
төлбөрийн систем
systemically important
payment system**

Хэрэв систем нь дотооддоо эрсдэл, саатлаас хангалттай бус хамгаалагдсан бол энэ байдал цаашлаад оролцогчдын дундын саатал эсвэл санхүүгийн илүү өргөн хүрээнд системийн саатлыг үүсгэх буюу дамжуулахуйц төлбөрийн системийг системийн хувьд нэн чухал төлбөрийн систем гэнэ.

**Системийн эрсдэл
systemic risk**

Шилжүүлгийн системийн буюу санхүүгийн зах зээлийн нэг оролцогч ерөнхийдөө хүлээсэн үүргээ биелүүлэх чадваргүй болсноос шалтгаалж тухайн үед бусад оролцогчдыг эсвэл санхүүгийн байгууллагуудыг үүргээ (шилжүүлгийн системийн төлбөр тооцооны үүргийг оролцуулан) гүйцэтгэх боломжгүй болгохтой холбоотой эрсдэл. Нэг оролцогчийн дампуурал нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвар эсвэл зээлийн томоохон асуудлыг үүсгэж, цаашлаад энэ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх боломжтой байдаг.

**Сүлжээний ажиллагаа
network operations**

Сүлжээний ажиллагаатай холбоотой (жишээ нь, ажиллах цаг, шимтгэл, торгууль, мэдээний дамжуулалт, формат гэх мэт) бүхий л процесс болон зохицуулалт.

**Тасралтгүй байдал
business continuity**

Хэрвээ системийн нэг буюу түүнээс олон бүрэлдэхүүн хэсэг гэмтэхэд эсвэл гадаад хэвийн бус үйл явдал нөлөөлөхөд үйлчилгээний байвал зохих төвшнийг хангахыг батлах зорилго бүхий төлбөрийн системийн төлөвлөлт. Энэ нь болзошгүй нөхцлийг шийдэх зохицуулалт болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг багтаасан байна.

**Төв банкны зээл
(төлбөр түргэн гүйцэтгэх
чадварын)
central bank credit (liquidity)
facility**

Төв банкинд тодорхой данс эзэмшигчдийн (тухайлбал, банкууд) ашиглаж болох байнгын зээл. Энэ зээл нь зарим тохиолдолд данс эзэмшигчийн хүсэлтээр автоматаар ашиглагддаг ч бусад тохиолдолд төв банк үзэмжээрээ тогтоож болдог. Энэхүү зээлийг ихэвчлэн нэг бол үнэт цаас барьцаалан (Европын зарим орнуудад ломбардын зээл гэдэг) данс эзэмшигчийн харилцах дансанд зээллэг буюу овердрафт хэлбэртэйгээр эсвэл векселийг буцаан худалдан авах уламжлалт хэлбэрээр авч болно.

**Төлбөр
payment**

Төлбөр хүлээн авагч талд хүлээн зөвшөөрөгдөхүйц төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгийн шилжүүлэг. Ерөнхийдөө мөнгөн хөрөнгө нь мөнгөн тэмдэгт эсвэл санхүүгийн байгууллага буюу төв банкинд байршуулсан татан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдлийн хэлбэртэй байж болно.

**Төлбөр тооцоо
settlement**

Хоёр болон түүнээс дээш талуудын хооронд хөрөнгө эсвэл үнэт цаас шилжүүлэх үүргийг гүйцэтгэх үйлдэл.

**Төлбөр тооцооны эрсдэл
settlement risk**

Шилжүүлгийн системд төлбөр тооцоо хүлээгдэж байснаар хийгдэхгүй болох үед гарах эрсдлийг тодорхойлдог ерөнхий нэр томъёо. Энэхүү эрсдэл нь зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдлийг хоёуланг нь агуулдаг.

**Төлбөрийн
чадварын эрсдэл
liquidity risk**

Төлбөр тооцооны системд оролцогч түнш төлбөрийн үүргээ тухайн үед бүтэн дүнгээр нь биелүүлэх боломжгүй болсон үед үүсэх эрсдэл. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл нь

оролцогч түнш (төлбөрийн системийн оролцогч)-ийг төлбөрийн чадваргүй болсон гэдэг утгыг агуулдаггүй. Учир нь хожим тодорхой бус хугацааны дараа оролцогч түнш шаардлагатай өр төлбөрийн үүргээ биелүүлэх боломжтой болж болдог.

**Төлбөрийн даалгавар
payment order (instruction)**

Төлбөр хүлээн авагчид мөнгөн хөрөнгийг (аль нэг талын мөнгөний нэхэмжлэлийн хэлбэрээр) шилжүүлэхийг хүссэн мэдээ буюу даалгавар. Даалгавар нь кредит эсвэл дебит шилжүүлэгтэй холбоотой байж болно.

**Төлбөрийн дэд бүтцийн үйлчилгээ
payment infrastructure service**

Төлбөрийн хэрэгслүүдийг хүлээн авах, шилжүүлэх болон холбогдох төлбөрүүдийн боловсруулалт, клиринг, төлбөр тооцоог хийх зорилго бүхий дэд бүтцүүдийн үзүүлж буй үйлчилгээ.

**Төлбөрийн дэд бүтэц
payment infrastructure**

Төлбөрийн хэрэгслүүдийг хүлээн авах, шилжүүлэх болон холбогдох төлбөрүүдийн боловсруулалт, клиринг, төлбөр тооцоог хийх зорилго бүхий нийт сүлжээний төхөөрөмж, технологи, заавар журмууд.

**Төлбөрийн систем
payment system**

Мөнгөний эргэлтийг баталгаажуулж буй банк хоорондын хөрөнгийн шилжүүлгийн систем (жишээ нь, клирингийн болон төлбөр тооцооны), банкны журмууд болон арга хэрэгслийн тусгай иж бүрдэл.

**Төлбөрийн үйлчилгээний
зах зээлүүд
payment service markets**

Төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээг боловсруулах, үнэ тогтоох, төлбөрийн үйлчилгээг үйлчилгээ үзүүлэгчээс хэрэглэгчид хүргэх ажиллагааг зохицуулах зорилготой зохион байгуулалтын хэлбэрүүд. Тусгай зах зээлүүд нь өвөрмөц зах зээлийн практик, үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгч, энэхүү өвөрмөц үйлчилгээний эрэлт болон нийлүүлэлтэд

**Төлбөрийн эсрэг нийлүүлэлт
delivery versus payment**

нөлөөлж буй хүчин зүйл зэргээр тодорхойлогдож байдаг.

**Урьд хүлээсэн үүргийг шинэ
үүргээр солих
novation**

Зөвхөн төлбөр хийгдсэн нөхцөлд л нийлүүлэлт хийгдэхийг баталгаажуулдаг, үнэт цаасны систем болон мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн системүүдийн хоорондын холбоос.

**Үйл ажиллагааны эрсдэл
operational risk**

Одоо байгаа талуудын эсвэл орлогч талуудын хооронд өмнө хүлээсэн үүргийг хуулийн ёсны, шаардлага хангахуйц шинэ үүргээр солих ажиллагаа.

**Үндсэн дүнгийн эрсдэл
principal risk**

Мэдээллийн систем эсвэл дотоод хяналтын хангалтгүй байдлаас урьдчилан таамаглагдаагүй алдагдалд хүргэх эрсдэл.

**Үндэсний төлбөрийн систем
national payment system**

Үнэт цаас арилжаалагч нь үнэт цаасаа шилжүүлсэн боловч төлбөрөө хүлээж аваагүй эсвэл үнэт цаас худалдан авагч төлбөрөө хийсэн боловч үнэт цаасаа хүлээн аваагүй үед үүсэх эрсдэл. Энэ тохиолдолд үнэт цаасны буюу мөнгөн шилжүүлгийн үндсэн дүн эрсдэлд учирна.

**Үнэт цаасны дэд бүтэц
securities infrastructure**

Төв банк болон арилжааны банкны төлбөрийн үүргийн хэлбэртэй мөнгөний нэхэмжлэлийг үүсгэх болон шилжүүлэх зорилго бүхий санхүүгийн систем дэх эрх зүйн болон дэд бүтцийн зохицуулалт.

**Үнэт цаасны систем
securities system**

Үнэт цаасны гүйлгээний баталгаажуулалт, клиринг, төлбөр тооцоо болон үнэт цаасны арилжаа, бүртгэл, кастодийн үйлчилгээ зэрэгт зориулсан зохион байгууллын бүхэл цогц.

Үнэт цаас гаргах болон удирдах, гаргасан үнэт цаасыг хадгалах болон зохицуулах, түүнчлэн үнэт цаасны гүйлгээг үүсгэх, баталгаажуулах,

тулгах, шилжүүлэх, төлбөр тооцоог хийх дэд бүтцүүдийн болон эрх зүйн зохицуулалт.

**Үнэт цаасны төвлөрсөн
хадгаламжийн төв (ҮЦТХТ)
central securities depository (CSD)**

Үнэт цаасны шилжүүлгийг биет бус хэлбэрээр боловсруулах бололцоотойгоор үнэт цаасыг хадгалж буй байгууллага. Биет үнэт цаасыг хадгаламжийн төв нь эргэлтэд оруулалгүй байлгаж эсвэл үнэт цаасыг материаллаг бус (өөрөөр хэлбэл, үнэт цаас нь зөвхөн цахим бичилтийн үндсэн дээр оршино) болгож болно. Хадгалах үүргээс гадна ҮЦТХТ нь хэлцэл биелсэн эсэхийг мэдээлэх, клиринг, төлбөр тооцоо хийх үүргийг гүйцэтгэж болно.

**Үр дүнгийн тооцоолол
netting**

Төлбөрийн системийн оролцогч буюу арилжааны түншүүдийн хоорондын төлбөрийн үүрэг буюу позицийг харилцан суутгах тохиролцоо. Үр дүнгийн тооцоо нь олон тооны нэгбүрчилсэн позици буюу үүргийг цөөн тооны позици буюу үүрэг болгон цөөрүүлдэг. Нэг оролцогч үүргээ гүйцэтгэж чадахгүй болоход хуулийн албадан гүйцэтгэх янз бүрийн зэрэг байдгаас үр дүнгийн тооцооны хэд хэдэн хэлбэр байна.

**Үр дүнгийн төлбөр тооцооны систем
net settlement system**

Төлбөрийн даалгавар бүрийн банк хоорондын эцсийн төлбөр тооцоо ажлын өдрийн турш нэг буюу хэд хэдэн удаа тодорхой цагт хийгддэг төлбөр тооцооны систем.

**Хадгалагч (депозитор)
depository**

Үнэт цаасны биет болон цахим бүртгэлийг хийх, эдгээр үнэт цаасны эзэмшлийн бүртгэлийг хадгалах үндсэн үүрэг бүхий агент.

**Хандалт
access**

Харилцагчийн болон өөрийн дансаар төлбөр тооцоог гүйцэтгэхдээ тодорхой төлбөрийн системийн үйлчилгээг ашиглах байгууллагын эрх буюу боломж.

**Харилцан ажиллах боломж
interoperability**

Тухайн системд хамаарал бүхий төлбөрийн хэрэгсэл нь өөр системийн суурилуулсан төхөөрөмжид ашиглагдах боломжтой байх нөхцөл. Харилцан ажиллах боломж нь системүүдийн хооронд техникийн зохицлыг шаардах боловч зөвхөн тухайн системүүдийн хооронд арилжааны буюу үйлчилгээний хэлэлцээр байгуулсан нөхцөлд л үйлчилж эхэлдэг.

**Холбогдох этгээд
stakeholder**

Төлбөрийн системд холбогдох этгээд гэдгийг системийн ажиллагаа нь ашиг сонирхолд нь нөлөө үзүүлдэг талууд гэж тодорхойлдог.

**Хууль зүйн эрсдэл
legal risk**

Хууль буюу журмыг буруугаар хэрэглэснээс эсвэл гэрээнд заагдаагүй нөхцөл байдлаас шалтгаалан үүсэх эрсдэл.

**Хэрэглэгч
user**

Төлбөрийн системийн хэрэглэгч гэж дэд бүтцийн сүлжээний эрх зүйн оролцогчид болон эцсийн хэрэглэгчийн зах зээл дэх төлбөрийн төрөл бүрийн үйлчилгээг шаардаж, хэрэглэдэг тэдгээрийн харилцагчдыг багтаасан байгууллага.

**Хяналт
oversight**

Одоо байгаа болон төлөвлөж буй системд мониторинг хийх, зорилготой нь харьцуулан тэднийг үнэлэх, зайлшгүй тохиолдолд өөрчлөлтийг дэмжих замаар төлбөрийн болон төлбөр тооцооны системийн найдвартай, үр ашигтай байдлыг хангах зорилго бүхий төв банкны үүрэг.

**Эргэлтэд оруулахгүй байх
immobilisation**

Үнэт цаасны болон санхүүгийн хэрэгслийн биет гэрчилгээг ҮЦТХТ-д байршуулах ажиллагаа. Үүний дүнд дараагийн шилжүүлгүүдийг цахим бүртгэлийн үндсэн дээр хийх боломжтой болно.

Эрх зүйн зохицуулалт
institutional arrangements

Санхүүгийн болон бусад байгуулагуудаас төлбөрийн төрөл бүрийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх зохион байгуулалтын тохиролцоо ба хэрэглээ. Үүнд зах зээлийн зохицуулалт, хууль зүйн болон зохицуулалтын тогтолцоо, үндэсний төлбөрийн системд холбогдох этгээдүүдийн хоорондын зохицох болон зөвшилцөх механизм зэргийг оруулна.

Эцсийн байх
finality

Үл буцаагдах болон нөхцөлт бус байдал.

Эцсийн хэрэглэгч
end user

Арилжааны буюу санхүүгийн гүйлгээг гүйцэтгэх зорилгоор төлбөрийн хэрэгсэл болон үйлчилгээ үзүүлж буй санхүүгийн байгууллагын харилцагч.

Хавсралт 6: Ажлын хэсгийн гишүүд

Төлбөр тооцооны системийн хороонд энэхүү тайланг дараахь нэр дурдсан гишүүд бүхий ажлын хэсгийн тусламжтайгаар бэлтгэсэн болно.

Дарга (Канадын төв банк)	Шон О'Коннор
Бразилийн төв банк	Луסיано Андраде Фройс
Канадын банк	Моник Менар, Роберт Тернбулл
Хятадын ардын банк	Сонг Пан
Колумбийн улсын банк	Хоакин Берналь
Европын төв банк	Том Коккола Жан-Мишель Годффруа (2004 оны 9 сар хүртэл)
Францын банк	Кристин Сампик Жаклин Лакост (2004 оны 7 сар хүртэл)
Дойче Бундесбанк	Маркус Гросс
Индонезийн банк	Диа Н.К. Махияни
Италийн банк	Паола Джукка
Японы банк	Akiko Kobayashi Tomohiro Usui (2004 оны 7 сар хүртэл)
Казахстан Улсын Үндэсний банкны банк хоорондын төлбөр тооцооны төв	Александр Шишлов
Оросын Холбооны төв банк	Николай Геронин
Өмнөд Африкийн нөөцийн банк	Дэвид Митчелл
Шри Ланкийн төв банк	Рани Джаямаха
Тринидад болон Тобагогийн төв банк	Карамей Фармер
Нью Йоркийн Холбооны Нөөцийн банк	Лоренс М. Свит
Холбооны нөөцийн системийн ерөнхийлөгчдийн зөвлөл	Дженифер Люсьер Яо-Чин Чао (2005 оны 6 сар хүртэл)

Баруун Африкийн Улсуудын төв банк (ВСЕАО)	Мануэль Рубиральта (2004 оны 3 сар хүртэл)
Олон Улсын Валютын Сан	Фатимату Захра Диоп
Дэлхийн Банк	Жан Вольтьер
Нарийн бичгийн дарга (Олон улсын төлбөр тооцооны банк)	Массимо Чиразино, Марио Гвадамийас
	Бенджамин Ханссенс

Түүнчлэн Африкийн төв банкуудын холбооны төлбөрийн системийн семинар, Арабын төв банкуудын төлбөрийн долоо хоног, ТУХН-ийн төлбөрийн долоо хоног, Төлбөр тооцооны системийн хороо (CPSS) - Өмнөд Африкийн хөгжлийн нийгэмлэг (SADC)-ийн төлбөрийн конференци, Төв Америкийн валютын зөвлөл (СМСА)-ийн Зөвлөлдөх ажлын хэсгийн уулзалт, CPSS – Хар тэнгисийн бүсийн төлбөрийн курс, Төв болон Зүүн Европ (ICCI)-ын төлбөрийн конференци, Зүүн Өмнөд Азийн Орнуудын Төв Банкуудын Холбооны (SEACEN) Төлбөрийн газрын захирлуудын болон Бөмбөрцгийн өрнөд хагасын төлбөрийн долоо хоног зэрэгт оролцогчид хувь нэмрээ оруулсан билээ. Хэлэлцүүлгийн хугацааны туршид төв банкууд, төлбөрийн байгууллагууд болон сонирхогч талууд хэрэгтэй саналууд оруулж байлаа.